

**БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2026 оны 06 дугаар сарын 17-ны өдөр, Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл:	1-27
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	28-74
1. Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2026.05.21-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	29-58
2. Ойн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ нарын 18 гишүүн 2026.06.04-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	58-66
3. “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2026.03.17-ны өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	66-71
4. Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай нарын 10 гишүүн 2025.06.19 -ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	71-72
5. Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Хөдөө аж ахуйн тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/	72-74

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы
Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны
06 дугаар сарын 17-ны өдөр /Лхагва гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дарга Б.Бейсен ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 29 гишүүнээс 15 гишүүн хүрэлцэн ирж, 51.7 хувийн ирцтэйгээр хуралдаан 16 цаг 55 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

Томилолттой: Д.Амарбаясгалан, С.Лүндэг, М.Мандхай, С.Одонтуяа, Ц.Туваан, А.Ундраа;

Чөлөөтэй: Н.Алтаншагай, С.Амарсайхан, Б.Батцэцэг, Ж.Бат-Эрдэнэ, С.Ганбаатар, Х.Ганхуяг;

Эмнэлгийн чөлөөтэй: Р.Сэддорж.

Нэг.Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2026.05.21-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд Ц.Сандаг-Очир, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ш.Батбаяр, мөн яамны Хуулийн хэлтсийн дарга Х.Мөнхзул, Тусгай хамгаалалттай газар нутгийн бодлогын газрын ахлах шинжээч Ц.Мөнхбат, Бодлого, төлөвлөлтийн газрын ахлах шинжээч А.Нарангаравуу, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Мал аж ахуйн бодлогын газрын дарга Л.Чой-Иш, мөн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын ахлах шинжээч Ц.Мөнхнасан, Эдийн засаг, хөгжлийн яамны Ногоон санхүүжилтийн бодлогын хэлтсийн дарга С.Пүрэвсүрэн, Сангийн яамны Санхүүгийн зах зээл, олон улсын хамтын ажиллагааны хэлтсийн ахлах шинжээч Х.Номин, Цаг уур, орчны шинжилгээний газрын дарга Э.Баттулга, Газарзүй, геоэкологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан Д.Дагвадорж, Уур амьсгалын ногоон сангийн үндэсний зохицуулагч Д.Одхүү, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөрийн хамтран хэрэгжүүлж буй Нүүрстөрөгчийн зах зээлийн бэлэн байдлыг бэхжүүлэх төслийн хуулийн зөвлөх Б.Номун нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, зөвлөх П.Хулан, референт Б.Бадралт, Ц.Рэнцэнтогтох, Б.Энхгэрэл, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны зөвлөх М.Отгон нар байлцав.

Хуулийн төслийн талаарх тусгайлсан ажлын хэсгийн саналыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Э.Болормаа танилцуулав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаясгалан, Б.Бат-Эрдэнэ, Ц.Мөнхбат, Д.Батбаяр нарын тавьсан асуултад

ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Э.Болормаа, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд Ц.Сандаг-Очир, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ш.Батбаяр, Эдийн засаг, хөгжлийн яамны Ногоон санхүүжилтийн бодлогын хэлтсийн дарга С.Пүрэвсүрэн, Уур амьсгалын ногоон сангийн үндэсний зохицуулагч Д.Одхүү нар хариулж, тайлбар хийв.

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан ажлын хэсгийн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Б.Бейсен: 1.Улсын Их Хурлын гишүүн Э.Болормаа, Б.Батбаатар, Н.Батсүмбэрэл, С.Ганбаатар, П.Наранбаяр, С.Одонтуяа, П.Сайнзориг, Ч.Ундрэм, С.Эрдэнэбат /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийн “бодлого,” гэснийг, мөн хэсгийн “бүртгэл” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 6
Бүгд: 16
62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “Байгаль орчныг хамгаалах тухай хууль,” гэсний дараа “Агаарын тухай хууль,” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 6
Бүгд: 16
62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсгийн “төр,” гэсний дараа “иргэн,” гэж нэмэх, мөн хэсгийн “эрх, үүрэг, тэдгээрийн уялдаа холбоог хангахтай холбогдсон” гэснийг “эрх, үүргийг зохицуулсан” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 6
Бүгд: 16
62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалтыг, 4.1.3 дахь заалтын “нэг ижил” гэснийг, 4.1.5 дахь заалтын “, болон сайн дурын санаачилгыг хэрэгжүүлэх” гэснийг, 4.1.12 дахь заалтын “Парисын хэлэлцээрийн 6 дугаар зүйлийн дагуу” гэснийг, 4.1.13 дахь заалтыг, 4.1.15 дахь заалтын “зорилгоор ашигладаг” гэснийг, 4.1.16 дахь заалтыг, 4.1.21 дэх заалтын “бодлого,” гэснийг, 4.1.25, 4.1.27 дахь заалтыг, 4.1.30 дахь заалтын “Парисын хэлэлцээрийн 6 дугаар зүйлийн хүрээнд” гэснийг, мөн заалтын “тохируулга хийж” гэснийг, 4.1.40 дэх заалтыг тус тус хасаж, 4.1.3 дахь заалтын “шингээлт, эсхүл” гэснийг “шингээх үйл ажиллагаанаас үүссэн” гэж, 4.1.4 дэх заалтын “тогтвортой” гэснийг “арга хэмжээ” гэж, 4.1.6 дахь заалтын “зах зээлийн тогтолцоо” гэснийг “зах зээлийг” гэж, 4.1.14 дэх заалтын “шингээсэн” гэснийг “хүлэмжийн хийн шингээлтийг нэмэгдүүлсэн” гэж,

4.1.15 дахь заалтын “шаардлагаас” гэснийг “үүргээс” гэж, 4.1.28 дахь заалтын “нэмэр” гэснийг “нэмрийн зорилт” гэж тус тус өөрчилж, 4.1.6 дахь заалтын “худалдах,” гэсний дараа “арилжих, дүйцүүлэх” гэж, 4.1.9 дэх заалтын “үзүүлэлтэд” гэсний дараа “нийцсэн уур амьсгалын санхүүжилтийг хамарсан” гэж, 4.1.20 дахь заалтын “үйлдвэрлэл,” гэсний дараа “үйлчилгээ,” гэж, 4.1.28 дахь заалтын “зохицох” гэсний дараа “даван туулах” гэж, 4.1.30 дахь заалтын “нэмж” гэсний дараа “, эсхүл” гэж, 4.1.32 дахь заалтын “бусад хий” гэсний өмнө “олон улсын гэрээ, стандартаар хүлэмжийн хий гэж хүлээн зөвшөөрөгдсөн” гэж, 4.1.33 дахь заалтын “ой,” гэсний дараа “бэлчээр” гэж тус тус нэмж, мөн зүйлийн 4.1.2, 4.1.7, 4.1.8, 4.1.10, 4.1.11, 4.1.17, 4.1.19, 4.1.22, 4.1.24, 4.1.26, 4.1.31, 4.1.36, 4.1.37, 4.1.38, 4.1.39 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.1.2.“даван туулах” гэж уур амьсгалын өөрчлөлт, аюулт үзэгдэл тулгарахад байгаль орчин, нийгэм, эдийн засгийн тогтолцоо үндсэн чиг үүрэг, өвөрмөц чанар, бүтцээ хадгалан хариу үйлдэл үзүүлэх, сэргээн зохион байгуулагдах, дасан зохицох чадавхыг;

4.1.7.“карбон кредит” гэж эзэмших, ашиглах, захиран зарцуулах боломжтойгоор баталгаажсан, бүртгэгдсэн карбон нэгжийг;

4.1.8.“карбон нэгж” гэж сааруулалтын үр дүнг нэг тонн нүүрстөрөгчийн давхар ислийн тэнцэлд дүйцэх байдлаар илэрхийлсэн тооцооллын нэгжийг;

4.1.10.“ногоон таксономи” гэж эдийн засгийн үйл ажиллагаа, төсөл, хөтөлбөр, арга хэмжээг байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэхгүй байдлаар нь ангилах, ногоон болон уур амьсгалын санхүүжилтэд хамрагдахыг тодорхойлсон шалгуур, ангиллыг;

4.1.11.“олон талт карбон зах зээл” гэж олон улсын гэрээ, шийдвэрийн хүрээнд төвлөрсөн зохицуулалтаар хэрэгжих, олон улсад шилжүүлэн тооцох сааруулалтын үр дүнг бий болгох, бүртгэх, шилжүүлэх, худалдах, арилжих, дүйцүүлэх, ашиглах үйл ажиллагааг зохицуулсан зах зээлийг;

4.1.17.“уур амьсгалын өөрчлөлт” гэж байгалийн хүчин зүйл, хүний үйл ажиллагааны улмаас дэлхийн агаар мандлын хийн бүрэлдэхүүн өөрчлөгдсөнөөс үүдэн уур амьсгалд урт хугацаанд гарч буй өөрчлөлтийг;

4.1.19.“уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөлд өртөмтгий хүн амын бүлэг” гэж уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөлөлд өртөх эрсдэлтэй, нийгэм, эдийн засаг, эрүүл мэнд, газар зүйн байршлын улмаас түүнд дасан зохицох, даван туулах чадавх хязгаарлагдмал хүн амын бүлгийг;

4.1.22.“уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөлөл” гэж уур амьсгалын өөрчлөлтийн улмаас хүний эрүүл мэнд, байгаль орчин, нийгэм, эдийн засгийн үйл ажиллагаанд үзүүлэх сөрөг өөрчлөлтийг;

4.1.24.“уур амьсгалын санхүүжилт” гэж уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох үйл ажиллагааг дэмжихэд чиглэсэн олон улсын, үндэсний болон орон нутгийн түвшинд төр, хувийн хэвшил, бусад эх үүсвэрээс бүрдсэн хөрөнгө оруулалт, санхүүжилтийг;

4.1.26.“үндэсний карбон зах зээл” гэж үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилтыг хангах хүрээнд хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, ялгарахаас урьдчилан сэргийлэх, шингээлтийг нэмэгдүүлэх үйл ажиллагааны үр дүнд үүссэн карбон кредитийг бүртгэх, шилжүүлэх, худалдах, арилжих, дүйцүүлэх, ашиглах замаар зохицуулсан зах зээлийг;

4.1.31.“хоёр талт карбон зах зээл” гэж улс хоорондын хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжих олон улсад шилжүүлэн тооцох сааруулалтын үр дүнг бий болгох, бүртгэх, шилжүүлэх, худалдах, арилжих, дүйцүүлэх, ашиглах үйл ажиллагааг зохицуулсан зах зээлийг;

4.1.36.“хүлэмжийн хийн ялгарлаас урьдчилан сэргийлэх” гэж тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлээгүй тохиолдолд үүсэх байсан хүлэмжийн хийн ялгарлаас зайлсхийхэд чиглэсэн үйл ажиллагааг;

4.1.37.“хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах” гэж хүлэмжийн хийн ялгарлын хэмжээг багасгахад чиглэсэн үйл ажиллагааг;

4.1.38.“хүлэмжийн хийн ялгарлын тэнцэл” гэж тайлант хугацаанд үүссэн хүлэмжийн хийн нийт ялгарлаас бууруулалт, урьдчилан сэргийлсэн ялгарал болон шингээлтийг хасан гарах цэвэр дүнг;

4.1.39.“хэмжилт, тайлагнал, баталгаажуулалт” гэж хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, урьдчилан сэргийлэх, шингээлтийг нэмэгдүүлэх үйл ажиллагааны үр дүнг батлагдсан аргачлалын дагуу хэмжих, үр дүнг тайлагнах, тайлагнасан мэдээллийг хөндлөнгийн итгэмжлэгдсэн этгээдээр шалгуулан баталгаажуулах үйл ажиллагааг;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 7

Бүгд: 16

56.3 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйлийн 5.1.3 дахь заалтын “салбар,” гэсний дараа “хүн амын” гэж нэмэх, 5.1.5 дахь заалтын “шинжлэх ухаанд үндэслэх” гэснийг “шинжлэх ухаан, инновацад суурилах” гэж, 5.1.9 дэх заалтын “мэдлэг, инновацад суурилсан дэвшилтэт технологийг” гэснийг “мэдлэгийг” гэж тус тус өөрчилж, 5.1.6 дахь заалтыг, 5.2 дахь хэсгийг тус тус хасаж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 5.1.1 дэх заалт нэмэх:

“5.1.1.эдийн засгийн үр ашигтай байх;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 7

Бүгд: 16

56.3 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 6 дугаар зүйлийн 6.1.3 дахь заалтын “олон улсын өмнө хүлээсэн үүргийн хүрээнд боловсруулах тайлан, илтгэлийг

танилцах” гэснийг “тайлан, илтгэлийг сонсож, хэлэлцэх” гэж өөрчилж, мөн зүйлийн 6.1.4 дэх заалтын “бүрэн эрх” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 7
Бүгд: 16

56.3 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалтын “нэмэр” гэснийг “нэмрийн зорилт” гэж, 7.1.5 дахь заалтын “хөтөлбөрийг тодорхойлсон” гэснийг “хөтөлбөрт зориулсан” гэж, 7.1.9 дэх заалтын “санхүүжилтийн орлогын урсгалыг” гэснийг “санхүүжилтийг” гэж, 7.1.10 дахь заалтын “ажиллагааг удирдах зохицуулах” гэснийг “ажиллагааны” гэж тус тус өөрчилж, мөн зүйлийн 7.1.3 дахь заалтын “энэ хуульд заасан асуудлаар” гэснийг, 7.1.6 дахь заалтыг, 7.1.8 дахь заалтын “хүлэмжийн хийн ялгарлын бууралт, шингээлтийн үр дүнг тооцох, баталгаажуулах, тайлагнахтай холбоотой” гэснийг, 7.1.9 дэх заалтын “ногоон болон уур амьсгалын санхүүжилтийн орлогын урсгал, үр ашиг, зарцуулалтыг бүртгэх, хянах, тайлагнах, цаашдын төлөвлөлтийг хангах, олон улсын тайлагнал болон ил тод байдлыг хэрэгжүүлэхтэй холбоотой” гэснийг, 7.1.10 дахь заалтын “энэ хуулийн 4.1.27-д заасан” гэснийг, 7.1.11 дэх заалтын “бүрэн эрх” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 7
Бүгд: 16

56.3 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 8 дугаар зүйлийн 8.1.2 дахь заалтын “ногоон хөрөнгө оруулалтын бодлого,” гэснийг 8.1.5 дахь заалтыг тус тус хасаж, мөн зүйлийн 8.1.1, 8.1.3 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“8.1.1.Монгол Улсын хөгжлийн урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичигт уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох, даван туулах асуудлыг уялдуулан боловсруулах;

8.1.3.ногоон санхүүжилтийн стратегийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран боловсруулах;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 7
Бүгд: 16

56.3 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 8 дугаар зүйлийн 8.2.1 дэх заалтын “төлөвлөгөө,” гэснийг хасаж, 8.2.2 дахь заалтын “удирдах” гэснийг “зохицуулах, хяналт тавих” гэж өөрчилж, 8.1.4 дэх заалтыг 8.2.1 дэх заалт болгон өөрчилж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 8.2 дэх хэсэг нэмэх:

“8.2.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 7

Бүгд: 16

56.3 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 8 дугаар зүйлийн 8.2.5, 8.2.6, 8.2.8 дахь заалтын “хөтөлбөрт” гэсний дараа “эдийн засгийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн” гэж, 8.2.7 дахь заалтын “шилжүүлэгт” гэсний дараа “эдийн засгийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн” гэж тус тус нэмж, 8.2.13 дахь заалтын “зарцуулалтыг хариуцан удирдаж,” гэснийг “зарцуулалтад” гэж, 8.2.15 дахь заалтын “, мэдээлэл цуглуулах, боловсруулах, тайлагнахтай холбоотой үйл ажиллагаа, аргачлал, зохицуулалтын уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөл, эмзэг байдал, эрсдэлийн үнэлгээ хийх журам” гэснийг “аргачлал, журам” гэж тус тус өөрчилж, 8.2.9 дэх заалтыг, 8.2.14 дэх заалтын “Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилтын хэрэгжилтийн үр дүнг тооцох, мэдээлэл цуглуулах, нэгтгэх, тайлагнах, баталгаажуулах үйл ажиллагааны нэгдсэн аргачлал, зохион байгуулалтын” гэснийг, 8.2.18, 8.2.19 дэх заалтыг тус тус хасаж, мөн зүйлийн 8.2.4, 8.2.16, 8.2.17, 8.3.1, 8.4.5 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“8.2.4.олон талт карбон зах зээлийн үйл ажиллагаанд зөвшөөрсөн тухай тодорхойлолт олгох, оролцогч этгээдийг бүртгэх, хяналт тавих;

8.2.16.энэ хуулийн 7.1.8-д заасан журмын төслийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран боловсруулж, батлуулах;

8.2.17.энэ хуулийн 7.1.6, 7.1.7, 7.1.9-т заасан журмын төслийг боловсруулж, батлуулах;

8.3.1.энэ хуулийн 6.1.1, 7.1.1-д заасны дагуу уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох, даван туулах арга хэмжээг салбарын хэмжээнд тодорхойлж, улсын төсөвт тусгуулах, хэрэгжилтийг зохион байгуулах, тайлагнах;

8.4.5.салбарын хэмжээнд Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилтын хэрэгжилтийг хангах, хүлэмжийн хийн ялгарлын тооллоготой холбоотой өгөгдөл, мэдээллийг цуглуулах, тайлагнах үйл ажиллагааг хэрэгжүүлэх;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 7

Бүгд: 16

56.3 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 8 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 8.2.18 дахь заалт нэмэх:

“8.2.18.сааруулалтын үр дүнг тооцох аргачлал, стандарт, ялгарал болон шингээлтийн итгэлцүүрийг Уур амьсгалын өөрчлөлтийн Үндэсний хорооны дэргэдэх техникийн хороогоор хэлэлцүүлж, түүний дүгнэлтэд үндэслэн батлах;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 7

Бүгд: 16

56.3 хувийн саналаар дэмжигдлээ.

12.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“9.1.Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тухайн шатны Засаг даргын өргөн мэдүүлсэн Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилтод нийцсэн уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицоход чиглэсэн аймаг, нийслэлийн төлөвлөгөө болон түүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах төсвийг батлан санхүүжүүлж, гүйцэтгэлд хяналт тавина.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 7

Бүгд: 16

56.3 хувийн саналаар дэмжигдлээ.

13.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсгийн ““8.2-т заасан байгууллагаар” гэснийг “8.3.14-т заасан журмын дагуу” гэж өөрчилж, мөн зүйлийн 10.2 дахь хэсгийн “6.1.1, 7.1.1, 10.1-д заасантай уялдуулан тухайн нутаг дэвсгэрийн хэмжээнд төлөвлөгөөг” гэснийг “6.1.1, 7.1.1, 9.1-д заасантай уялдуулан тухайн нутаг дэвсгэрийн уур амьсгалын өөрчлөлтийн үйл ажиллагааны төлөвлөгөө” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 7

Бүгд: 16

56.3 хувийн саналаар дэмжигдлээ.

14.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 11 дүгээр зүйлийн 11.1.7 дахь заалтын “уур амьсгалын” гэсний дараа “өөрчлөлтийн” гэж нэмж, мөн зүйлийн 11.1 дэх хэсгийн “байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын чиг үүргийн хүрээнд” гэснийг “Цаг уур, орчны хяналт шинжилгээний асуудал эрхэлсэн” гэж, 11.1.2 дахь заалтын “нэмэр” гэснийг “нэмрийн зорилт” гэж, “хариуцсан зохих байгууллагад” гэснийг “байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хянуулахаар” гэж, 11.1.3 дахь заалтын “удирдах” гэснийг “удирдлага, зохион байгуулалтаар хангах” гэж тус тус өөрчилж, 11.1.6 дахь заалтын “Парисын хэлэлцээрийн шаардлагад нийцүүлэн” гэснийг, 11.1.10 дахь заалтын “бүрэн эрх” гэснийг тус тус хасаж, 11.1.9 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“11.1.9.сааруулалтын үр дүнгийн урт хугацааны хадгалалт алдагдах, хэтрүүлэн тооцож шилжүүлэх, байгалийн болон бусад хүчин зүйлээс шалтгаалан буцаан алдагдах эрсдэлийг бууруулах зорилгоор төсөл, хөтөлбөрөөс үүссэн баталгаажсан сааруулалтын үр дүнг тооцож, энэ хуулийн 7.1.6-д заасан журмын дагуу карбон кредитийг байршуулж, буцаан олгох, удирдлага, хяналтыг хэрэгжүүлэх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 8
Бүгд: 16
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Бейсенгийн “дэмжсэн” санал “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Б.Бейсен: Улсын Их Хурлын гишүүн Б.Бейсенгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 7
Бүгд: 16
56.3 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

14.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 11 дүгээр зүйлийн 11.1.7 дахь заалтын “уур амьсгалын” гэсний дараа “өөрчлөлтийн” гэж нэмж, мөн зүйлийн 11.1 дэх хэсгийн “байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын чиг үүргийн хүрээнд” гэснийг “Цаг уур, орчны хяналт шинжилгээний асуудал эрхэлсэн” гэж, 11.1.2 дахь заалтын “нэмэр” гэснийг “нэмрийн зорилт” гэж, “хариуцсан зохих байгууллагад” гэснийг “байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хянуулахаар” гэж, 11.1.3 дахь заалтын “удирдах” гэснийг “удирдах, зохион байгуулалтаар хангах” гэж тус тус өөрчилж, 11.1.6 дахь заалтын “Парисын хэлэлцээрийн шаардлагад нийцүүлэн” гэснийг, 11.1.10 дахь заалтын “бүрэн эрх” гэснийг тус тус хасаж, 11.1.9 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“11.1.9.сааруулалтын үр дүнгийн урт хугацааны хадгалалт алдагдах, хэтрүүлэн тооцож шилжүүлэх, байгалийн болон бусад хүчин зүйлээс шалтгаалан буцаан алдагдах эрсдэлийг бууруулах зорилгоор төсөл, хөтөлбөрөөс үүссэн баталгаажсан сааруулалтын үр дүнг тооцож, энэ хуулийн 7.1.6-д заасан журмын дагуу карбон кредитийг байршуулж, буцаан олгох, удирдлага, хяналтыг хэрэгжүүлэх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 7
Бүгд: 16
56.3 хувийн саналаар дэмжигдлээ.

15.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 12 дугаар зүйлийн 12.1, 12.2, 12.3, 12.4, 12.5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“12.1.Ус, цаг уур, орчны хяналт шинжилгээний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь уур амьсгалын өөрчлөлтийн өнөөгийн төлөв байдлын үнэлгээг жил тутам, уур амьсгалын өөрчлөлтийн ирээдүйн чиг хандлага, нөлөөллийн үнэлгээг таван жил тутам боловсруулж, үнэлгээний дүнг нэгтгэн байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

12.2.Энэ хуулийн 8.3.14-т заасан журмын дагуу уур амьсгалын өөрчлөлтөөс үүсэх бодит болон болзошгүй сөрөг нөлөөлөл, эмзэг байдал, эрсдэлийн үнэлгээг нийгэм, эдийн засгийн салбар, бүс нутаг тус бүрээр холбогдох төрийн захиргааны төв байгууллага, төрийн захиргааны байгууллага, орон нутгийн байгууллага нь Ус, цаг уур, орчны хяналт шинжилгээний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон эрдэм шинжилгээний байгууллагатай хамтран гүйцэтгэнэ.

12.3.Энэ хуулийн 12.2-т заасан үнэлгээний үр дүнг нэгтгэн дүгнэж, шинжлэх ухаанд суурилсан уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах болон дасан зохицох арга хэмжээний бодлого, төлөвлөлтийг тодорхойлно.

12.4.Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөл, эмзэг байдал, эрсдэлийн үнэлгээний үр дүнг үндэсний, бүс нутгийн, салбарын болон орон нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөлт, Үндэсний дасан зохицох төлөвлөгөөг боловсруулахад ашиглана.

12.5.Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөл, эмзэг байдал, эрсдэлийн үнэлгээний үр дүнг уур амьсгалын өөрчлөлтийн Үндэсний платформоор дамжуулан олон нийтэд нээлттэй мэдээлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	9
Татгалзсан:	7
Бүгд:	16

56.3 хувийн саналаар дэмжигдлээ.

16.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 12 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 12.6 дахь хэсэг нэмэх:

“12.6.Төрийн захиргааны байгууллага Гамшгаас хамгаалах тухай хуулийн 20.3-т заасан журмын дагуу Уур амьсгалын өөрчлөлтийг даван туулах, нөлөөллөөс үүдэн гарах эдийн засгийн болон эдийн засгийн бус гарз хохирлын үнэлгээг хийнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	9
Татгалзсан:	7
Бүгд:	16

56.3 хувийн саналаар дэмжигдлээ.

17.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсгийн “баталгаажуулахаар” гэснийг “хянуулахаар” гэж, 13.3 дахь хэсгийн “коэффициентыг” гэснийг “итгэлцүүрийг” гэж, мөн зүйлийн 13.4 дэх хэсгийн “боловсруулж, тогтмол хугацаанд шинэчилнэ” гэснийг “боловсруулна” гэж, 13.5 дахь хэсгийн “аргачлалыг” гэснийг “аргачлал, ялгарал болон шингээлтийн итгэлцүүрийг” гэж, мөн хэсгийн “энэ

хуулийн 8.2-т заасан байгууллага” гэснийг “байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран” гэж, 13.8 дахь хэсгийн “хүргүүлж” гэснийг “гаргаж” гэж тус тус өөрчилж, 13.4 дэх хэсгийн “бодлого,” гэснийг, 13.8 дахь хэсгийн “хүлэмжийн хийн ялгарал, шингээлтийн ил тод байдлын тайлангийн хамтаар” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 7
Бүгд: 16
56.3 хувийн саналаар дэмжигдлээ.

18.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсгийн “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх тохиолдолд холбогдох хуульд заасны дагуу хүлэмжийн хийг бууруулах арга хэмжээг байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгана.” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 7
Бүгд: 16
56.3 хувийн саналаар дэмжигдлээ.

19.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсгийн “санхүүжилтийг тодорхойлон” гэснийг “санхүүжүүлэн” гэж, 16.6 дахь хэсгийн “өөрчлөлтөд дасан зохицох, даван туулах” гэснийг “өөрчлөлтийн талаар” гэж тус тус өөрчилж, 16.4 дэх хэсгийн “, ирээдүйд учирч болзошгүй байгалийн гамшигт үзэгдэлд өртөх эрсдэл өндөртэй байгаа” гэснийг хасаж, 16.1, 16.4, 16.6 дахь хэсгийн доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“16.1.Үндэсний зохицуулагч байгууллага энэ хуулийн 12.3, 12.4-т заасан үнэлгээний үр дүнд үндэслэн Үндэсний дасан зохицох төлөвлөгөөг Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилтод нийцүүлэн тухайн салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран боловсруулна.

16.4.Холбогдох төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэлийн Засаг дарга энэ хуулийн 4.1.16, 4.1.17-д заасан уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөлд өртөмтгий салбар, хүн амын бүлгийн дасан зохицох, даван туулах чадавхыг бэхжүүлэхэд чиглэсэн арга хэмжээг тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлнэ.

16.6.Уур амьсгалын өөрчлөлтийн талаарх мэдлэг, ойлголтыг бүх шатны боловсролын түвшинд эзэмшүүлэх, олон нийтэд түгээн дэлгэрүүлэх, хандлага, оролцоог нэмэгдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 8
Бүгд: 16
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн У.Отгонбаярын “дэмжсэн” санал “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Б.Бейсен: Улсын Их Хурлын гишүүн У.Отгонбаярын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 7
Бүгд: 16
56.3 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

19.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсгийн “санхүүжилтийг тодорхойлон” гэснийг “санхүүжүүлэн” гэж, 16.6 дахь хэсгийн “өөрчлөлтөд дасан зохицох, даван туулах” гэснийг “өөрчлөлтийн талаар” гэж тус тус өөрчилж, 16.4 дэх хэсгийн “, ирээдүйд учирч болзошгүй байгалийн гамшигт үзэгдэлд өртөх эрсдэл өндөртэй байгаа” гэснийг хасаж, 16.1, 16.4, 16.6 дахь хэсгийн доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“16.1.Үндэсний зохицуулагч байгууллага энэ хуулийн 12.3, 12.4-т заасан үнэлгээний үр дүнд үндэслэн Үндэсний дасан зохицох төлөвлөгөөг Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилтод нийцүүлэн тухайн салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран боловсруулна.

16.4.Холбогдох төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэлийн Засаг дарга энэ хуулийн 4.1.16, 4.1.17-д заасан уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөлд өртөмтгий салбар, хүн амын бүлгийн дасан зохицох, даван туулах чадавхыг бэхжүүлэхэд чиглэсэн арга хэмжээг тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлнэ.

16.6.Уур амьсгалын өөрчлөлтийн талаарх мэдлэг, ойлголтыг бүх шатны боловсролын түвшинд эзэмшүүлэх, олон нийтэд түгээн дэлгэрүүлэх, хандлага, оролцоог нэмэгдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 7
Бүгд: 16
56.3 хувийн саналаар дэмжигдлээ.

20.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсгийн “дээд шатны” гэснийг “энэ хуулийн 8.3-т заасан” гэж, мөн хэсгийн “танилцуулга” гэснийг “хянуулахаар хүргүүлнэ” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 8
Бүгд: 16
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Бейсенгийн “дэмжсэн” санал “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Б.Бейсен: Улсын Их Хурлын гишүүн Б.Бейсенгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 7
Бүгд: 16
56.3 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

20.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсгийн “дээд шатны” гэснийг “энэ хуулийн 8.3-т заасан” гэж, мөн хэсгийн “танилцуулга” гэснийг “хянуулахаар хүргүүлнэ” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 7
Бүгд: 16
56.3 хувийн саналаар дэмжигдлээ.

21.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 18 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“18.1.Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилтыг таван жил тутам шинэчлэн батална.

18.2.Урт хугацааны хүлэмжийн хийн ялгарал багатай эдийн засгийн шилжилтийн стратегийг хүлэмжийн хийн үндэсний тооллого, хүлэмжийн хийн ялгарал, шингээлтийн хэтийн төлөв, төсөөлөлд үндэслэн боловсруулна.

18.3.Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, урьдчилан сэргийлэх, шингээлтийг нэмэгдүүлэх төлөвлөлтийг Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилтод нийцүүлэн тодорхойлно.

18.4.Энэ хуулийн 18.2-т заасан стратеги, төлөвлөгөөнд хүлэмжийн хийг ялгаруулагч болон шингээгч салбар тус бүрээр хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, урьдчилан сэргийлэх, шингээлтийг нэмэгдүүлэх зорилт, арга хэмжээний хүрээ, үр дүнгийн шалгуур үзүүлэлтийг тусгана.

18.5.Төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэлийн Засаг дарга нь энэ хуулийн 8.4-т заасан чиг үүрэг, 10, 11 дүгээр зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, урьдчилан сэргийлэх, шингээлтийг нэмэгдүүлэх зорилт, арга хэмжээг салбарын болон орон нутгийн хөгжлийн төлөвлөлтийн баримт бичигт тусган хэрэгжүүлнэ.

18.6.Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах арга хэмжээг хэрэгжүүлэхдээ эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл, эрсдэлийг харгалзан үзнэ.

18.7.Хувийн хэвшлийн байгууллага өөрийн үйл ажиллагаанаас үүдэлтэй хүлэмжийн хийн ялгарал, шингээлтийг тооцох, бууруулах, урьдчилан сэргийлэх, шингээлтийг нэмэгдүүлэх арга хэмжээ хэрэгжүүлэхийг дэмжинэ.

18.8.Үндэсний зохицуулагч байгууллага байгууллагын болон төслийн түвшний хүлэмжийн хийн ялгарлын тооцоо, хэмжилт, тайлагнал, баталгаажуулалттай холбоотой заавар, аргачлалыг баталж, хэрэгжилтэд арга зүйн дэмжлэг үзүүлнэ.

18.9.Үндэсний зохицуулагч байгууллага уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах арга хэмжээний гүйцэтгэлийг жил бүр үнэлж, хэрэгжилтийн тайланг боловсруулж, энэ хуулийн 8.3-т заасан байгууллагад хянуулахаар хүргүүлнэ.

18.10.Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах төлөвлөлтийг боловсруулах, хэрэгжүүлэх хүрээнд институтийн болон хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх, олон нийтийн мэдлэг, оролцоог нэмэгдүүлэх арга хэмжээг тусгана.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 7

Бүгд: 16

56.3 хувийн саналаар дэмжигдлээ.

22.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 19 дүгээр зүйлийн 19.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“19.2.Үндэсний зохицуулагч байгууллага Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилтын хэрэгжилтийн ил тод байдлын тайланг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн арга, аргачлалын дагуу боловсруулж, энэ хуулийн 8.3-т заасан байгууллагад хянуулахаар хүргүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 7

Бүгд: 16

56.3 хувийн саналаар дэмжигдлээ.

23.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 20 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“20 дугаар зүйл. Ногоон санхүүжилт

20.1.Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох, даван туулах, байгалийн нөөцийн зохистой ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх, нийгэм, эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангахад чиглэсэн төсөл, хөтөлбөр, үйл ажиллагааг ногоон санхүүжилтээр дэмжинэ.

20.2.Ногоон санхүүжилтээр хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь хөгжлийн бодлого, төлөвлөлт, төсөв, мөнгөний бодлого, ногоон санхүүжилтийн стратегитай нийцсэн байна.

20.3.Энэ хуулийн 20.1-т заасан төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд улсын болон орон нутгийн төсвийн төлөвлөлтөд зардал, үр ашгийн тооцоо, нийгэм, эдийн засгийн өгөөж, төсөвт үзүүлэх нөлөөлөлд үндэслэнэ.

20.4.Ногоон санхүүжилт нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ:

20.4.1.улсын болон орон нутгийн төсөв;

20.4.2.төр, хувийн хэвшлийн түншлэлийн санхүүжилт;

20.4.3.гадаад, дотоодын хуулийн этгээд, хувь хүний санхүүжилт;

20.4.4.гадаадын зээл, буцалтгүй тусламж;

20.4.5.байгаль орчин, уур амьсгалын сан;

20.4.6.хууль тогтоомжид нийцсэн бусад эх үүсвэр.

20.5.Ногоон санхүүжилтийг дараах санхүүгийн хэрэгсэл, хөшүүргийг ашиглан хэрэгжүүлж болно:

20.5.1.улсын болон орон нутгийн төсвийн санхүүжилт;

20.5.2.татварын хөнгөлөлт, чөлөөлөлт;

20.5.3.батлан даалт;

20.5.4.зорилтот бонд, зээл;

20.5.5.төр, хувийн хэвшлийн болон олон улсын эх үүсвэртэй холимог санхүүжилт;

20.5.6.хууль тогтоомжид нийцсэн бусад;

20.6.Энэ хуулийн 20.5-д заасан ногоон санхүүжилтийн хөшүүрэг нь Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай, Төсвийн тухай, Өрийн удирдлагын тухай, Татварын ерөнхий хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасан холбогдох шаардлагыг хангасан байна.

20.7.Ногоон санхүүжилтэд хамрагдах төсөл, хөтөлбөр, үйл ажиллагаа нь ногоон санхүүжилтийн шалгуур, ногоон таксономи, хэмжилт, тайлагнал, баталгаажуулалтын шаардлагыг хангасан байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 7

Бүгд: 16

56.3 хувийн саналаар дэмжигдлээ.

24.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсгийг хасаж, 21.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“21.3.Ногоон санхүүжилтэд хамрагдах төсөл, хөтөлбөр, үйл ажиллагааны үр дүн нь бодит, хэмжигдэхүйц, баталгаажихуйц байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 6
Бүгд: 16
62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

25.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 22 дүгээр зүйлийн 22.2, 22.3, 22.5, 22.6 дахь хэсгийг хасаж, 22.1, 22.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“22.1.Ногоон санхүүжилтийн мэдээлэл нь ил тод, нээлттэй, нийтэд хүртээмжтэй байна.

22.4.Уур амьсгалын санхүүжилтийн мэдээллийг энэ хуулийн 19 дүгээр зүйлд заасны дагуу Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилтын хэрэгжилтийн ил тод байдлын тайланд тусган тайлагнана.”

Тайлбар: Энэ хуулийн 4.1.21-д заасан уур амьсгалын санхүүжилт нь 4.1.8-д заасан ногоон санхүүжилтийн бүрэлдэхүүн хэсэг байх бөгөөд энэ хуульд “ногоон болон уур амьсгалын санхүүжилт” гэж дурдсан тохиолдолд уур амьсгалын санхүүжилтийг ногоон санхүүжилтэд хамааруулан ойлгоно гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 7
Бүгд: 16
56.3 хувийн саналаар дэмжигдлээ.

26.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсгийн “хэлбэртэй” гэснийг “төрөлтэй” гэж, 23.3.8 дахь заалтын “иргэдтэй урьдчилан зөвлөлдөж” гэснийг “иргэдэд төсөл, хөтөлбөрийн танилцуулга хийж” гэж тус тус өөрчилж, мөн зүйлийн 23.3.7, 23.5.11, 23.6 дахь хэсгийг хасаж, 23.5.5 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“23.5.5.сааруулалтын үр дүнг Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилтод тооцох, олон улсад шилжүүлэх эсэхийг тодорхойлсон ашиглалтын зорилго” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 7
Бүгд: 16
56.3 хувийн саналаар дэмжигдлээ.

27.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсгийн “санхүүжилтээр шууд санхүүжээгүй төслөөс” гэснийг “санхүүжилтээс бусад эх үүсвэрээр хэрэгжүүлсэн төслөөс” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 7
Бүгд: 16
56.3 хувийн саналаар дэмжигдлээ.

28.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 25 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 7
Бүгд: 16
56.3 хувийн саналаар дэмжигдлээ.

29.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 26 дугаар зүйлийн 26.3 дахь хэсгийн “баталгаажуулалтын журмыг энэ хуулийн 8.2-т заасан байгууллага батална” гэснийг “баталгаажуулалтыг энэ хуулийн 7.1.8-д заасан журмын дагуу хэрэгжүүлнэ” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 7
Бүгд: 16
56.3 хувийн саналаар дэмжигдлээ.

30.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн Наймдугаар бүлгийн гарчгийн “ИЛ ТОД БАЙДАЛ” гэснийг “ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ” гэж өөрчилж, 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсгийн “Үндэсний” гэсний өмнө “Уур амьсгалын өөрчлөлтийн” гэж нэмж, 27.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“27.2.Үндэсний зохицуулагч байгууллага уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа, төсөл, хөтөлбөрийн үр дүн, хүлэмжийн хийн үндэсний тооллогын мэдээллийг энэ хуулийн 27.1-д заасан үндэсний мэдээллийн системд бүртгэж, түүний ашиглалт, хадгалалт, хамгаалалт, нууцлалын найдвартай байдлыг ханган ажиллана.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 7
Бүгд: 16
56.3 хувийн саналаар дэмжигдлээ.

31.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 28 дугаар зүйлийн гарчгийн “, ил тод байдал” гэснийг хасаж, мөн зүйлийн 28.2 дахь хэсгийн “хуулийн” гэсний өмнө “хуулийн 28.1-д заасан байгууллага” гэж нэмж, 28.3 дахь хэсгийн “мэдээллийг тогтоосон хугацаанд” гэснийг “мэдээллийг энэ хуулийн 8.2.10-т заасан техникийн хороогоор хянуулна.” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 7
Бүгд: 16
56.3 хувийн саналаар дэмжигдлээ.

32.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсгийн “зорилтыг хангах зохицуулалттай карбон кредитийг энэ хуулийн 8.2-т заасан” гэснийг “зорилтод тооцогдох карбон кредитийг энэ хуулийн 8.3-т заасан” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 7
Бүгд: 16
56.3 хувийн саналаар дэмжигдлээ.

33.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 31 дүгээр зүйлийн 31.3 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 7
Бүгд: 16
56.3 хувийн саналаар дэмжигдлээ.

34.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 32 дугаар зүйл нэмэх:

“32 дугаар зүйл.Шилжилтийн үеийн зохицуулалт

32.1.Энэ хуулийн 22.1.7, 22.1.8, 22.1.9, 22.1.10-т заасан журмыг Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 6 сарын сарын дотор баталж мөрдүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 7
Бүгд: 16
56.3 хувийн саналаар дэмжигдлээ.

35.Ажлын хэсгийн гаргасан, “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 7
Бүгд: 16
56.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Найруулгын санал:

Б.Бейсен: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 18 дугаар зүйлийн 18.4 дэх хэсгийн “8.3” гэсний дараа “заасан чиг үүрэг” гэж, 24.1 дэх хэсгийн “бүртгэгдсэнээр” гэсний дараа “түүнийг” гэж тус тус нэмж, 4 дүгээр зүйлийн 4.1.6, 4.1.11, 4.1.15 дахь заалтын “зах зээлийн тогтолцоо” гэснийг “зах зээлийг” гэж, 4.1.20 дахь заалтын “мэдрэг байдал өндөр” гэснийг “эрсдэлтэй, мэдрэг байдалтай” гэж, мөн заалтын “өндөр” гэснийг “бүхий” гэж, 4.1.32 дахь заалтын “нүүрсхүчлийн хий” гэснийг “нүүрстөрөгчийн давхар исэл” гэж, 4.1.33 дахь заалтын “экосистемийн,” гэснийг

“экосистемийг ашиглах” гэж, 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсгийн “тогтоосон” гэснийг “хуульд заасан” гэж, 31 дүгээр зүйлийн 31.3 дахь хэсгийн “22.7-д” гэснийг “30.2-т” гэж тус тус өөрчилж, төслийн хуулийн нэрийн “ХУУЛЬ” гэснийг, 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалтын “тогтмол” гэснийг, 18 дугаар зүйлийн 18.4 дэх хэсгийн “Салбарын болон бусад” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 6
Бүгд: 16
62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг зүйл бүрээр хэлэлцэв.

Нэг.Агаарын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Хоёр.Авто замын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Гурав.Барилгын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Дөрөв.Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл

Төслийн зүйлтэй холбогдуулан ажлын хэсгийн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Б.Бейсен: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 9 дэх хэсгийн “мэдээллийн нэгдсэн” гэснийг “уур амьсгалын өөрчлөлтийн мэдээллийн” гэж, 2 дугаар зүйлийн “өөрчлөлтийн мэдээллийн нэгдсэн сан” гэснийг “өөрчлөлт” гэж тус тус өөрчлөх гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 6
Бүгд: 16
62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Тав.Гамшгаас хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Зургаа.Тариалангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Долоо.Хот байгуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл

Төслийн зүйлтэй холбогдуулан ажлын хэсгийн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Б.Бейсен: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “өөрчлөлтийг даван туулах” гэснийг “өөрчлөлтийн” гэж өөрчлөх гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 6
Бүгд: 16
62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Найм.Эрчим хүчний хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Ес.Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төсөл

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаясгалан үг хэлэв.

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан ажлын хэсгийн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Б.Бейсен: Ажлын хэсгийн гаргасан, Төслийг хууль санаачлагчид нь буцаах гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 6
Бүгд: 16
62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Б.Бейсен: Ажлын хэсгийн гаргасан, Дээрх зарчмын зөрүүтэй саналын томьёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн бүлэг, зүйл, хэсэг, заалтын дугаарыг өөрчилж, төслийн агуулга, зарчмыг алдагдуулахгүйгээр үг хэллэг, найруулгын шинжтэй засвар хийх гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 6
Бүгд: 16
62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Э.Болормаа Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 18 цаг 46 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Ойн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ нарын 18 гишүүн 2026.06.04-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд Ц.Сандаг-Очир, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ш.Батбаяр, мөн яамны Байгалийн нөөцийн бодлого, зохистой ашиглалтын газрын дарга Т.Балжинням, Ойн газрын дарга Б.Оюунсанаа, Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн төслийн зөвлөх Я.Хишигт нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, зөвлөх Бад.Баярмаа, П.Хулан, референт Б.Бадралт, Ц.Рэнцэнтогтох, Б.Энхгэрэл нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхбат, Л.Мөнхбаясгалан нарын тавьсан асуултад хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Г.Ганбаатар үг хэлэв.

Б.Бейсен: 1.Ойн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 6
Бүгд: 16
62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаясгалангийн “дэмжсэн” санал “эсрэг” гарсан тул санал хураалтыг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, 68.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Хамт өргөн мэдүүлсэн:

2.Ойн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 5
Бүгд: 16
68.8 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Тариалангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 5
Бүгд: 16
68.8 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ойн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 5
Бүгд: 16
68.8 хувийн саналаар дэмжигдлээ.

5.“Ойн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 6

Бүгд: 16
62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Ганбаатар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 19 цаг 11 минутад хэлэлцэж дуусав.

Гурав. “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2026.03.17-ны өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын дарга А.Энхманлай, мөн газрын Геодези, зураг зүйн хэлтсийн дарга Д.Мөнхцэцэг, мэргэжилтэн Ц.Орлого, Шинжлэх ухааны академийн Нийгмийн шинжлэх ухаан хариуцсан дэд ерөнхийлөгч Ц.Цэрэндорж, мөн академийн Газарзүйн мэдээллийн систем, зураг зүйн салбарын дарга Ц.Наранцацрал, Хэл зохиолын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан О.Самбуудорж, Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн Ажлын албаны дарга Н.Нарангэрэл, гавьяат багш Э.Равдан, гавьяат барилгачин Д.Оюунчимэг, “Сондуултын зам” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн ерөнхий менежер О.Сарангэрэл нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, зөвлөх Бад.Баярмаа, П.Хулан, референт Б.Бадралт, Ц.Рэнцэнтогтох, Б.Энхгэрэл нар байлцав.

Хуулийн төслийн талаарх тусгайлсан ажлын хэсгийн саналыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга танилцуулав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг заалт бүрээр хэлэлцэв.

Төслийн заалтуудтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Ганхүлэг, Г.Ганбаатар нарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын дарга А.Энхманлай нар хариулж, тайлбар хийв.

Төслийн заалтуудтай холбогдуулан ажлын хэсгийн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Б.Бейсен: 1.Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга, Н.Алтаншагай, Б.Бейсен, М.Ганхүлэг, А.Ундраа, Ж.Чинбүрэн /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Тогтоолын төслийн 1 дэх заалтын “Гатлага,” гэсний дараах “Говь,” гэснийг, “Толгой,” гэсний дараах “Тохой,” гэснийг, “Хад,” гэсний дараах “Харгайт,” гэснийг, “Цав,” гэсний дараах “Чулуу” гэсэн дэвсгэр нэрийг хасаж, эдгээрт хамаарах газар зүйн нэрийг “Салаа”, “Бөөрөг”, “Хаалга”, “Хөтөл”, “Уул”, “Товог”,

“Бэлчир”, “Даваа”, “Тал” хэсэгт тус тус харгалзуулж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 6
Бүгд: 16
62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 1 дэх заалтын “Уул” хэсгийн “Арал Толгой уул, Aral Tolgoi uul, Баян-Өлгий, Сагсай” гэснийг “Арал Толгой уул, Aral Tolgoi uul, Баян-Өлгий, Алтай” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 6
Бүгд: 16
62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дахь заалтын “Ам” гэсний дараа ““Ар”,” гэж, “Шанд” гэсний дараа ““Ширээ”,” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 5
Бүгд: 16
68.8 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 3 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3.Монгол Улсын Засгийн газар /Н.Учрал/-т даалгах нь:

1/Энэ тогтоолоор баталсан газар зүйн нэрийг геодези, зураг зүйн мэдээллийн улсын нэгдсэн санд бүртгэх;

2/Монгол Улсын Их Хурлаас баталсан газар зүйн нэрийг батлагдсан стандартад нийцүүлэн латин үсэгт галиглан хэрэглэх, газар зүйн нэрийг судлах, сурталчлах, хамгаалах, мөрдүүлэх, газар зүйн нэрийн цахим системээр дамжуулан хэрэглээнд нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах;

3/Баян-Өлгий аймгийн нутаг дэвсгэрт хамаарах газар зүйн нэрийн тодотголыг хийж, сумдын хилийн цэсийг албан ёсны газар зүйн нэрийн дагуу шинэчлэн холбогдох шийдвэрийн төслийг боловсруулж, 2027 оны намрын ээлжит чуулганы хугацаанд багтаан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 5
Бүгд: 16
68.8 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төсөлд доор дурдсан 4 дэх заалт нэмэх:

“4.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо /Б.Бейсен/-д даалгасугай.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 5
Бүгд: 16
68.8 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Хууль тогтоомжийн тухай хуульд нийцүүлэн тогтоолын төслийн 1 дэх заалтыг 2 дахь заалт болгон өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 5
Бүгд: 16
68.8 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн нэр томъёог жигдлэх, заалтын дугаарыг нийцүүлж өөрчлөх, бүтэц найруулга, латин хөрвүүлэгт холбогдох хууль зүйн техникийн засварыг хийх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 5
Бүгд: 16
68.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 19 цаг 31 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв.Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай нарын 10 гишүүн 2025.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Довчинсүрэн, мөн яамны Хуулийн хэлтсийн дарга Ч.Раднаабазар, Бодлого, төлөвлөлтийн газрын ахлах шинжээч О.Онон, ахлах мэргэжилтэн Х.Цэрэнханд, Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн төслийн зөвлөх Я.Хишигт нар оролцов.

Хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Т.Мөнхсайхан танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүд асуулт асуугаагүй болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-т заасны дагуу хураалгах санал:

Б.Бейсен: Төслийн 4 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4 дүгээр зүйл.Хүнсний тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийн “эрхлэхтэй” гэснийг “эрхлэх, түүнд хяналт тавихтай” гэж, 3 дугаар зүйлийн 3.1.8 дахь заалтын “үйлдвэрлэсэн” гэснийг “үйлдвэрлэсэн хүнс” гэж, “хийгдсэнийг” гэснийг “хийгдсэн хүнсийг” гэж, 4 дүгээр зүйлийн гарчгийн “зарчим” гэснийг “зарчим, бодлогын чиглэл” гэж, Хоёрдугаар бүлгийн гарчгийн “ХАНГАМЖ” гэснийг “ХАНГАМЖ, ХҮРТЭЭМЖ” гэж, 10 дугаар зүйлийн 10.1.5 дахь заалтын “боловсруулах болон нийтийн хоолны үйлдвэрлэл” гэснийг “хүнсний боловсруулах болон хоол үйлдвэрлэл, үйлчилгээ” гэж, 13 дугаар зүйлийн 13.1.1 дэх заалтын “шим тэжээллэг байдалд” гэснийг “шим тэжээллэг байдал, хуурамч хүнсний бүтээгдэхүүнд” гэж, 13.1.4 дэх заалтын “энэ хуулийн 6.8-д заасан” гэснийг “энэ хуулийн 5¹ дүгээр зүйлд заасан” гэж тус тус өөрчилсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 6

Бүгд: 16

62.5 хувь буюу гуравны хоёроос доошгүй саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхбатын “дэмжсэн” санал “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Б.Бейсен: Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхбатын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 5

Бүгд: 16

68.8 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Б.Бейсен: Төслийн 4 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4 дүгээр зүйл.Хүнсний тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийн “эрхлэхтэй” гэснийг “эрхлэх, түүнд хяналт тавихтай” гэж, 3 дугаар зүйлийн 3.1.8 дахь заалтын “үйлдвэрлэсэн” гэснийг “үйлдвэрлэсэн хүнс” гэж, “хийгдсэнийг” гэснийг “хийгдсэн хүнсийг” гэж, 4 дүгээр зүйлийн гарчгийн “зарчим” гэснийг “зарчим, бодлогын чиглэл” гэж, Хоёрдугаар бүлгийн гарчгийн “ХАНГАМЖ” гэснийг “ХАНГАМЖ, ХҮРТЭЭМЖ” гэж, 10 дугаар зүйлийн 10.1.5 дахь заалтын “боловсруулах болон нийтийн хоолны үйлдвэрлэл” гэснийг “хүнсний боловсруулах болон хоол үйлдвэрлэл, үйлчилгээ” гэж, 13 дугаар зүйлийн 13.1.1 дэх заалтын “шим тэжээллэг байдалд” гэснийг “шим тэжээллэг байдал, хуурамч хүнсний бүтээгдэхүүнд” гэж, 13.1.4 дэх заалтын “энэ хуулийн 6.8-д заасан” гэснийг “энэ

хуулийн 5¹ дүгээр зүйлд заасан” гэж тус тус өөрчилсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 5

Бүгд: 16

68.8 хувь буюу гуравны хоёроос дээш саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Т.Мөнхсайхан Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 19 цаг 38 минутад хэлэлцэж дуусав.

Тав.Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Хөдөө аж ахуйн тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хуулийн хэлтсийн дарга Ч.Раднаабазар, мөн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын шинжээч Ц.Мөнхнасан нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, зөвлөх Бад.Баярмаа, П.Хулан, референт Б.Бадралт, Ц.Рэнцэнтогтох, Б.Энхгэрэл нар байлцав.

Хуулийн төслийн талаарх тусгайлсан ажлын хэсгийн саналыг ажлын хэсгийн гишүүн, Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатар танилцуулав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатар төслийн талаар зарчмын зөрүүтэй саналын томьёолол гараагүй тул хуулийн төслийг анхны хэлэлцүүлгээс эцэслэн батлах үе шат руу шилжүүлэх горимын санал гаргав.

Б.Бейсен: Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатарын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 5

Бүгд: 16

68.8 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 19 цаг 44 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 5 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 2 цаг 49 минут үргэлжилж, ирвэл зохих 29 гишүүнээс 16 гишүүн хүрэлцэн ирж, 55.2 хувийн ирцтэйгээр 19 цаг 44 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС,
ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Б.БЕЙСЕН

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ГАЗРЫН ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2026 оны 06 дугаар сарын 17-ны өдөр,
Лхагва гараг
Төрийн ордон “Их засаг” танхим
16 цаг 55 минут.

БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Б.Бейсен: Эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая. Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, ирц 51.7 хувьтай бүрдсэн тул Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн /БОХХАА/ байнгын хорооны 2026 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье.

Монгол Улсын Их Хурал /УИХ/-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7.8-д заасны дагуу хуралдааны ирцийг гишүүний сонгогдсон тойрог, нэрээр нь танилцуулъя. Очирбатын Амгаланбаатар гишүүн ирсэн байна, Буланы Бейсен гишүүн ирсэн байна, Дамдинсүрэнгийн Жаргалсайхан гишүүн ирсэн байна, Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан гишүүн ирсэн байна, Ухнаагийн Отгонбаяр гишүүн ирсэн байна, Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүн ирсэн байна, Гомбожавын Ганбаатар гишүүн ирсэн байна, Сонгобайн Замира гишүүн ирсэн байна, Тогтмолын Мөнхсайхан гишүүн ирсэн байна, Болдын Уянга гишүүн ирсэн байна, Пүрэвийн Батчимэг гишүүн ирсэн байна, Мөнгөнцогийн Ганхүлэг гишүүн ирсэн байна, Цагаанхүүгийн Мөнхбат гишүүн ирсэн байна, Нанзадын Наранбаатар гишүүн ирсэн байна, Жигжидсүрэнгийн Чинбүрэн гишүүн ирсэн байна.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Хэлэлцэх асуудал 1.Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд, Засгийн газар /ЗГ/ 2026 оны 5 сарын 21-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг. 2.Ойн тухай хууль Шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд, УИХ-ын гишүүн Бат-Өлзийн Бат-Эрдэнэ нарын 18 гишүүн 2026 оны 6 сарын 4-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх. 3 дахь асуудал Тогтоолын хавсралт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай УИХ-ын тогтоолын төсөл, ЗГ 2026 оны 3 сарын 17-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг. 4.Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд, УИХ-ын гишүүн Мандхай нарын 10 гишүүн 2025 оны 6 сарын 19-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг. 5 дахь асуудал Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл Хөдөө аж ахуй /ХАА/-н тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг. 6 дахь асуудал Хянан шалгах түр хороо байгуулах тухай УИХ-ын тогтоолын төсөл, УИХ-ын гишүүн Баатархүү нарын 35 гишүүн 2025 оны 11 сарын 7-ны өдөр өргөн мэдүүлсэн.

Энэ зургаа дахь асуудал дээр бүлгүүд гишүүдийн нэрийг өгөөгүй учраас энэ асуудлыг хойшлууллаа. Ингээд 5 асуудал хэлсэн. Хэлэлцэх асуудлын талаар саналтай гишүүд байна уу? Байхгүй байна. Хэлэлцэх асуудалд оръё.

Нэг.Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2026.05.21-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулна. Хуралд оролцож байгаа ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамнаас Ш.Батбаяр Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн дарга /ТНБД/-ын албан үүрэг түр орлон гүйцэтгэгч, Ц.Уранчимэг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Тусгай хамгаалалттай газар нутаг /ТХГН/-ийн бодлогын газрын дарга, Л.Чой-Иш, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам /ХХААХҮЯ/-ны Мал аж ахуйн бодлогын газрын дарга, Ц.Пүрэвсүрэн Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын Ногоон санхүүжилтийн бодлогын хэлтсийн дарга, Х.Мөнхзул Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын Хуулийн хэлтсийн дарга, Х.Номин Сангийн яамны Санхүү, бодлогын газрын Санхүүгийн зах зээл, олон улсын хамтын ажиллагааны хэлтсийн ахлах шинжээч, Ц.Мөнхбат Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны ТХГН-ийн бодлогын газрын ахлах шинжээч, Ц.Мөнхнасан ХХААХҮЯ-ны Бодлого, төлөвлөлтийн газрын ахлах шинжээч, А.Нарангарав Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын ахлах шинжээч, Э.Баттулга Цаг уур, орчны шинжилгээний газрын дарга, Д.Дагвадорж, Газар зүй, геоэкологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан, судлаач, Д.Одхүү Уур амьсгалын ногоон сангийн үндэсний зохицуулагч, Б.Номун Нэгдсэн Үндэстний байгууллага /НҮБ/-ын Хөгжлийн хөтөлбөрийн хамтран хэрэгжүүлж буй Нүүрстөрөгчийн зах зээлийн бэлэн байдлыг бэхжүүлэх төслийн хуулийн зөвлөх.

Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдааны хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий Ажлын хэсэг УИХ-ын даргын захирамжаар байгуулан ажилласан. Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, УИХ-ын гишүүн Э.Болормаа танилцуулна. Болормаа гишүүнд микрофон өгье.

Э.Болормаа: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 3Г-аас 2026 оны 5 сарын 21-ний өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг 2026 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр БОХХАА-н байнгын хороонд шилжүүлсэн. Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг хангах үүрэг бүхий Ажлын хэсгийг УИХ-ын дарга 2026 оны 263 дугаар захирамжаар байгуулсан бөгөөд ажлын хэсгийн ахлагчаар УИХ-ын гишүүн Э.Болормаа, бүрэлдэхүүнд нь УИХ-ын гишүүн Б.Батбаатар, Н.Батсүмбэрэл, С.Ганбаатар, П.Наранбаяр, С.Одонтуяа, П.Сайнзориг, Ч.Ундрэм, С.Эрдэнэбат нарын гишүүд ажиллалаа.

Ажлын хэсэг энэ хугацаанд 2 удаа, мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх дэмжих баг 4 удаа хуралдаж, уур амьсгалын өөрчлөлтийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн талаар 28 саналын томьёолол бэлтгэж, хамт өргөн

мэдүүлсэн хуулийн төслийн талаарх 3 санал, төслийн бүтэц, нэр, томьёо, хэл, найруулга, дэс дараалал, зүйл, заалтын дугаар, эшлэлийг нийцүүлж өөрчлөх нэг саналын томьёоллыг хэлэлцэн дэмжиж, БОХХАА-н байнгын хорооны хуралдаанд танилцуулах нь зүйтэй гэж үзсэн болно.

Тухайлбал, хуулийн төслийн нэр томьёоны тодорхойлолтыг сайжруулах, эдийн засгийн үр ашигтай байх зарчмыг тусгах, ус, цаг уур, орчны хяналт шинжилгээний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага үндэсний зохицуулагч байгууллага байх бөгөөд уур амьсгалын өөрчлөлтийн төлөв байдлын үнэлгээг жил бүр, уур амьсгалын өөрчлөлтийн чиг хандлага, нөлөөллийн үнэлгээг 5 жил тутам хийж, үнэлгээний дүнг нэгтгэн байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх, уур амьсгалын өөрчлөлтийн талаарх мэдлэг, ойлголтыг бүх шатны боловсролын түвшинд эзэмшүүлэх, олон нийтэд түгээн дэлгэрүүлэх, хандлага, оролцоог нэмэгдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх, ногоон санхүүжилтийн стратегийн хамрах хүрээ, хэрэгжилтийн уялдаа холбоог илүү нарийвчлан тодорхойлон нэмж тусган боловсруулсан болно.

Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдтэй холбогдуулан ажлын хэсгээс бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг та бүхэнд тараасан болно.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ, дээрх хуулийн төслүүдийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулга болон зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Б.Бейсен: Болормаа гишүүнд баярлалаа. Монгол УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-д Байнгын хороо хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэнэ гэж заасны дагуу хэлэлцье. Гишүүд та бүхэн тухайн хуулийн зүйлтэй холбогдуулан асуулт асууж болно. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу, нэрсээ өгнө үү? Тарааж өгсөн, төслийг нь тарааж өгсөн. Ба-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүнээр тасалъя. Мөнхбаясгалан гишүүн. Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүн асуулт асууж.

Б.Бат-Эрдэнэ: Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хууль бид яах вэ зүгээр нэг ийм л юм харагдаад байгаа. Парисын хэлэлцээрийн 6 дугаар зүйлээр зохицуулсан харилцааг бид хуульчилж байгаа юм. Энэ өөрөө хуулийн зорилго дээр хэр тусаж өгсөн юм, хэр нийцэж байгаа юм? Илүү хуульчилж байгаа хэлбэр дээр илүү хүнд суртал, давхардал үүсгэж байгаа юм биш биз дээ гэдэг асуултыг би асуух гэж байгаа юм?

Б.Бейсен: Болормаа гишүүн хариулъя.

Э.Болормаа: Б.Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя. Маш энгийнээр хэлбэл энэ хуулийн зорилго маань өөрөө анхдагч хууль. Уур амьсгалын өөрчлөлтийг Монгол Улс хэрхэн авч үзэх вэ, тэр дундаа төрийн байгууллагууд хаана эрх мэдэл, үүрэг, чиг үүргүүд хаана байх вэ гэдэг энэ уялдаа зохицлыг хангах бол үндсэн нэг үүрэг байгаа. Нөгөөдөх нэг томоохон үүрэг нь сая гишүүний асуултад орсон бид энэ олон улсын карбон зах зээл /carbon market/ гэдэг зүйлд хэрхэн нэвтрэх вэ гэдэгтэй холбоотой зохицуулалтуудыг оруулж ирсэн байгаа. Энэ ажлын

хэсгийн явцад бид энэ карбон зах зээл гэдгийг олон нийтэд танин мэдүүлэх, энэ дээр олон төсөл хэрэгжүүлэгчид энэ уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, байгаль орчинд ээлтэй төслүүдийг хэрэгжүүлэхэд тодорхой санхүүжилтийг олон улсаас босгох боломжууд байвч өнөөдөр Монгол Улсад зохицуулалт байхгүй тул бид энд нэвтэрч чадахгүй байгаа.

Гэхдээ Бат-Эрдэнэ сайд өөрөө энд гар бие оролцож маш том дэвшил авчирсан нэг зүйл нь өнөөдөр бид энэ Парисын хэлэлцээрийн article 6 дугаар зүйлийн дагуу олон улсын болоод хоёр талт хэлэлцээрүүдийг байгуулчихсан байгаа. Хоёр талт хэлэлцээр дундаа Швейцар, Сингапур, Япон, Солонгос гэсэн ийм 4 улстай хэлэлцээр байгуулаад энийг хэрэгжилтийн явцад ямар нэгэн хүндрэл учруулж, ААН-үүдэд зөвшөөрлийн шинж чанартай ч юм уу иймэрхүү давхардсан удаашрал, төрийн хүнд суртал үзүүлэх вий гэсэн ийм таны болгоомжлол болон энэ саналыг олон гишүүд энэ ажлын хэсгийн хуралдаануудад хэлсэн байгаа.

Бид энийг ямархуу байдлаар зохицуулсан бэ гэхээр бидний шаардах гэхээс илүүтэйгээр олгох гэж байгаа 3 зөвшөөрөл нь гурвуулаа олон улсын зах зээл шаардаж байгаа. Эхнийх нь татгалзахгүй байх, 2 дахь нь энэ төслийг хэрэгжүүлж болно гэдэг Монгол Улсын өөрийн зорилттой энэ нийцнэ гэдэг, 3 дахь нь нөгөө гадаад улстайгаа энэ шилжүүлгээ хийж болно гэсэн ийм гуравхан зөвшөөрөл гэж хэлэх нь арай зохимжгүй, гуравхан бичиг баримтын тодорхойлолтыг гаргах ийм үйл явц байгаа. Бид өөр бусад шаардлагагүй юмнуудыг бүгдийг нь хасах ийм шийдвэрүүдийг гаргаад яг таны энэ болгоомжлол дээр үндэслээд зөвхөн энэ 3-аар хязгаарласан. Энэ 3-ыг бид тодорхойлох биш, зах зээл нь тодорхойлсон байгаа, худалдан авагч тал нь тодорхойлсон. Тэгээд энэ нь бидний хуульд хаана эрх бүхий байгууллага нь энэ тодорхойлолтыг олгох вэ гэдгийг нь тодруулж өгсөн гэдгийг л хэлье.

Б.Бейсен: Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүн тодруулъя.

Б.Бат-Эрдэнэ: Харин тийм, ойлгож байгаа. Тэгэхдээ энэ дээр нэг иймэрхүү юм байгаад байна. Байгаль орчны яам ба үндэсний зохицуулагч байгууллага гээд, Үндэсний зохицуулагч байгууллага гээд нэр томьёо, байгууллага орж ирчхээд байгаа. Ингээд харахаар яг карбон зах зээлийг удирдах, бүртгэлийн системийг удирдах, шилжүүлгийг хянах, нөгөө corresponding adjustment хийх гээд, тэгээд ингээд эд нарыг нь харахаар бодлогыг нь хэн гаргах юм, зөвшөөрлийг нь хэн өгөх юм, бүртгэлийг нь хэн хөтлөх юм, тооцоог нь хэн хийх юм бэ гэдэг нь яг зүгээр одоо байгаа хуулийн төсөл дээр харахаар тийм яг тодорхой бус харагдаад байгаа байхгүй юу. Энэ өөрөө эргээд article 6 буюу маш тодорхой байх үндсэн зарчмыг зөрчиж байх вий дээ гэж санаа зовоод байгаа юм 1 дүгээрт.

2 дугаарт жишээлбэл төсөвтэй холбоотой харилцаан дээр хуулийн 20.3 дээр заагаад өгчихсөн байна. Улсын төсөвт урьдчилан тусгаагүй бол хэрэгжүүлэхгүй гээд оруулчихсан байгаа юм. Гэтэл өнөөдөр бид article 6 харах юм бол Уур амьсгалын ногоон сан /GCF/, нөгөө Дасан зохицох сан /Adaptation Fund/, Хамтарсан кредит олгох механизм /JCM/, 6 дугаар зүйл гээд санхүүжилтүүд төсвөөс ихэвчлэн гадуур шууд орж ирэх нөхцөл байдалтай байдаг. Гэтэл бид төсөвт урьдчилан тусгаагүй бол хэрэгжүүлэхгүй гээд заачихаар энэ чинь өөрөө олон улсын санхүүжилтийг гацаах бас нэг хэлбэр болчих вий дээ. Энэ өөрөө хуулийн зорилготой чинь 1 дүгээрт нийцэж байгаа юм уу гэдгийг асуух гэж байгаа юм, 2 дугаарт?

6 дугаар зүйлийг зүгээр хэтэрхий хуульчлаад өгчихсөн харагдаад байгаа, тэгээд 6 дугаар зүйл чинь өөрөө процедурын хувьд тодорхой нөгөө талуудын бага хурлын үеэр тодорхой шийдвэрүүд гардаг, журам өөрчлөгддөг, тэгтэл манайх хуульчилчихсан байдаг. Ахиад хуулиа бид өөрчлөх вий дээ, жил болгон ийм асуудал үүсэх эрсдэл байх вий дээ л гэж асууя.

Б.Бейсен: Мөнхбат гишүүнийг асуулт асуухаар нэрийг нь нэмье. Болормаа гишүүн хариулъя.

Э.Болормаа: Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя. Энэ хуулийн яг гол голцоо асуудлыг та яг онцлоод асууж байна. Хэн нь яг алийг нь хариуцах юм бэ л гэдэг ийм шинж чанартай. Энэ дээр үндэсний зохицуулагч байгууллага буюу анхан шатны энэ ард талд нь нөгөө презентаци тавиад өгөх боломжтой болов уу. Би Энхгэрэл референтэд явуулчихсан байгаа. Энэ дээр яг зураглалыг нь гаргачихсан байгаа. Үндэсний зохицуулагч байгууллага гэдгийг бид ажлын хэсэг ажиллаад тодорхойлоод яг яамны саналаар буюу ус, цаг уур, орчны шинжилгээний төрийн захиргааны байгууллага буюу өнөөдрийн бид нарын цаг уур гэдгийг мэргэжлийн байгууллага яг энэ тооллого, энэ зүйлүүдээ хийнэ. 6 дугаар зүйлтэй холбоотой тодорхойлолтуудыг бол Эдийн засаг, хөгжлийн яамны санал дээр үндэслэн Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам төрийн захиргааны төв байгууллага олгоно гэсэн ийм ялгаа байгаа гэдгийг хэлье.

Нөгөө таны асуугаад байгаа 6.2-той холбоотой тодорхойлолтуудыг бол үндэсний зохицуулагч байгууллага олгохгүй. Тэгэхээр энэ өнөөдрийн бид нарын оруулж ирж байгаа энэ 30-аад зарчмын зөрүүтэй саналд яг энэ тодорхойгүй байгаа, би бол тантай яг энэ эхний төслийг хараад санал нэг байна. Аль нь яах гээд байгаа нь мэдэгдэхгүй байсныг бол нэлээд эрх, үүргүүдийг нь тодорхой, хэн хэнийгээ хариуцах юм, хэн аль асуудлыг хийхийг оруулсан байгаа.

2 дахь таны асуудал энэ 6 дугаар зүйлийг хэтэрхий, эхлээд энэ 20.3-тай холбоотой. 20.3-ыг бид шинэчлэн найруулсан байгаа. Яг таны асуусан энэтэй холбоотойгоор ингэж урьдчилсан гэдэг нь буруу юм байна гээд. Энэ хуулийг шинэчлэн найруулж, энэ зарчмын зөрүүтэй саналуудын нэгээр орж ирж байгаа. Яг энэ эрсдэлийг хаах үүднээс.

6.2-ыг хэтэрхий хуульчилчихсан юм биш үү гэж. Энэ олон улсын гэрээ хэлэлцээрүүд, бараг 200-аад улс орон санал нэгтгээд, зах зээл нь тодорхойлчихсон байгаа тодорхойлолтуудыг Монгол Улс хэрхэн олгох вэ гэж байгаа болохоос биш заавал энийг олгоно, заавал энийг хийнэ гэсэн утга агуулга биш, яг зах зээлийн шаардаж байгаа юмыг нь Монгол Улсад ийм байдлаар.../минут дуусав/

Б.Бейсен: Гүйцээж хариул гэж байна, 4 асуулт асуусан гэж байна. Болормаа.

Э.Болормаа: 6.2-той холбоотой асуудлыг онцолж хэлье. 6.2 дээр бид яагаад заавал хуульчлах шаардлага үүсэж байгаа юм бэ гэхээр энийг ялгаж олон нийтэд ойлгуулах нь зүйтэй. Нэг нь бол сайн дурын карбон зах зээл, сайн дурын үндсэн дээр энд байгаа карбон нэгжийн 1 тоннтой дүйцэх үнэ нь бол 15-аас 20 доллар ч юм уу. Энэ 6.2, 6.4-өөр албан журмаар олон улсын зохицуулалттай байгаа карбон нэгж нь ойролцоогоор 80 орчим доллароор буюу арай илүү үнэ төлбөртэй. Хүмүүс энийг илүү их сонирхох ийм зах зээл байгаа. Энд яагаад заавал төрийн тодорхой хэмжээний оролцоо, зохицуулалт шаардлагатай вэ гэхээр бид энэ карбон нэгжээ

арилжиж өөр улстай тохиролцоход тэднийхээс хасагдаж тооцох нь манайд нэмэгдэж тооцно. Дэлхийн нэгдсэн агаар мандлын энэ доторх тохируулга учир энд заавал тодорхой хэмжээний төр засгийн бодлого байж, энд хуулийн хэмжээнд зохицуулалтыг нь оруулж ирэх нь зүйтэй юм гэсэн үндсэн дээр энэ.../минут дуусав/

Б.Бейсен: Мөнхбаясгалан гишүүн асуулт асууя.

Л.Мөнхбаясгалан: Хуулийн 1.1 дээр хүлэмжийн хийг тэг ялгаралд хүргэх гэж заасан байгаа. Тэгээд 2050 он гэхэд Монгол Улс хүлэмжийн хийг тэг болгох үүрэг олон улсын гэрээ, хэлэлцээр хаана нэг газар хүлээсэн үү? Энэ их том амбиц байна, бид яг амьдрал дээр чадах уу гээд энийг Болормаа гишүүнээс асууя, бас Одхүү гуайгаас асуучихъя. Маш олон жил энэ тал дээр ажиллаж байгаа туршлагатай хүн орж ирсэн байна.

Б.Бейсен: Болормаа гишүүн хариулъя. Дараа нь Одхүү.

Э.Болормаа: Мөнхбаясгалан гишүүний асуултад хариулъя. Энэ хуулийн үндсэн зорилго дотор байгаль орчин, нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжлийн зорилтод нийцсэн хүлэмжийн хийн тэг ялгаралд хүргэхэд чиглэсэн уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах гэж яг та онцолж хэллээ. Энэ бол Монгол Улсын ямар нэгэн бид тэг ялгаралд хүргэх зорилтгүй Монгол Улс. Энэ юуг хэлээд байна вэ гэхээр дэлхий нийтийн хүлэмжийн хийн тэг ялгаралд хүргэхэд чиглэсэн дэлхий нийтийн зорилт, амбицыг нийтэд нь хэлээд байгаа юм л даа, нөгөө уур амьсгалын өөрчлөлтийн асуудал. Яагаад гэвэл бид нэг агаар мандлаа л хамтдаа, дэлхийн хэмжээнд бол энэ дунд нийт хүлэмжийн хийн асуудлыг ярьж, түүний тэг ялгарлыг ярьж байгаа. Тэр дунд Монгол Улс харин эерэг нөлөө үзүүлэх боломжтой, түүнээсээ тодорхой хэмжээний санхүүжилт байх боломжтой гэдэг үүднээс энэ дэлхийн нэгдсэн хүлэмжийн хийн тэг ялгарлыг хэлж байгаа юм шүү. Одхүү гишүүн нэмээд хариулах уу? Ажлын хэсгээс.

Б.Бейсен: Ажлын хэсгийн 6 номерын микрофон. Битгий дараарай, 6 номерын микрофон.

Д.Одхүү: Асуултад баярлалаа, Мөнхбаясгалан гишүүнд. Монгол Улс 2050 онд хүлэмжийн хийн тэг ялгаралд хүрнэ гэсэн зорилтыг хэдийгээр албан ёсны бичиг баримтад байгаагүй боловч Монгол Улсын Ерөнхийлөгчийн өөрийнх нь олон УИХ дээр зарласан ийм факт гэдэг юм уу мэдээлэл бидэнд бий. Тэгээд Монгол Улсын Ерөнхийлөгчийн хэлсэн үгийг бол тухайн үедээ бол дэлхийн олон улсын НҮБ-ын олон байгууллагууд бол энэ зорилт бол Монгол Улс их зоригтой бөгөөд нэлээн амбицтай ийм зорилт авлаа гэдэг ийм дүгнэлт хийж байсан. Ер нь дэлхийн улс орнуудын бараг дийлэнх хувь нь энэ 2050 он гэхэд тэг ялгарал руу очно гэдэг ийм зорилтууд тавьчихсан учраас энэ хууль дээр хүлэмжийн хийн тэг ялгаралд хүргэх гэдэг энэ зорилтыг бид хуулийнхаа үндсэн ойрын ядаж 20-оос 25 жилийн хугацаанд зорилгоо тавья гэдэг ийм байдлаар томьёолсон гэж би ойлгож байгаа. Энэ дээр Мөнхбаясгалан гишүүн ямар нэгэн өөр тодруулах, томьёолох, нэмж яах санал байвал хүлээж авахад бэлэн байна гэж хэлэх гэсэн юм. Баярлалаа.

Б.Бейсен: Цагаанхүүгийн Мөнхбат гишүүн асуулт асууя.

Ц.Мөнхбат: Энэ нэлээн өргөн хүрээтэй, чухал хууль ингээд хэлэлцэгдэхээр болж байна. Энэ дээр би нэг ийм л юм асуумаар байна ерөнхий. Энэ Уур амьсгалын

өөрчлөлтийн тухай хууль орж ирснээрээ жишээ нь бид ямар, ямар асуудлууд дээр ингээд тодорхой зохицуулалтуудыг хийж чадах вэ гэдгийг арай дэлгэрүүлж асуумаар байна 1 дүгээрт?

2 дугаарт өнгөрсөн хугацаанд энэ хуулийг хийгээгүй байснаараа ямар, ямар зохицуулалтууд хийгдэж чадахгүй өнөөдрийг хүртэл яваад байсан бэ гэдэг ийм. 2 дугаарт нь энэ бүс нутгийн хувьд энэ уур амьсгалын өөрчлөлт, ялангуяа энэ говийн бүс нутгуудад маш их нөлөөлдөг ийм зүйл. Тэр бүс нутагт ажиллаж, амьдарч байгаа тэр хүмүүсийн нийгмийн асуудал, бусад асуудлууд руу чиглэсэн тийм зүйлүүд байна уу энд гэдэг ийм асуултуудыг асууя?

3 дугаарт нь, бид экологийн төслүүд их ярьж байгаа. Энэ нь бол бүгд тэр усны төсөл энэ тэр гээд л. Энэ нь энэ хууль батлагдсанаараа жишээ нь ямар боломж, давуу талууд үүсэх вэ гэдэг ийм 3 асуултад хариулж өгөөч гэж?

Б.Бейсен: Болормаа гишүүн хариулъя.

Э.Болормаа: Мөнхбат гишүүний асуултад хариулъя. Эхний асуулт нь болохоор энэ хууль байгаагүйгээс болоод өнөөдрийг хүртэл бид ямар боломжуудыг алдсан юм уу нөхцөлтэй байна гэж. 1 дүгээрт 2024 онд бид БОАЖЯ-ныхаа нэршлийг өөрчлөөд Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам болгосон. Үүнд ЗГ-ын бүдүүвчид нэршлийн өөрчлөлт орсон боловч бид яг нэгдсэн бодлого, төлөвлөлт, салбар хоорондын уялдаа, хэрхэн зохицуулах талаар нарийн зохицуулалт байгаагүй ирсэн. Тэгэхээр бид энэ асуудалдаа төдийлөн яг жишээлбэл говийн бүсэд ийм хэмжээний уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй сөрөг нөлөөллүүд үзүүлж байна, ийм эмзэг өртөмтгий байна гэдэг нарийн тооцоо, судалгаануудаа нэгдсэн бодлого, уялдаатай гаргаж чадаагүй байсан. Тэгэхээр энэний нэг суурь зохицуулалт нь бол яг хэн, хаана, ямар чиг үүргээр энэ асуудлыг хариуцах вэ гэдэг ийм зүйл байгаа.

2 дахь нэг боломж нь болохоор өнөөдөр яг Монгол Улсын энэ 6.2, 6.4 хэмээх олон улсын карбон зах зээлд нэвтрэх шаардлагатай тодорхойлолтууд нь төр засгийн аль эрх бүхий нэгж нь тэр тодорхойлолтыг гаргадгийг мэддэггүйгээс, байгаагүйгээс болоод магадгүй зарим төсөл хэрэгжүүлэгчид энэ зах зээлд нэвтэрч чадаагүй байсан. Тэгэхээр дэлхийн нөгөө карбон зах зээлээс, яг энэ зохицуулалттай зах зээлээс бид орлого олох боломж тодорхой байгаагүй. Сайн дурын зах зээл дээр бол энэ дээр амжилттай явж ирсэн. Тэгээд бидний JCM, CDM гэдэг ийм зохицуулалттай зах зээлээс одоо тодорхой хэмжээнд явж ирсэн ч энэнээс магадгүй илүү их өндөр боломжууд байсныг бид ашиглаж чадаагүй. Тэгэхээр энэ 2 маань шийдэгдэх буюу боломжууд нээгдэх, үүд хаалга нь нээгдэх гэсэн ийм үндсэн зорилго байгаа. Карбон зах зээлийн хувьд.

Таны 2 дахь асуудал бол, жишээлбэл говийн бүсэд уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй нийгэм, эдийн засгийн гэж онцолж хэлэхэд зөвхөн байгаль орчны биш, иргэдэд тулгамдаж байгаа энэ нийгэм, эдийн засгийн нөлөөллийг бид уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөлөл мөн, энэ зөвхөн байгаль экологийн асуудал биш, үүнтэй дасан зохицох хариу арга хэмжээ авах нь хүртэл энэ дотор тодорхой хэмжээгээр зохицуулагдаж, томъёологдож орж ирж байна гэдэг, эргээд иргэдэд, малчдад бид хариу арга хэмжээ авах нь Монгол Улсын төр засгийн бодлого болоод орж ирж байгаа шүү гэдэг нь бас орж ирж байгаа. Бидний эмзэг, би нөгөө

дараа нь яг засвар дээрээ хаана орсныг хэлье. Анхны хувилбар дээр нь тодорхойлж орж ирээгүй.

3 дахь нь экологийн төслүүд дээр энэ ямар боломжуудыг бий болгох вэ гэж. Жишээлбэл усжуулах төсөл ч юм уу, энэний бүх санхүүжилтийг бид карбон зах зээлээр олоод ирнэ гэж би хэлэхгүй. Харин одоо явж байгаа төслүүд эсхүл бид бэлтгэгдэж байгаа төслүүдийг илүү байгаль орчинд ээлтэй болгосноор тодорхой хувийн санхүүжилтийг нэмж олох боломжуудыг бий болгож байгаа юм, карбон зах зээлээр тодорхой хувь, усны төсөл хэдий шууд.../минут дуусав/

Б.Бейсен: Болормаа гишүүн гүйцээж хариулъя.

Э.Болормаа: Усны төсөл хэдий шууд хүлэмжийн хийн ялгарлыг төдий хэмжээгээр бууруулж байна гэж бид шууд ойлголт байхгүй байгаа ч гэсэн яг нарийн тооцооллоор эхэлбэл тухайн байгаль экологийн системдээ, ойр орчны хөрс, газар, бэлчээртээ шингээлтээр дамжуулж, нөхөн сэргээснийхээ үр дүнд шингээлтээр дамжуулж хүлэмжийн хийн бууруулалтыг бий болгоно гэдэг нарийн тооцооллыг хийх боломж үүссэнээр эдгээр төслүүдэд тодорхой хэмжээний additionality буюу нэмэлт санхүүжилтийг олох, энэ зах зээлээр олох боломж, үүд хаалга нь нээгдэж өгч байна.

Б.Бейсен: Байгаль орчин юмнаас энэ сая 3 дахь асуудалтай холбоотой нэмж хариулах хүн байна уу? Тэр говийн бүсийн юутай холбоотой. 6 номерын микрофон, Одхүү хариулъя.

Д.Одхүү: Уур амьсгалын хууль үндсэн 2, 3 зохицуулалтын эдийн засгийн ач холбогдолтой юм бий. 1 дүгээрт, уур амьсгалын сөрөг нөлөөлөлд дасан зохицох, даван туулах гэсэн энэ хэсэг дээр говийн аймгууд бол Монгол Улсын говийн аймгууд бол хамгийн их хэмжээгээр уур амьсгалын сөрөг нөлөөлөлд өртөж байгаа цөлжилт, тэгээд л бүх төрлийн хөрсний эвдрэл, өвөл бол зуд гэсэн ийм юм байж байгаа. Тэгэхээр дасан зохицох энэ зах зээл дээр эргэлдэж байгаа, хамгийн багаар бодоход 1.5 тэрбум долларын дэлхийн нийтийн энэ дасан зохицох юман дээр явж байгаа, хэрэглэж байгаа санхүүжилтийн энэ юу руу Монгол Улс өөрөө орох боломжийг орно гэсэн үг. Энэ дээр бол саяын Болормаа гишүүний ярьж байгаагаар 2 болон олон талт гэрээнүүдийн үндсэн дээр дасан зохицох энэ төслүүд дээр говийн аймгууд өөрсдийнхөө асуудлыг шийдэх төслүүдийн санхүүжилтээ нэмж татах бололцоо гарна гэж ингэж нэг явж байгаа.

Нөгөө тал дээр карбон зах зээлийн хүрээнд бид ер нь карбоныг бууруулах гэдэг буюу уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах гэдэг ажил дээр бол усны, тэгээд цөлжилтийг багасгах, шинээр ногоон бүсийг бий болгох гэсэн энэ төслүүдийгээ санхүүжүүлэх нэмэлт боломжуудыг гаргачих ийм 2 том чиглэлээр давуу талтай ийм зохицуулалтуудыг бидэнд хийж өгсөн гэж тайлбарлаж байна.

Б.Бейсен: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Ажлын хэсгээс нэг санал ирүүлсэн байгаа. Гишүүд санал хураалтад бэлдээрэй.

Төслийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийн “бодлого,” гэснийг, мөн хэсгийн “бүртгэл” гэснийг тус тус хасах. Санал хураалт. Санал 62.5 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Далайн Батбаяр гишүүнээр тасаллаа. Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүн асуулт асууя.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. 2 дугаар зүйл дээр Байгаль орчныг хамгаалах тухай хууль, энэ хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ гээд биччихсэн байгаа.

Б.Бейсен: Гишүүд сууж байгаарай, санал хураалттай шүү. Отгонбаяр гишүүн, Наранбаатар гишүүн одоо яг санал хураалттай.

Б.Бат-Эрдэнэ: Би цагаа нэмж авъя. Таны яриа явсаар байтал дарлаа.

Б.Бейсен: Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүний цагийг эхнээс нь өгье.

Б.Бат-Эрдэнэ: 2 дугаар зүйл дээр Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, энэ хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ гээд орсон. Байгаль орчныг хамгаалах тухай хуультай нийцэлтэй байх ёстой. Гэтэл энэ дээр Байгаль орчны мэдээллийн сан, Байгаль орчныг хамгаалах тухай хуульдаа байгаль орчны мэдээллийн сан, мониторинг үнэлгээ, байгаль хамгаалах сан гээд аль хэзээний зохицуулагдсан харилцаа байгаа. Энэ хуулийн төсөл дээр болохоороо шинэ платформ, шинэ бүртгэл, шинэ сан гээд ингээд бий болгож байгаа юм. Тэгээд энэ өөрөө Байгаль орчныг хамгаалах тухай хуультайгаа хэр нийцэж байгаа юм, хэр нийцүүлж байгаа юм бэ, яаж ялгаж салгаж ойлгох юм бэ?

Байгаль орчныг хамгаалах тухай хууль 1995 оны хууль, өнгөрсөн 31 жилийн хугацаанд яг ийм хуулийн төслүүд орж ирээд энд тэндээс нь сэглэсээр байгаад Байгаль орчныг хамгаалах тухай хууль маш асуудалтай болсон. Дахиад ийм платформ, бүртгэл, шинэ сан бий болгоод ингээд институцийн давхардал үүсгээд эхэлчихээр цаашдаа бид Байгаль орчныг хамгаалах тухай хуульд байгаа мэдээллийн сан, мониторинг үнэлгээ, байгаль хамгаалах сантай холбоотой харилцаагаараа шийдэх юм уу, эсхүл тусдаа Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хууль дээрээ байгаа энэ шинээр үүсэж байгаа шинэ бүртгэл, шинэ сан, шинэ платформтой харилцаагаараа шийдэх юм уу гэдэг. Зүгээр Уур амьсгалын өөрчлөлтийн хууль нэгэнт анхдагч хуулийн төсөл учраас Байгаль орчныг хамгаалах тухай хуультайгаа нийцүүлээд холбогхож болоогүй юу дагах хуулиар нь ч юм уу тийм асуулт байна? Баярлалаа.

Б.Бейсен: Ажлын хэсэг хэдэн номер хариулах вэ, 5 номерын микрофон.

Ш.Батбаяр: Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам ТНБД Батбаяр. Гишүүний асуултад хариулъя. Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуульд туссан мэдээллийн тогтолцоо нь Байгаль орчны мэдээллийн төвийн одоо байгаа үндэсний платформ руу уялдан ажиллах зарчимтай. Өөрөөр хэлбэл EIC байгаль орчны мэдээллийн нэгдсэн платформ хэвээрээ ажиллана. Харин хуулийн хүрээнд шинээр бол хүлэмжийн хийн тооллого, үндэсний тодорхойлсон зорилтын хэрэгжилт, дасан зохицох арга хэмжээ, уур амьсгалын санхүүжилт, карбон зах зээлийн MRV тайлагнал зэрэг мэдээллийн нэгдсэн тусгай модулиудыг хөгжүүлнэ дэргэд шинээр. Санг бол ерөөсөө database хэлбэрээр ашиглана. Хажууд нь систем ажиллаад тэр

сангаас мэдээллийг татаж авах, бүртгэх, тайлагнах мөн бусад хувийн хэвшилтэй харьцах ажлуудыг систем өөрөө зохицуулна. EIC бол database хэлбэрээрээ ашиглагдана гэсэн үг. Ингээд энэ сан маань платформ, сан 2 маань хоршиж ажиллана гэсэн үг.

Б.Бейсен: Бат-Эрдэнэ гишүүн тодруулъя.

Б.Бат-Эрдэнэ: Тэгэхээр Батбаяр дарга энэ үндэсний платформ, мэдээллийн сан, карбон бүртгэл, үндэсний тооллогын систем гэдэг чинь 4 тусдаа юм уу, эсхүл нэг систем юм уу энийгээ яг тодорхойлоод өгөөч гэж би хэлэх гэж байгаа юм. Үүнээс улбаатай дараагийн үр дагавартай холбоотой асуудлууд яригдана. Үйл ажиллагааны чиг үүрэгтэй холбоотой асуудлууд яригдана. Мөн үргэлжлүүлээд та хэд ингээд MRV-тэй холбоотой нэлээн олон харилцаануудыг оруулаад ирчихсэн, энэтэй холбоотой харилцаа, тэгээд зөрчил гээд ингээд цаашдаа нэлээн үргэлжлэх гээд байна л даа. Тэгэхээр би энэ 4 чинь нэг систем юм уу, 4 тусдаа бүтэц юм уу гэдгийг ойлгомоор байгаа юм.

Б.Бейсен: 5 номерын микрофон, Батбаяр дарга хариулъя. Ажлын хэсгийн 5 номер.

Ш.Батбаяр: Энэ 4 маань Үндэсний платформын маань модулиуд, хэсгүүд гэсэн үг, доторх 4 модуль хэсэг нь гэсэн үг. Тэгэхээр 1 платформ дотроо ажиллана гэсэн үг. Энийг бол Үндэсний зохицуулагч байгууллага удирдан зохион байгуулж ажиллана.

Б.Бейсен: Тодруулах юм уу? Далайн Батбаяр гишүүний асуулт асууя.

Д.Батбаяр: Энэ өдрийн мэндийг хүргэе. Тэгээд энэ бол чухал хууль гэж харж байгаа. Тэгээд энэ хуулийг бол ерөнхийдөө дэмжих ёстой гэж харж байгаа. Тэгээд 2 дугаар зүйл гэдэг нь нөгөө төрийн байгуулалтын тухай явж байгаа учраас энэ дээр тодруулж асууя. Тэгээд УИХ болон ЗГ, Эдийн засаг, хөгжлийн яам, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам гээд тус тусдаа их олон байгууллагууд дээр олон чиг үүрэг нэмэгдэж байгаа юм байна, олон ажлууд хийгдэх ёстой болж таарах юм байна. Тэгэхээр энэ ямар нэгэн бие даасан агентлаг энэ тэр байгуулагдах уу, ажлууд нь ингээд тус тусынхаа яаман дээр байгаад байж болох юм уу? Энэ техникийн хороо, мэргэжлийн зөвлөл байгуулах гэхчихсэн байна. Ийм байдлаар хийж явж байна уу 1 дүгээр асуулт байна?

2 дугаар асуудал нь энэ хууль ингээд энэ байгаа байдлаараа өргөн баригдаад хэлэлцэгдээд батлагдлаа гэхэд санхүү, төсөвтэй холбоотой, татвартай холбоотой ямар нэгэн асуудлууд, нэмж хасагдах асуудлууд байх уу? Бодвол их олон төрлийн тоног төхөөрөмжүүд, янз бүрийн зүйлүүд орж ирж таарах байх. Том зах зээл нээгдэж байна гэж харах байх. Тэгээд энэтэй холбоотой энэ гаалийн болон нэмэгдсэн өртгийн татвар энэ тэр нь ер нь ямархуу байдлаар зохион байгуулах вэ? Энэ дараа дараагийн хариуцсан юмнууд дээр хийгдээд явах юм уу гэдэг дээр дэлгэрэнгүй тайлбар өгчхөөч.

Б.Бейсен: Болормаа гишүүн хариулъя.

Э.Болормаа: Энэ төрийн захиргааны байгууллагуудын чиг үүргийн хүрээнд ямар нэгэн шинэ төрийн байгууллага, бүтэц бол бий болохгүй байгаа. Тэгэхээр

энэтэй холбоотойгоор шинэ төрийн өмчит үйлдвэр ч юм уу ингээд агентлаг үүсээд явахгүй. Одоо байгаа бүдүүвч дотроо ус, цаг уур, орчны асуудлыг хариуцсан төрийн захиргааны байгууллага бол үндэсний зохицуулагч агентлаг болж байгаа. Саяын таны асуусан техникийн хороо бол одоо байдаг Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хорооны дэргэд бол ажиллах ийм Техникийн хороо байгаа.

2 дахь асуудал бол татвартай холбоотой асуудал байна. Татвартай холбоотой асуудлыг хуулиараа бид заавал Төсвийн тухай хуулийг дагалдаж ирэхийн учир энэ хуультай дагалдуулж ямар нэгэн татвартай холбоотой асуудал бол орж ирээгүй гэдгийг бол хариуцлагатайгаар хэлье. Гишүүдээс бол саналууд ирсний нэг нь Лувсанжамц гишүүн бол гэр хороололд байшин дулаалгатай холбоотойгоор татварын буцаан олголт олгох ийм зохицуулалтыг хийж болох уу гэдэг нэлээд бид ярилцсаны үндсэн дээр Төсвийн байнгын хорооны холбогдох албан тушаалтнуудтай ярихад бид татварын хөнгөлөлтийг онцгойлон зааж энд оруулж ирж болохгүй учир бид ногоон санхүүжилтийн нэгэн төрлийг бол татварын хөнгөлөлт болон татварын буцаан олголт гэж үзнэ гэдэг ийм саналын томьёоллыг бол ажлын хэсэг Лувсанжамц гишүүний гаргасан саналыг бол дэмжсэн байгаа.

Б.Бейсен: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Ажлын хэсгээс нэг санал ирүүлсэн байгаа.

Төслийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “Байгаль орчныг хамгаалах тухай хууль,” гэсний дараа “Агаарын тухай хууль,” гэж нэмэх. Санал хураалт. Санал 62.5 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүнээр тасаллаа. Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүн асуулт асууя.

Б.Бат-Эрдэнэ: Түрүүн би нөгөө хариултаа авч чадаагүй. 20.3 дээр 3 дугаар зүйлийн хуулийн үйлчлэх хүрээн дээр уур амьсгалын өөрчлөлтийн хүрээн дэх төр, хувийн хэвшил, санхүүгийн байгууллага болон бусад оролцогч талуудын эрх, үүрэг, тэдгээрийн уялдаа холбоог хангахтай холбогдсон харилцаанд энэ хууль үйлчилнэ гээд. Түрүүн нөгөө төсөвтэй холбоотой асуудал дээр 20.3 дээр хуулийн 6 дугаар бүлгийн ногоон санхүүжилт буюу 20.3 дээр карбон зах зээл, ногоон санхүүжилтийн механизм хэрэгжүүлэхтэй холбоотой төсвийн зардал, татаас, урамшууллыг улсын төсөвт урьдчилан тусгаагүй тохиолдолд хэрэгжүүлэхгүй бөгөөд эдгээр арга хэмжээг улсын төсвийн төлөвлөлт, дунд хугацааны төсвийн хүрээтэй уялдуулан хэрэгжүүлнэ гэдэг ийм заалт орж ирж байгаа юм.

Тэгээд хэдүүлээ ялангуяа энэ хүлэмжийн энэ зах зээлтэй холбоотой асуудал дээр Парисын хэлэлцээрийн 6 дугаар зүйлийн хүрээнд төсвөөс гадуур орж ирдэг зүйлсүүд байгаа. Тэгээд бид өнөөдөр энэ дээрээ хууль дээр улсын төсөвт урьдчилан тусгаагүй тохиолдолд хэрэгжүүлэхгүй гээд ингээд заачихаар нөгөө GCF, Adaptation Fund, JCM гээд эд маань олон улсын санхүүжилтийг саатуулж болзошгүй нөхцөл байдлыг үүсгэж байгаа юм биш биз дээ гэдэг дээр би аягүй их санаа зовж байна. Тэгэхгүй бол энэ чинь заавал улсын төсөвтэй уялдуулж байж, урьдчилсан байдлаар улсын төсөвтэй уялдуулж байж хэрэгжүүлнэ, үгүй бол үгүй гэдэг зарчим тавьчихаж болж байгаа юм уу? Тэрийг хариулаад өгөөч.

Б.Бейсен: Болормаа гишүүн хариулъя.

Э.Болормаа: Бат-Эрдэнэ гишүүнд энэ яг зассан хувилбарыг хүргүүлээд, энэ дээр бид яг таны хэлсэн асуудлыг засах гэж оролдсон. Та энэ томьёолол нь болж байна уу, хэлээд үзээрэй. Тэгээд энэ дээр Ногоон санхүүжилтийн хэлтсийн дарга Пүрэвсүрэн дарга Эдийн засаг, хөгжлийн яамнаас яг онцгойлон энэ асуултад хариулаач гэж хүсье.

Яг бидний хэлэлцэж байгаа асуудал хуулийн үйлчлэх хүрээ буюу энэ дунд бидний ганц оруулсан зорилт юу вэ гэхээр өмнө нь орсон санал дээр бол зөвхөн төр, хувийн хэвшил, санхүүгийн байгууллагын болон бусад оролцогч талуудын эрх, үүргийг зохицуулсан байсан бол бид үүнд иргэн гэдгийг бол нэмж өгсөн байгаа. Ийм зарчмын зөрүүтэй саналыг ажлын хэсэг дэмжиж оруулсан байгаа гэдгийг онцлон хэлье. Энэ бидний хэлэлцэж байгаа 3 дугаар зүйл дээр бол.

Б.Бейсен: Пүрэвсүрэн индрийн микрофоноос хариулъя.

С.Пүрэвсүрэн: Эдийн засаг, хөгжлийн яам Пүрэвсүрэн. Гишүүний асуултад хариулъя. Энэ хуулийн төсөл дээр ирсэн ногоон санхүүжилттэй холбоотой зохицуулалтыг одоо хүчин төгөлдөр байгаа хууль тогтоомж, бодлогын баримт бичгүүдтэйгээ уялдуулаад илүү аж ахуйн нэгж /ААН/ төсөл хэрэгжүүлэгч илүү нээлттэй байхаар оруулсан. Одоо бол ажлын хэсгийн хүрээнд бол энэ таны ярьсан зохицуулалтуудыг хасаад томьёолоод оруулчихсан байгаа.

Б.Бейсен: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Ажлын хэсгээс нэг санал ирүүлсэн байгаа.

Төслийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсгийн “төр,” гэсний дараа “иргэн,” гэж нэмж, мөн хэсгийн “эрх, үүрэг, тэдгээрийн уялдаа холбоог хангахтай холбогдсон” гэснийг “эрх, үүргийг зохицуулсан” гэж өөрчлөх. Санал хураалт. Санал 62.5 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Асуулт асуух гишүүд байхгүй байна. Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүн асуулт асууя.

Б.Бат-Эрдэнэ: Би санал гаргаагүй шүү дээ. Зүгээр л тодорхойлолттой холбоотой юмыг нь л асуучихъя гэсэн. Энэ сааруулалтын үр дүн, карбон нэгж, карбон кредит, ИТМО гээд энэ ерөнхий үр дүн, тооцооны нэгж, арилжаалагдах нэгжтэй холбоотойг яаж яг ойлгож, задалж харж байгаа вэ хууль дээр?

Б.Бейсен: Ажлын хэсгээс хэн хариулах вэ? Сайд хариулах юм уу?

Б.Бат-Эрдэнэ: Бичгээр авчихъя.

Б.Бейсен: Хурдан уншъя, энэ бичгээр авчихъя гэсэн тийм учраас.

Хуулийн төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Асуулт асуух гишүүд байхгүй байна.

Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалтыг, 4.1.3 дахь заалтын “нэг ижил” гэснийг, 4.1.5 дахь заалтын “, болон сайн дурын санаачилгыг хэрэгжүүлэх” гэснийг,

4.1.12 дахь заалтын “Парисын хэлэлцээрийн 6 дугаар зүйлийн дагуу” гэснийг, 4.1.13 дахь заалтыг, 4.1.15 дахь заалтын “зорилгоор ашигладаг” гэснийг, 4.1.16 дахь заалтыг, 4.1.21 дэх заалтын “бодлого,” гэснийг, 4.1.25, 4.1.27 дахь заалтыг, 4.1.30 дахь заалтын “Парисын хэлэлцээрийн 6 дугаар зүйлийн хүрээнд” гэснийг, мөн заалтын “тохируулга хийж” гэснийг, 4.1.40 дэх заалтыг тус тус хасаж, 4.1.3 дахь заалтын “шингээлт, эсхүл” гэснийг “шингээх үйл ажиллагаанаас үүссэн” гэж, 4.1.4 дэх заалтын “тогтвортой” гэснийг “арга хэмжээ” гэж, 4.1.6 дахь заалтын “зах зээлийн тогтолцоо” гэснийг “зах зээлийг” гэж, 4.1.14 дэх заалтын “шингээсэн” гэснийг “хүлэмжийн хийн шингээлтийг нэмэгдүүлсэн” гэж, 4.1.15 дахь заалтын “шаардлагаас” гэснийг “үүргээс” гэж, 4.1.28 дахь заалтын “нэмэр” гэснийг “нэмрийн зорилт” гэж тус тус өөрчилж, 4.1.6 дахь заалтын “худалдах,” гэсний дараа “арилжих, дүйцүүлэх” гэж, 4.1.9 дэх заалтын “үзүүлэлтэд” гэсний дараа “нийцсэн уур амьсгалын санхүүжилтийг хамарсан” гэж, 4.1.20 дахь заалтын “үйлдвэрлэл,” гэсний дараа “үйлчилгээ,” гэж, 4.1.28 дахь заалтын “зохицох” гэсний дараа “даван туулах” гэж, 4.1.30 дахь заалтын “нэмж” гэсний дараа “, эсхүл” гэж, 4.1.32 дахь заалтын “бусад хий” гэсний өмнө “олон улсын гэрээ, стандартаар хүлэмжийн хий гэж хүлээн зөвшөөрөгдсөн” гэж, 4.1.33 дахь заалтын “ой,” гэсний дараа “бэлчээр” гэж тус тус нэмж, мөн зүйлийн 4.1.2, 4.1.7, 4.1.8, 4.1.10, 4.1.11, 4.1.17, 4.1.19, 4.1.22, 4.1.24, 4.1.26, 4.1.31, 4.1.36, 4.1.37, 4.1.38, 4.1.39 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.1.2.“даван туулах” гэж уур амьсгалын өөрчлөлт, аюулт үзэгдэл тулгарахад байгаль орчин, нийгэм, эдийн засгийн тогтолцоо үндсэн чиг үүрэг, өвөрмөц чанар, бүтцээ хадгалан хариу үйлдэл үзүүлэх, сэргээн зохион байгуулагдах, дасан зохицох чадавхыг;

4.1.7.“карбон кредит” гэж эзэмших, ашиглах, захиран зарцуулах боломжтойгоор баталгаажсан, бүртгэгдсэн карбон нэгжийг;

4.1.8.“карбон нэгж” гэж сааруулалтын үр дүнг нэг тонн нүүрстөрөгчийн давхар ислийн тэнцэлд нийцсэн байдлаар илэрхийлсэн тооцооллын нэгжийг;

4.1.10.“ногоон таксономи” гэж эдийн засгийн үйл ажиллагаа, төсөл, хөтөлбөр, арга хэмжээг байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэхгүй байдлаар нь ангилах, ногоон болон уур амьсгалын санхүүжилтэд хамрагдахыг тодорхойлсон шалгуур, ангиллыг;

4.1.11.“олон талт карбон зах зээл” гэж олон улсын гэрээ, шийдвэрийн хүрээнд төвлөрсөн зохицуулалтаар хэрэгжих, олон улсад шилжүүлэн тооцох сааруулалтын үр дүнг бий болгох, бүртгэх, шилжүүлэх, худалдах, арилжих, дүйцүүлэх, ашиглах үйл ажиллагааг зохицуулсан зах зээлийг;

4.1.17.“уур амьсгалын өөрчлөлт” гэж байгалийн хүчин зүйл, хүний үйл ажиллагааны улмаас дэлхийн агаар мандлын хийн бүрэлдэхүүн өөрчлөгдсөнөөс үүдэн уур амьсгалд урт хугацаанд гарч буй өөрчлөлтийг;

4.1.19.“уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөлд өртөмтгий хүн амын бүлэг” гэж уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөлөлд өртөх эрсдэлтэй, нийгэм, эдийн засаг, эрүүл мэнд, газар зүйн байршлын улмаас түүнд дасан зохицох, даван туулах чадавх хязгаарлагдмал хүн амын бүлгийг;

4.1.22.“уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөлөл” гэж уур амьсгалын өөрчлөлтийн улмаас хүний эрүүл мэнд, байгаль орчин, нийгэм, эдийн засгийн үйл ажиллагаанд үзүүлэх сөрөг өөрчлөлтийг;

4.1.24.“уур амьсгалын санхүүжилт” гэж уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох үйл ажиллагааг дэмжихэд чиглэсэн олон улсын, үндэсний болон орон нутгийн түвшинд төр, хувийн хэвшил, бусад эх үүсвэрээс бүрдсэн хөрөнгө оруулалт, санхүүжилтийг;

4.1.26.“үндэсний карбон зах зээл” гэж үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилтыг хангах хүрээнд хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, ялгарахаас урьдчилан сэргийлэх, шингээлтийг нэмэгдүүлэх үйл ажиллагааны үр дүнд үүссэн карбон кредитийг бүртгэх, шилжүүлэх, худалдах, арилжих, дүйцүүлэх, ашиглах замаар зохицуулсан зах зээлийг;

4.1.31.“хоёр талт карбон зах зээл” гэж улс хоорондын хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжих олон улсад шилжүүлэн тооцох сааруулалтын үр дүнг бий болгох, бүртгэх, шилжүүлэх, худалдах, арилжих, дүйцүүлэх, ашиглах үйл ажиллагааг зохицуулсан зах зээлийг;

4.1.36.“хүлэмжийн хийн ялгарлаас урьдчилан сэргийлэх” гэж тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлээгүй тохиолдолд үүсэх байсан хүлэмжийн хийн ялгарлаас зайлсхийхэд чиглэсэн үйл ажиллагааг;

4.1.37.“хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах” гэж хүлэмжийн хийн ялгарлын хэмжээг багасгахад чиглэсэн үйл ажиллагааг;

4.1.38.“хүлэмжийн хийн ялгарлын тэнцэл” гэж тайлант хугацаанд үүссэн хүлэмжийн хийн нийт ялгарлаас бууруулалт, урьдчилан сэргийлсэн ялгарал болон шингээлтийг хасан гарах цэвэр дүнг;

4.1.39.“хэмжилт, тайлагнал, баталгаажуулалт” гэж хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, урьдчилан сэргийлэх, шингээлтийг нэмэгдүүлэх үйл ажиллагааны үр дүнг батлагдсан аргачлалын дагуу хэмжих, үр дүнг тайлагнах, тайлагнасан мэдээллийг хөндлөнгийн итгэмжлэгдсэн этгээдээр шалгуулан баталгаажуулах үйл ажиллагааг,” гэж өөрчлөх. Санал хураалт. Санал 56.3 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 5 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Байхгүй байна. Ажлын хэсгээс нэг санал ирүүлсэн байгаа.

Төслийн 5 дугаар зүйлийн 5.1.3 дахь заалтын “салбар,” гэсний дараа “хүн амын” гэж нэмж, 5.1.5 дахь заалтын “шинжлэх ухаанд үндэслэх” гэснийг “шинжлэх ухаан, инновацад суурилах” гэж, 5.1.9 дэх заалтын “мэдлэг, инновацад суурилсан дэвшилтэт технологийг” гэснийг “мэдлэгийг” гэж тус тус өөрчилж, 5.1.6 дахь заалтыг, 5.2 дахь хэсгийг тус тус хасаж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 5.1.1 дэх заалт нэмэх:

“5.1.1.эдийн засгийн үр ашигтай байх;” Санал хураалт. Санал 56.3 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 6 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Асуулт асуух гишүүд байхгүй байна.

Б.Бат-Эрдэнэ: 6.Төслийн 6 дугаар зүйлийн 6.1.3 дахь заалтын “олон улсын өмнө хүлээсэн үүргийн хүрээнд боловсруулах тайлан, илтгэлийг танилцах” гэснийг “тайлан, илтгэлийг сонсож, хэлэлцэх” гэж өөрчилж, мөн зүйлийн 6.1.4 дэх заалтын “бүрэн эрх” гэснийг хасах.

Б.Бейсен: Санал хураалт. Санал 56.3 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 7 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Асуулт асуух гишүүд байхгүй байна.

Б.Бат-Эрдэнэ: 7.Төслийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалтын “нэмэр” гэснийг “нэмрийн зорилт” гэж, 7.1.5 дахь заалтын “хөтөлбөрийг тодорхойлсон” гэснийг “хөтөлбөрт зориулсан” гэж, 7.1.9 дэх заалтын “санхүүжилтийн орлогын урсгалыг” гэснийг “санхүүжилтийг” гэж, 7.1.10 дахь заалтын “ажиллагааг удирдах зохицуулах” гэснийг “ажиллагааны” гэж тус тус өөрчилж, мөн зүйлийн 7.1.3 дахь заалтын “энэ хуульд заасан асуудлаар” гэснийг, 7.1.6 дахь заалтыг, 7.1.8 дахь заалтын “хүлэмжийн хийн ялгарлын бууралт, шингээлтийн үр дүнг тооцох, баталгаажуулах, тайлагнахтай холбоотой” гэснийг, 7.1.9 дэх заалтын “ногоон болон уур амьсгалын санхүүжилтийн орлогын урсгал, үр ашиг, зарцуулалтыг бүртгэх, хянах, тайлагнах, цаашдын төлөвлөлтийг хангах, олон улсын тайлагнал болон ил тод байдлыг хэрэгжүүлэхтэй холбоотой” гэснийг, 7.1.10 дахь заалтын “энэ хуулийн 4.1.27-д заасан” гэснийг, 7.1.11 дэх заалтын “бүрэн эрх” гэснийг тус тус хасах.

Б.Бейсен: Санал хураалт. Санал 56.3 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 8 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу, нэрсээ өгнө үү? Асуулт асуух гишүүд байхгүй байна.

Б.Бат-Эрдэнэ: 8.Төслийн 8 дугаар зүйлийн 8.1.2 дахь заалтын “ногоон хөрөнгө оруулалтын бодлого,” гэснийг 8.1.5 дахь заалтыг тус тус хасаж, мөн зүйлийн 8.1.1, 8.1.3 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“8.1.1.Монгол Улсын хөгжлийн урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичигт уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох, даван туулах асуудлыг уялдуулан боловсруулах;

8.1.3.ногоон санхүүжилтийн стратегийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран боловсруулах;”

Б.Бейсен: Санал хураалт. Санал 56.3 хувиар дэмжигдлээ. 9 дэх санал.

Б.Бат-Эрдэнэ: Төслийн 8 дугаар зүйлийн 8.2.1 дэх заалтын “төлөвлөгөө,” гэснийг хасаж, 8.2.2 дахь заалтын “удирдах” гэснийг “зохицуулах, хяналт тавих” гэж өөрчилж, 8.1.4 дэх заалтыг 8.2.1 дэх заалт болгон өөрчилж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 8.2 дэх хэсэг нэмэх:

“8.2.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:”

Б.Бейсен: Санал хураалт. Санал 56.3 хувиар дэмжигдлээ. 10 дахь санал.

Б.Бат-Эрдэнэ: Төслийн 8 дугаар зүйлийн 8.2.5, 8.2.6, 8.2.8 дахь заалтын “хөтөлбөрт” гэсний дараа “эдийн засгийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн” гэж, 8.2.7 дахь заалтын “шилжүүлэгт” гэсний дараа “эдийн засгийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн” гэж тус тус нэмж, 8.2.13 дахь заалтын “зарцуулалтыг хариуцан удирдаж,” гэснийг “зарцуулалтад” гэж, 8.2.15 дахь заалтын “, мэдээлэл цуглуулах, боловсруулах, тайлагнахтай холбоотой үйл ажиллагаа, аргачлал, зохицуулалтын уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөл, эмзэг байдал, эрсдэлийн үнэлгээ хийх журам” гэснийг “аргачлал, журам” гэж тус тус өөрчилж, 8.2.9 дэх заалтыг, 8.2.14 дэх заалтын “Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилтын хэрэгжилтийн үр дүнг тооцох, мэдээлэл цуглуулах, нэгтгэх, тайлагнах, баталгаажуулах үйл ажиллагааны нэгдсэн аргачлал, зохион байгуулалтын” гэснийг, 8.2.18, 8.2.19 дэх заалтыг тус тус хасаж, мөн зүйлийн 8.2.4, 8.2.16, 8.2.17, 8.3.1, 8.4.5 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“8.2.4.олон талт карбон зах зээлийн үйл ажиллагаанд зөвшөөрсөн тухай тодорхойлолт олгох, оролцогч этгээдийг бүртгэх, хяналт тавих;

8.2.16.энэ хуулийн 7.1.8-д заасан журмын төслийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран боловсруулж, батлуулах;

8.2.17.энэ хуулийн 7.1.6, 7.1.7, 7.1.9-т заасан журмын төслийг боловсруулж, батлуулах;

8.3.1.энэ хуулийн 6.1.1, 7.1.1-д заасны дагуу уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох, даван туулах арга хэмжээг салбарын хэмжээнд тодорхойлж, улсын төсөвт тусгуулах, хэрэгжилтийг зохион байгуулах, тайлагнах;

8.4.5.салбарын хэмжээнд Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилтын хэрэгжилтийг хангах, хүлэмжийн хийн ялгарлын тооллоготой холбоотой өгөгдөл, мэдээллийг цуглуулах, тайлагнах үйл ажиллагааг хэрэгжүүлэх;”

Б.Бейсен: Санал хураалт. Санал 56.3 хувиар дэмжигдлээ. 11 дэх санал.

Б.Бат-Эрдэнэ: Төслийн 8 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 8.2.18 дахь заалт нэмэх:

“8.2.18.сааруулалтын үр дүнг тооцох аргачлал, стандарт, ялгарал болон шингээлтийн итгэлцүүрийг Уур амьсгалын өөрчлөлтийн Үндэсний хорооны дэргэдэх техникийн хороогоор хэлэлцүүлж, түүний дүгнэлтэд үндэслэн батлах;”

Б.Бейсен: Санал хураалт. Санал 56.3 хувиар дэмжигдлээ. Хуулийн төслийн 9 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Байхгүй байна. Ажлын хэсгээс 1 санал ирүүлсэн байгаа. 12.

Б.Бат-Эрдэнэ: Төслийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“9.1.Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тухайн шатны Засаг даргын өргөн мэдүүлсэн Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилтод нийцсэн уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицоход чиглэсэн аймаг, нийслэлийн төлөвлөгөө болон түүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах төсвийг батлан санхүүжүүлж, гүйцэтгэлд хяналт тавина.”

Б.Бейсен: Санал хураалт. Санал 56.3 хувиар дэмжигдлээ. Хуулийн төслийн 10 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Асуулт асуух гишүүн байхгүй байна. Ажлын хэсгээс 1 санал ирүүлсэн байгаа.

Б.Бат-Эрдэнэ: Төслийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсгийн ““8.2-т заасан байгууллагаар” гэснийг “8.3.14-т заасан журмын дагуу” гэж өөрчилж, мөн зүйлийн 10.2 дахь хэсгийн “6.1.1, 7.1.1, 10.1-д заасантай уялдуулан тухайн нутаг дэвсгэрийн хэмжээнд төлөвлөгөөг” гэснийг “6.1.1, 7.1.1, 9.1-д заасантай уялдуулан тухайн нутаг дэвсгэрийн уур амьсгалын өөрчлөлтийн үйл ажиллагааны төлөвлөгөө” гэж өөрчлөх.

Б.Бейсен: Санал хураалт. Санал 56,3 хувиар дэмжигдлээ. Хуулийн төслийн 11 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Асуулт асуух гишүүн байхгүй байна. Мөнхбаясгалан гишүүн асуулт асууя.

Л.Мөнхбаясгалан: 11 дүгээр зүйл дээр төрийн захиргааны байгууллага, агентлагийн статустай үндэсний зохицуулагч байгууллага гэдгийг шинээр байгуулж байгаа юм байна. Дагах хуулиараа Агаарын тухай хуульд өөрчлөлт оруулаад Уур амьсгалын үндэсний хороог татан буулгаж байгаа юм байна. Энэ Уур амьсгалын үндэсний хороо чинь Шадар сайд даргалдаг, тийм ээ? Ямар үндэслэлээр энэ хороог татан буулгаж байгаа юм бэ? Муу ажилласан юм уу, ажил нь шаардлагагүй гэж үзсэн юм уу? Угаасаа Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд ЦУОШГ, нөгөөдөх нь Ойн газар, Усны газар гэсэн 3 агентлаг байж байгаа шүү дээ. Тэгэнгүүт дахиад нэг агентлаг байгуулж байна шүү дээ. Энэ нь улам данхайх биш үү? Ийм 2 асуулт.

Б.Бейсен: Болормаа гишүүн хариулъя.

Э.Болормаа: Мөнхбаясгалан гишүүний асуултад хариулъя. ЗГ-аас өргөн мэдүүлсэн хувилбар дээр бол уншигдахад яг дахиад нэг байгууллага байгуулагдаж байгаа мэт уншигдсан. Тэгэхээр бид энийг тодорхой болгоод яамтай хэлэлцээд бид шинэ байгууллага байгуулахгүй. Ус, цаг уур, орчны хяналт шинжилгээний асуудал эрхэлсэн байгууллага буюу цаг уур дээрээ энийгээ хийнэ гэж бодож байгаа учир бид энэ өөрчилсөн, одоо санал хураалгах гээд байгаа ажлын хэсгийн өөрчлөлтүүд бол яг энэ Үндэсний зохицуулагч байгууллага нь ус, цаг уур, орчны хяналт шинжилгээний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага байх болно гэдгийг баталгаажуулчхаж байна. Тэгэхээр түрүүн би өөрчлөн биш, яг тэрний харьяандаа энэ чиг үүргийг цаг уур хариуцна гээд түрүүн Далайн Батбаяр гишүүний асуултад хариулснаар бид ямар нэгэн шинэ байгууллага үүгээр байгуулахгүй байгаа.

2 дахь асуулт буюу таны үндэсний хороотой холбоотой асуудал дээр энд одоо уншигдаж байгаагаар бол энийг татан буулгаж байгаа мэт нөгөө байхгүй учир,

тэгж уншигдаж байгаа учир түрүүний бид нарын сая та бүхний маань дэмжиж санал өөрчлөлтийг дэмжсэн асуудал дээр бол энэ ЗГ-ынхаа үйл ажиллагаанд хэвээр нь үлдээхээр эргэн найруулж оруулсан байгаа.

Б.Бейсен: Энэ 40-өөд санал байгаа. Миний хоолой хатаад байгаа учраас энэ саналыг Бат-Эрдэнэ гишүүнээр уншуулж байгаа шүү. Хуулийн төслийн 11 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Асуулт асуух гишүүн байхгүй байна.

Б.Бат-Эрдэнэ: Төслийн 11 дүгээр зүйлийн 11.1.7 дахь заалтын “уур амьсгалын” гэсний дараа “өөрчлөлтийн” гэж нэмж, мөн зүйлийн 11.1 дэх хэсгийн “байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын чиг үүргийн хүрээнд” гэснийг “Цаг уур, орчны хяналт шинжилгээний асуудал эрхэлсэн” гэж, 11.1.2 дахь заалтын “нэмэр” гэснийг “нэмрийн зорилт” гэж, “хариуцсан зохих байгууллагад” гэснийг “байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хянуулахаар” гэж, 11.1.3 дахь заалтын “удирдах” гэснийг “удирдлага, зохион байгуулалтаар хангах” гэж тус тус өөрчилж, 11.1.6 дахь заалтын “Парисын хэлэлцээрийн шаардлагад нийцүүлэн” гэснийг, 11.1.10 дахь заалтын “бүрэн эрх” гэснийг тус тус хасаж, 11.1.9 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“11.1.9.сааруулалтын үр дүнгийн урт хугацааны хадгалалт алдагдах, хэтрүүлэн тооцож шилжүүлэх, байгалийн болон бусад хүчин зүйлээс шалтгаалан буцаан алдагдах эрсдэлийг бууруулах зорилгоор төсөл, хөтөлбөрөөс үүссэн баталгаажсан сааруулалтын үр дүнг тооцож, энэ хуулийн 7.1.6-д заасан журмын дагуу карбон кредитийг байршуулж, буцаан олгох, удирдлага, хяналтыг хэрэгжүүлэх.”

Б.Бейсен: Санал хураалт. Энэ миний юу ажиллаагүй учраас саяын санал хураалтыг хүчингүй болгох санал хураалт явуулъя. Санал хураалт. Хүчингүй болгох санал 56.3 хувиар дэмжигдсэн тул дахин санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал 56.3 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 12 дугаар зүйлтэй холбогдуулаад асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Байхгүй байна. 15 дахь санал.

Б.Бат-Эрдэнэ: Төслийн 12 дугаар зүйлийн 12.1, 12.2, 12.3, 12.4, 12.5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“12.1.Ус, цаг уур, орчны хяналт шинжилгээний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь уур амьсгалын өөрчлөлтийн өнөөгийн төлөв байдлын үнэлгээг жил тутам, уур амьсгалын өөрчлөлтийн ирээдүйн чиг хандлага, нөлөөллийн үнэлгээг таван жил тутам боловсруулж, үнэлгээний дүнг нэгтгэн байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

12.2.Энэ хуулийн 8.3.14-д заасан журмын дагуу уур амьсгалын өөрчлөлтөөс үүсэх бодит болон болзошгүй сөрөг нөлөөлөл, эмзэг байдал, эрсдэлийн үнэлгээг нийгэм, эдийн засгийн салбар, бүс нутаг тус бүрээр холбогдох төрийн захиргааны төв байгууллага, төрийн захиргааны байгууллага, орон нутгийн байгууллага нь Ус,

цаг уур, орчны хяналт шинжилгээний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон эрдэм шинжилгээний байгууллагатай хамтран гүйцэтгэнэ.

12.3.Энэ хуулийн 12.2-т заасан үнэлгээний үр дүнг нэгтгэн дүгнэж, шинжлэх ухаанд суурилсан уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах болон дасан зохицох арга хэмжээний бодлого, төлөвлөлтийг тодорхойлно.

12.4.Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөл, эмзэг байдал, эрсдэлийн үнэлгээний үр дүнг үндэсний, бүс нутгийн, салбарын болон орон нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөлт, Үндэсний дасан зохицох төлөвлөгөөг боловсруулахад ашиглана.

12.5.Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөл, эмзэг байдал, эрсдэлийн үнэлгээний үр дүнг уур амьсгалын өөрчлөлтийн Үндэсний платформоор дамжуулан олон нийтэд нээлттэй мэдээлнэ.”

Б.Бейсен: Санал хураалт. Санал 56.3 хувиар дэмжигдлээ. Төслийн 12 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 12.6 дахь хэсэг нэмэх:

“12.6.Төрийн захиргааны байгууллага Гамшгаас хамгаалах тухай хуулийн 20.3-т заасан журмын дагуу Уур амьсгалын өөрчлөлтийг даван туулах, нөлөөллөөс үүдэн гарах эдийн засгийн болон эдийн засгийн бус гарз хохирлын үнэлгээг хийнэ.” Санал хураалт. Санал 56.3 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 13 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Байхгүй байна. 17.

Б.Бат-Эрдэнэ: Төслийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсгийн “баталгаажуулахаар” гэснийг “хянуулахаар” гэж, 13.3 дахь хэсгийн “коэффициентыг” гэснийг “итгэлцүүрийг” гэж, мөн зүйлийн 13.4 дэх хэсгийн “боловсруулж, тогтмол хугацаанд шинэчилнэ” гэснийг “боловсруулна” гэж, 13.5 дахь хэсгийн “аргачлалыг” гэснийг “аргачлал, ялгарал болон шингээлтийн итгэлцүүрийг” гэж, мөн хэсгийн “энэ хуулийн 8.2-т заасан байгууллага” гэснийг “байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран” гэж, 13.8 дахь хэсгийн “хүргүүлж” гэснийг “гаргаж” гэж тус тус өөрчилж, 13.4 дэх хэсгийн “бодлого,” гэснийг, 13.8 дахь хэсгийн “хүлэмжийн хийн ялгарал, шингээлтийн ил тод байдлын тайлангийн хамтаар” гэснийг хасах.

Б.Бейсен: Санал хураалт. Санал 56.3 хувиар дэмжигдлээ. Хуулийн төслийн 14 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Асуулт асуух гишүүд байхгүй байна. 14-ийг хэлсэн. Хуулийн төслийн 15 дугаар зүйлтэй холбогдуулаад асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Мөнхбаясгалан гишүүн асуулт асууя.

Л.Мөнхбаясгалан: Энэ 15 дугаар зүйл дээр энэ нөгөө зарчмын зөрүүтэй санал орж ирж байгаа юм байна, тийм үү? Тэгэхээр 15 дугаар зүйл дээр ингэж байгаа байхгүй юу. Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, бусад хуулийн этгээд нь үйл ажиллагаанаас үүдэн ялгарах хүлэмжийн хийн ялгарлыг тооцож, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөл, эмзэг байдал, эрсдэлийн үнэлгээг хийж болно гэж байгаа, болохгүй ч байж болно. Хийнэ гэж оруулбал яадаг юм бол? Уг нь тэгсэн

бол. Танай энэ Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийн чинь үзэл баримтлалд хамгийн гол нь гоё юм ингэж хэлсэн уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөллийн үр дүнд усны хомсдол бий болж, мөнх цас, мөсөн голууд ширгээд байна. Ийм, ийм хэдэн тонны булаг шанд ингээд ширгэчихсэн байна гэж байгаа байхгүй юу. Тэгэхээр надад бол байна шүү дээ, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөлд орсон газар нутаг, усны нөөц, байгалийн экосистемийг нөхөн сэргээх, нөхөн төлбөр төлөх талаар ямар зохицуулалт орох юм бэ?

Тэгсэн хэр нь би нөгөө 3 юм өгчихсөн дээр чинь төөрөөд байна л даа. Зарчмын зөрүүтэй саналаар бол танайх энэ төгсгөлийн өгүүлбэрээ аваад хаячхаж байгаа юм байна, тийм ээ? Тийм, гэснийг хасах гэж байгаа байхгүй юу. Энэ яагаад ингээд хасчхаж байгаа юм, зарчмын зөрүүтэй саналаар? Ингээд 3 янзын юм яг гар дээр байгаад байна. Энийг надад тайлбарлаад өгөөч.

Б.Бейсен: Болормаа гишүүн хариулъя, хэн хариулах вэ? Ажлын хэсгээс, 5 номерын микрофон, Батбаяр дарга хариулъя.

Ш.Батбаяр: Энэ чуулганы хуралдааны үеэр асуугдаж байсан асуулт байна. Тэгэхээр яг "хийнэ" гээд албадлагын чанартай болчихоор яг манайд энэ зах зээл маань шинэ тутам хөгжиж байгаа, мэргэжилтэн байхгүй, тоног төхөөрөмж байхгүй, холбогдох суурь дэд бүтэц сул байгаа учраас энэ ялангуяа жижиг ААН-үүдэд бол томоохон дарамт болчхож байгаа юм, санхүүгийн.

Мөн ТӨК-ууд маань ч гэсэн яг дээр нь бол уур амьсгалын өөрчлөлт хариуцсан мэргэжилтэн тусгайлан авах хэрэг гарч байгаа юм. Тэгээд бүтэц, орон тоо гээд нэмэгдэнэ. Тэгэхээр одоо шилжилтийн үед бол энийг тусгайлан заах шаардлагагүй, эхний ээлжид дэмжих хэрэгтэй гэдэг утгаар оруулж ирсэн. Ер нь бол "хийнэ" гээд заах юм бол давуу тал бол байгаа, эрсдэлийг заавал үнэлдэг болох. Гэхдээ яг өнөөдрийн байдлаар манайд бол байгууллагууд маань яг тийм чадавх байхгүй байгаа учраас шилжилтийн үед бол энийг түрдээ заавал бишээр байлгах.

Б.Бейсен: Мөнхбаясгалан гишүүн тодруулъя.

Л.Мөнхбаясгалан: Гол заалт, үзэл баримтлалаасаа буцаж байгаа байхгүй юу даа та нар. Одоо юм ярихаар л өмнөөс манайд тийм ч мэргэжилтэн байхгүй, ийм ч аргачлал байхгүй гээд байдаг, наадхаа хийх ёстой биз дээ? Жишээ нь энэ 15 дугаар зүйлд хуулийн этгээд гэдэг дотор чинь уул уурхай, үйлдвэрүүд орж байгаа байхгүй юу. Эдний үйл ажиллагаанаас ялгарсан хүлэмжийн хийг хэрхэн тооцох юм? Тэгээд яг гол өгүүлбэрээ танайх аваад хаячихлаа шүү дээ. Энэ дээр бол дэмжмээргүй байна 15-ыг. Гишүүд хар даа энэ олон юм уншаад байгаа болохоор ингээд зарим нь шууд дараад байгаа байхгүй юу. Энэ хамгийн гол амин заалтаа та нар өөрсдөө энд уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөнөөс болоод ямар, ямар эрсдэл үүрч байгааг энэ хуулийнхаа үзэл баримтлалд шингээчхээд, одоо яг гол юмаа буцаагаад аваад хаячхаж байгаа байхгүй юу. Тэгээд энэ ТНБД нь даргаараа л хэлүүлж байна л даа. Ингээд дандаа буцалт хиймээргүй байна. Энүүгээр чинь оруулаад, аргачлалаа боловсруулаад, боловсон хүчинтэй болох ёстой байхгүй юу даа. Буцлаа шүү дээ одоо.

Б.Бейсен: Одхүү хариулъя, 6 номерын микрофон.

Д.Одхүү: Би Мөнхбаясгалан гишүүний ярьж байгаа санаа зовж байгаа юмтай санал нэг байна. Тэгээд ийм гарц байж болох уу гишүүнээ? Таны яг энэ юугаар тэр бүгдээр нь байж болно биш, байна гэдгээр нь заагаад үгийг нь үлдээхээд тэгээд энэ заалтынхаа хэрэгжих хугацааг нь нөгөө бид тийм практиктай болчихсон Их Хурал хэрэгжих хугацаагаа нэг жилийн дараагаас ч байдаг юм уу, хэрэгжинэ гэдгээр тавьчихвал, ер нь ухрахгүйгээр зоригтой шаардлага тавих гэдэгтэй Мөнхбаясгалан гишүүнтэй санал нэгдэж байгаа учраас одоогийн байгаа чадавх бэхэжтэл нь хэрэгжих хугацааг нь жоохон хойшлуулсан байдлаар хуульдаа томьёолчихвол болох уу л гэж санал оруулж байгаа шүү, чиглэлээр нь.

Б.Бейсен: Сайд ямар саналтай байна вэ, ийм маргаантай юм дээр? Сандаг-Очир сайдын микрофон өгье.

Ц.Сандаг-Очир: Манай яам бол яг энэ чиглэлээр уур амьсгалын өөрчлөлт, хүлэмжийн хийн ялгарлыг тооцох, тайлагнах, бүртгэх энэ чиглэлийн боловсон хүчин манай хуулийн этгээдүүд дээр бол хомс байгаа яг үнэнийг хэлэхэд. Тийм учраас бид хууль дээр хатуу ингээд байна гээд оруулчихаар шууд хууль хэрэгжээд эхлэхээр заавал ийм боловсон хүчин, хүний нөөцийн асуудал хөндөгдөнө, зайлшгүй тийм боловсон хүчин авах хэрэгцээ, шаардлага гарна. Та бүхэн, Одхүү зөвлөх ч ярьж байна шууд хэрэгжихэд бол хэцүү, тодорхой хугацаа өгөөд, тэр хугацаанд нь хуулийн этгээдүүд боловсон хүчнээ бэлтгэх энээ тэрээ тийм гарц гаргалгаа бол байж болно. Тэрнээс шууд одоогийнхоор ингээд байна гээд хууль батлагдангуут хэрэгжихээр, ингэчихвэл ер нь бол хуулийн этгээдүүдэд компаниудад энэ бол хүндрэл гарна шүү, боловсон хүчний асуудал. Тэгээд хаана хүнээ, боловсон хүчнээ бэлтгэх вэ, бэлтгэсэн боловсон хүчин байна уу, үгүй юү гээд.

Б.Бейсен: Болормаа гишүүн хариулъя.

Э.Болормаа: Мөнхбаясгалан гишүүний саналыг ойлголоо. Тэгээд энийг сая сайд ч дэмжээд, бид энийг нэмж, одоо орсон бидний саналын өөрчлөлт юу вэ гэхээр, шууд байгаа бүх ААН-ийн байгаль орчны нөлөөлөл рүү ингээд оруулна гээд. Энэ өөрөө тусгай зохицуулалттай явж байгаа байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд нь ямар нэгэн тооцоололгүйгээр шууд уур амьсгалын асуудлыг оруулчихаар бид энэ бэлэн биш юм болов уу гээд яг онцгойлон тэрийг хассан юм байгаа. Гэхдээ хэрвээ та бүхэн энэ саналыг дэмжвэл ажлын хэсгийн зүгээс энийг гүйцээн боловсруулах чиглэл хүсээд, саяын агуулга дундаас болох талаас нь бид хамтран ажиллая гэсэн саналтай байна.

Б.Бейсен: Мөнхбаясгалан гишүүн тодруулъя.

Л.Мөнхбаясгалан: Яах вэ, одоо дэмжээд чуулган дээр гүйцээн боловсруулахаар авъя гэж байна шүү дээ. Энэ хуулийн аягүй чухал заалт байхгүй юу, мэдэж байгаа тийм ээ. Жишээ нь хүлэмжийн хийн ялгарлыг тооцож, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөл, эмзэг байдал, эрсдэлийн үнэлгээ хийх ёстой. Тэгээд дараа нь одоо энэ хасагдаж байгаа заалт чинь аягүй чухал. Тэгвэл гүйцээн боловсруулахад авна гэж тооцоод дэмжих үү?

Б.Бейсен: Энэ саналыг гүйцээн боловсруулахаар чуулганд яахаар тохирлоо шүү. Төслийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсгийн “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх тохиолдолд холбогдох хуульд заасны дагуу хүлэмжийн хийг

бууруулах арга хэмжээг байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгана.” гэснийг хасах. Санал хураалт. Санал 56.3 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 16 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Асуулт асуух гишүүд байхгүй байна. Бат-Эрдэнэ гишүүн 19 дэх саналыг танилцуулъя.

Б.Бат-Эрдэнэ: Төслийн 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсгийн “санхүүжилтийг тодорхойлон” гэснийг “санхүүжүүлэн” гэж, 16.6 дахь хэсгийн “өөрчлөлтөд дасан зохицох, даван туулах” гэснийг “өөрчлөлтийн талаар” гэж тус тус өөрчилж, 16.4 дэх хэсгийн “, ирээдүйд учирч болзошгүй байгалийн гамшигт үзэгдэлд өртөх эрсдэл өндөртэй байгаа” гэснийг хасаж, 16.1, 16.4, 16.6 дахь хэсгийн доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“16.1.Үндэсний зохицуулагч байгууллага энэ хуулийн 12.3, 12.4-т заасан үнэлгээний үр дүнд үндэслэн Үндэсний дасан зохицох төлөвлөгөөг Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилтод нийцүүлэн тухайн салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран боловсруулна.

16.4.Холбогдох төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэлийн Засаг дарга энэ хуулийн 4.1.16, 4.1.17-д заасан уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөлд өртөмтгий салбар, хүн амын бүлгийн дасан зохицох, даван туулах чадавхыг бэхжүүлэхэд чиглэсэн арга хэмжээг тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлнэ.

16.6.Уур амьсгалын өөрчлөлтийн талаарх мэдлэг, ойлголтыг бүх шатны боловсролын түвшинд эзэмшүүлэх, олон нийтэд түгээн дэлгэрүүлэх, хандлага, оролцоог нэмэгдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.” Санал хураалт. Отгонбаяр гишүүн. Отгонбаяр гишүүнд микрофон өгье.

У.Отгонбаяр: Уучлаарай саяын санал хураалтыг цуцалж, дахин санал хурааж горимын санал гаргаж байна. Энэ техник ажилласангүй.

Б.Бейсен: Отгонбаяр гишүүний гаргасан горимын саналаар саяын саналыг хүчингүй болгох санал хураалт явуулъя. Санал хураалт. Хүчингүй болгох санал хураалт маань 56.3 хувиар дэмжигдлээ. Дахин санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал 56.3 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 17 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Асуулт асуух гишүүд байхгүй байна.

Б.Бат-Эрдэнэ: Төслийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсгийн “дээд шатны” гэснийг “энэ хуулийн 8.3-т заасан” гэж, мөн хэсгийн “танилцуулга” гэснийг “хянуулахаар хүргүүлнэ” гэж тус тус өөрчлөх.

Б.Бейсен: Санал хураалт. Энэ ажиллахгүй байна, энэ давхар дарчхаад. Энэ саяын санал хураалтыг энэ юугаа буруу ажиллуулаад ажиллахаа больчихлоо. Тийм учраас дахин санал хураалт явуулъя. Санал хураалт. Хүчингүй болгох санал хураалт 53.3 хувиар дэмжигдлээ. Санал хураалт. Санал 56.3 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 18 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Асуулт асуух гишүүд байхгүй байна. Ажлын хэсгээс нэг санал ирүүлсэн байгаа. Төслийн 18 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах: Бат-Эрдэнэ гишүүн 18-г.

Б.Бат-Эрдэнэ: Төслийн 18 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“18.1.Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилтыг таван жил тутам шинэчлэн батална.

18.2.Урт хугацааны хүлэмжийн хийн ялгарал багатай эдийн засгийн шилжилтийн стратегийг хүлэмжийн хийн үндэсний тооллого, хүлэмжийн хийн ялгарал, шингээлтийн хэтийн төлөв, төсөөлөлд үндэслэн боловсруулна.

18.3.Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, урьдчилан сэргийлэх, шингээлтийг нэмэгдүүлэх төлөвлөлтийг Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилтод нийцүүлэн тодорхойлно.

18.4.Энэ хуулийн 18.2-т заасан стратеги, төлөвлөгөөнд хүлэмжийн хийг ялгаруулагч болон шингээгч салбар тус бүрээр хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, урьдчилан сэргийлэх, шингээлтийг нэмэгдүүлэх зорилт, арга хэмжээний хүрээ, үр дүнгийн шалгуур үзүүлэлтийг тусгана.

18.5.Төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэлийн Засаг дарга нь энэ хуулийн 8.4-т заасан чиг үүрэг, 10, 11 дүгээр зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, урьдчилан сэргийлэх, шингээлтийг нэмэгдүүлэх зорилт, арга хэмжээг салбарын болон орон нутгийн хөгжлийн баримт бичигт тусган хэрэгжүүлнэ.

18.6.Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах арга хэмжээг хэрэгжүүлэхдээ эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл, эрсдэлийг харгалзан үзнэ.

18.7.Хувийн хэвшлийн байгууллага өөрийн үйл ажиллагаанаас үүдэлтэй хүлэмжийн хийн ялгарал, шингээлтийг тооцох, бууруулах, урьдчилан сэргийлэх, шингээлтийг нэмэгдүүлэх арга хэмжээ хэрэгжүүлэхийг дэмжинэ.

18.8.Үндэсний зохицуулагч байгууллага байгууллагын болон төслийн түвшний хүлэмжийн хийн ялгарлын тооцоо, хэмжилт, тайлагнал, баталгаажуулалттай холбоотой заавар, аргачлалыг баталж, хэрэгжилтэд арга зүйн дэмжлэг үзүүлнэ.

18.9.Үндэсний зохицуулагч байгууллага уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах арга хэмжээний гүйцэтгэлийг жил бүр үнэлж, хэрэгжилтийн тайланг боловсруулж, энэ хуулийн 8.3-т заасан байгууллагад хянуулахаар хүргүүлнэ.

18.10.Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах төлөвлөлтийг боловсруулах, хэрэгжүүлэх хүрээнд институтын болон хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх, олон нийтийн мэдлэг, оролцоог нэмэгдүүлэх арга хэмжээг тусгана.”

Б.Бейсен: Санал хураалт. Санал 56.3 хувиар дэмжигдлээ. Хуулийн төслийн 19 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Асуулт асуух гишүүд байхгүй байна. Ажлын хэсгээс нэг санал ирсэн байна. 22.Төслийн 19 дүгээр зүйлийн 19.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“19.2.Үндэсний зохицуулагч байгууллага Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилтын хэрэгжилтийн ил тод байдлын тайланг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн арга, аргачлалын дагуу боловсруулж, энэ хуулийн 8.3-т заасан байгууллагад хянуулахаар хүргүүлнэ.” Санал хураалт. Санал 56.3 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 20 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Мөнхбаясгалан гишүүн асуулт асууя.

Л.Мөнхбаясгалан: Энэ 20 дугаар бүлгийг би их таашааж талархаж байгаа юм. Ногоон санхүүжилт орж ирж байгаа байхгүй юу. Тэгээд ногоон санхүүжилт энэ ном дээр бичсэнээсээ дахиад зарчмын зөрүүтэй санал дээр өөрчлөн найруулчихсан байна, тийм үү? Энэ дээр одоо би дахиад л нөгөө танай хуулийн яг үзэл баримтлалыг уншиж өгөх гээд байна л даа. Судлаачдын тогтоосноор 1971 оны байдлаар нийт газар нутгийн 63 хувьд олон жилийн цэвдэг тархсан байсан бол 26 онд 29.3 хувь болсон, 2000 оноос 2015 оны хооронд нийт нуур, цөөрмийн 21, гол мөрний 12, горхи, булгийн 15 хувь хатаж ширгэсэн байна гэж.

Уур амьсгалын өөрчлөлтийн суурь үзүүлэлт усны хомсдол мөн биз дээ? Ус ширгэж байгаа энэ үйл явдал мөн. Тэгвэл энэ ногоон санхүүжилтийнхээ шалгуурт усны асуудал яаж орж байгаа юм бэ? Усны нөөцийг хамгаалсан, сэргээсэн, усыг дахин ашигласан, саарал ус ашигласан тохиолдолд энэ ногоон санхүүжилтийг оруулмаар байна. Ногоон санхүүжилт оруулмаар байна. Энэ дээр бол тийм юм алга байна шүү дээ, их ерөнхий. Хууль ерөнхий орно гэдгийг би мэднэ. Гэхдээ уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах гэдэгт нь ороод байгаа юм уу, дасан зохицоход нь орох юм уу, даван туулахад нь орох юм уу, байгалийн нөөцийн зохистой ашиглалтад орох юм уу, алинд нь орох юм бэ жишээ нь энэ ус? Гол нь танай хуулийн үзэл баримтлал дотор усны асуудлыг үзэл баримтлалаа болгосон учраас энийг заавал оруулах ёстой гэж би бодож байгаа юм. Тэгээд асуучихъя, тодруулна.

Б.Бейсен: Болормаа гишүүн хариулъя.

Э.Болормаа: Мөнхбаясгалан гишүүний асуултад хариулъя. Ногоон санхүүжилт гэдгийг 4.1.8-д 2 дугаар зүйлээсээ өмнө томьёолохоороо юу гэж оруулсан бэ гэхээр, ногоон санхүүжилт гэж байгаль орчны тогтвортой хөгжлийн хүрээнд байгаль орчинд эерэг нөлөө үзүүлэх, доройтлыг бууруулах, нөөцийн үр ашигтай хэрэглээг дэмжихэд чиглэсэн, тодорхой шалгуур үзүүлэлтэд нийцсэн хөрөнгө оруулалт, санхүүжилтийг хэлнэ гэж байгаа юм. Тэгэхээр бид нийтдээ хуульд бол энийг юу гэж томьёолсон бэ гэхээр энэ байгаа юм. Тэгвэл энэ 20 дугаар зүйл дээр энийг цаашдаа яаж зохицуулах юм бэ, тухайлбал нэг усны төсөл байа гэж бодъё яг таны онцгойлон асуусан. Энэ дээр ногоон таксономи /green taxonomy/ гэдэг юм гарч ирж байгаа юм. Ногоон таксономи гэдэг нь өөрөө энэ журам, зохицуулалт нь болно. Энийг яаж ангилах юм бэ, энэ усны төсөл орох юм уу, юун дээр үндэслэх юм, хог ангилах төсөл орох юм уу, мод тарих төсөл яаж орох юм гэдгийг бол олон улсын жишгээр ногоон таксономи буюу шалгуур ангиллыг нь Эдийн засаг, хөгжлийн яамны Ногоон санхүүжилтийн хэлтэс боловсруулна.

Яг өнөөдрийн байдлаар Монгол Улсад ногоон санхүүжилт гэдэг томьёолол хаана ч байхгүй байгаа хуулийн хүрээнд бол. Тэгэхээр бид анх удаагаа энд оруулж ирээд, зөвхөн уур амьсгалын өөрчлөлт гэхгүйгээр байгаль орчны эерэг нөлөөлөл яг энэ үзэл баримтлалын хүрээнд, цар хүрээнээсээ магадгүй зарим нь бол давсан гэж үзэхүйцээр ногоон санхүүжилтийн томьёоллыг оруулж ирээд, тэгээд энэ ногоон таксономи гэдэг зүйл эхлээд, энэ хуулийн 4 дүгээр зүйл дээр нэр томьёоны тодорхойлолт бий. Нэр томьёоны тодорхойлолт, тэгье.

Ногоон таксономи гэдэг нь эдийн засгийн үйл ажиллагаа, төсөл, хөтөлбөр, арга хэмжээг байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэхгүй байдлаар нь ангилж, ногоон болон уур амьсгалын санхүүжилтэд хамрагдахыг тодорхойлсон шалгуур, ангиллыг. Өнөөдөр Монгол Улсад ногоон таксономи бол банк, санхүүгийн салбарт аягүй амжилттай явж байгаа. Энэ яг өөрөө аль хэдийн тогтвортой санхүүжилтийн хүрээнд ингээд хийгээд явж байгаа зүйл. Тэгвэл бид энийг улсын төсөв, төр, хувийн хэвшлийн түншлэл ингээд бид улсын төсвөө ч гэсэн ангилдаг болох ёстой гээд Сангийн яам энэ шалгуур үзүүлэлтийг Эдийн засаг, хөгжлийн яамтай хамтран боловсруулж, цаашдаа энийгээ бүх үйл ажиллагаандаа оролцуулах суурийг нь оруулж ирэх энэ дүрэм, журам бол дагалдах журмаараа гарах учиртай юм.

Б.Бейсен: Мөнхбаясгалан гишүүн тодруулъя.

Л.Мөнхбаясгалан: Ногоон санхүүжилтийн энэ эх үүсвэр байна л даа. Гадаадын зээл, буцалтгүй тусламж, гадаад, дотоодын хуулийн этгээд, хувь хүний санхүүжилт гэхээр энэ ногоон зээл чинь маш өргөн хүрээтэй хэрэгжих гэж байгаа байхгүй юу. Энийг чинь бол би дэмжээд байна л даа, гол нь намайг сая асуухаар та усны төсөл гэж яриад байгаа байхгүй юу. Би төсөл биш, жишээ нь энэ усны нөөцийг хамгаалсан, нөхөн сэргээсэн, экосистемийг хамгаалсан энэ тохиолдолд энэ ногоон зээл хамрагдах хүрээнд нь орох уу? Тэгэхийн тулд энэ хуульд заагаад байгаа дээр чинь яг алин дээр нь тэр нь яваад байгаа юм бэ? Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулж байгаа нь юм уу, дасан зохицох уу? Төсөл гэж битгий хараарай.

Б.Бейсен: Хэн хариулах вэ? 5 номер, Батбаяр. Эхлээд Болормаа гишүүн хариулъя. Болормаа гишүүнд микрофон өгье.

Э.Болормаа: Бидний хувьд 3 том санхүүжилтийн схем, тогтолцоо байгаа гэж харж үзэж байгаа. Түүний хамгийн том нь бол тогтвортой хөгжлийн санхүүжилт. Нөгөө олон улсын тогтвортой хөгжлийн зорилтуудын хүрээнд явж байгаа, түүний бүрдэл нэг хэсэг нь бол ногоон санхүүжилт. Энэ байгаль орчинд эерэг үр нөлөө үзүүлэх төсөл, хөтөлбөр, арга хэмжээ бүгд орохоор байгаа. Би энийг яг нөгөө хуульд нь онцлон хэлье. Ногоон санхүүжилтийн нэг бүрдэл хэсэг нь 22 дугаар зүйл дээр тайлбараар орж ирсэн байгаа нь уур амьсгалын өөрчлөлтийн санхүүжилт орж ирнэ. Тэгэхээр ногоон нь том, жижиг гэж ярих юм бол арай өргөн цар хүрээтэйгээр орж ирнэ. Уур амьсгалын өөрчлөлтийн санхүүжилт үүнийхээ нэг хэсэг, түүний нэг хэсэг нь л карбон зах зээл. Яг таны хэлдэг шиг маш олон арга хэрэгслүүд энэ дунд байгаа.

Би түрүүн буруу ганц төсөл гэдгийг буруу ойлгогдож хэлсэн бол уучлаарай. Ногоон таксономи гэж эдийн засгийн үйл ажиллагаа, төсөл, хөтөлбөр, арга хэмжээг гэдгээрээ энэ өөрөө өргөн цар хүрээтэйгээр оруулж ирж байгаа. Энэ таксономийг Сангийн яам, Эдийн засаг, хөгжлийн яам боловсруулаад, ЗГ бүр батлах үүрэгтэй болгож байгаа юм. ЗГ-ыг энэ бүх төсөл, хөтөлбөрүүдээ мөн үүгээрээ ангилах ёстой

шүү, шалгуур үзүүлэлтээ боловсруул гэж яг бид зүгээр хий хоосон орхихгүйгээр үүрэгжүүлж өгсөн байгаа. Тэр бол 8 дугаар зүйлд орсон байгаа. 7 дугаар зүйл дээр ЗГ батална гэсэн. Уучлаарай. Харин энэ нөгөө анхдагч хууль, ЗГ-ын бүрэн эрх гэдэг дээр 7.2 гэснийг уншиж өгье. 7.2 дээр ногоон, энэ цаасан дээр нь 7 дугаар зүйл дээр, энэ ЗГ-ын бүрэн эрх гэдэг дээр, уучлаарай. "Ногоон болон уур амьсгалын санхүүжилтийг бүртгэх, тайлагнах, ил тод байдлыг хангах журмыг батлах" гэснийг оруулсан байгаа. Таксономийг батлах нь.../минут дуусав/

Б.Бейсен: 2 тодруулчихсан. Ажлын хэсгээс нэг санал ирүүлсэн байгаа. Төслийн 20 дугаар зүйлийн доор дурдсанаар өөрчлөн найруулах. Ногоон санхүүжилт. Бат-Эрдэнэ гишүүн танилцуулна.

Б.Бат-Эрдэнэ: 20.1.Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох, даван туулах, байгалийн нөөцийн зохистой ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх, нийгэм, эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангахад чиглэсэн төсөл, хөтөлбөр, үйл ажиллагааг ногоон санхүүжилтээр дэмжинэ.

20.2.Ногоон санхүүжилтээр хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь хөгжлийн бодлого, төлөвлөлт, төсөв, мөнгөний бодлого, ногоон санхүүжилтийн стратегитай нийцсэн байна.

20.3.Энэ хуулийн 20.1-т заасан төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд улсын болон орон нутгийн төсвийн төлөвлөлтөд зардал, үр ашгийн тооцоо, нийгэм, эдийн засгийн өгөөж, төсөвт үзүүлэх нөлөөлөлд үндэслэнэ.

20.4.Ногоон санхүүжилт нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ:

20.4.1.улсын болон орон нутгийн төсөв;

20.4.2.төр, хувийн хэвшлийн түншлэлийн санхүүжилт;

20.4.3.гадаад, дотоодын хуулийн этгээд, хувь хүний санхүүжилт;

20.4.4.гадаадын зээл, буцалтгүй тусламж;

20.4.5.байгаль орчин, уур амьсгалын сан;

20.4.6.хууль тогтоомжид нийцсэн бусад эх үүсвэр.

20.5.Ногоон санхүүжилтийг дараах санхүүгийн хэрэгсэл, хөшүүргийг ашиглан хэрэгжүүлж болно:

20.5.1.улсын болон орон нутгийн төсвийн санхүүжилт;

20.5.2.татварын хөнгөлөлт, чөлөөлөлт;

20.5.3.батлан даалт;

20.5.4.зорилтот бонд, зээл;

20.5.5.төр, хувийн хэвшлийн болон олон улсын эх үүсвэртэй холимог санхүүжилт;

20.5.6.хууль тогтоомжид нийцсэн бусад;

20.6.Энэ хуулийн 20.5-д заасан ногоон санхүүжилтийн хөшүүрэг нь Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай, Төсвийн тухай, Өрийн удирдлагын тухай, Татварын ерөнхий хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасан холбогдох шаардлагыг хангасан байна.

20.7.Ногоон санхүүжилтэд хамрагдах төсөл, хөтөлбөр, үйл ажиллагаа нь ногоон санхүүжилтийн шалгуур, ногоон таксономи, хэмжилт, тайлагнал, баталгаажуулалтын шаардлагыг хангасан байна.”

Б.Бейсен: Санал хураалт. Санал 56.3 хувиар дэмжигдлээ. Хуулийн төслийн 21 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Асуулт асуух гишүүд байхгүй байна. Ажлын хэсгээс нэг санал ирүүлсэн байгаа.

Төслийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсгийг хасаж, 21.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“21.3.Ногоон санхүүжилтэд хамрагдах төсөл, хөтөлбөр, үйл ажиллагааны үр дүн нь бодит, хэмжигдэхүйц, баталгаажихуйц байна.” Санал хураалт. Санал 62.5 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 22 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Асуулт асуух гишүүд байхгүй байна. Ажлын хэсгээс нэг санал ирүүлсэн байгаа.

Б.Бат-Эрдэнэ: Төслийн 22 дүгээр зүйлийн 22.2, 22.3, 22.5, 22.6 дахь хэсгийг хасаж, 22.1, 22.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“22.1.Ногоон санхүүжилтийн мэдээлэл нь ил тод, нээлттэй, нийтэд хүртээмжтэй байна.

22.4.Уур амьсгалын санхүүжилтийн мэдээллийг энэ хуулийн 19 дүгээр зүйлд заасны дагуу Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилтын хэрэгжилтийн ил тод байдлын тайланд тусган тайлагнана”

Тайлбар: Энэ хуулийн 4.1.21-д заасан уур амьсгалын санхүүжилт нь 4.1.8-д заасан ногоон санхүүжилтийн бүрэлдэхүүн хэсэг байх бөгөөд энэ хуульд “ногоон болон уур амьсгалын санхүүжилт” гэж дурдсан тохиолдолд уур амьсгалын санхүүжилтийг ногоон санхүүжилтэд хамааруулан ойлгоно.

Б.Бейсен: Санал хураалт. Санал 56.3 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 23 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Асуулт асуух гишүүд байхгүй байна.

Б.Бат-Эрдэнэ: Төслийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсгийн “хэлбэртэй” гэснийг “төрөлтэй” гэж, 23.3.8 дахь заалтын “иргэдтэй урьдчилан зөвлөлдөж” гэснийг “иргэдэд төсөл, хөтөлбөрийн танилцуулга хийж” гэж тус тус өөрчилж, мөн зүйлийн 23.3.7, 23.5.11, 23.6 дахь хэсгийг хасаж, 23.5.5 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“23.5.5.сааруулалтын үр дүнг Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилтод тооцох, олон улсад шилжүүлэх эсэхийг тодорхойлсон ашиглалтын зорилго”

Б.Бейсен: Санал хураалт. Санал 56.3 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 24 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Асуулт асуух гишүүд байхгүй байна. Ажлын хэсгээс нэг санал ирүүлсэн байгаа.

Төслийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсгийн “санхүүжилтээр шууд санхүүжээгүй төслөөс” гэснийг “санхүүжилтээс бусад эх үүсвэрээр хэрэгжүүлсэн төслөөс” гэж өөрчлөх. Санал хураалт. Санал 56.3 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 25 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Асуулт асуух гишүүд байхгүй байна. Ажлын хэсгээс нэг санал ирүүлсэн байгаа.

Төслийн 25 дугаар зүйлийг хасах. Санал хураалт. Санал 26.3 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 26 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Асуулт асуух гишүүд байхгүй байна. Ажлын хэсгээс нэг санал ирүүлсэн.

Төслийн 26 дугаар зүйлийн 26.3 дахь хэсгийн “баталгаажуулалтын журмыг энэ хуулийн 8.2-т заасан байгууллага батална” гэснийг “баталгаажуулалтыг энэ хуулийн 7.1.8-д заасан журмын дагуу хэрэгжүүлнэ” гэж өөрчлөх. Санал хураалт. Санал 56.3 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 27 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Асуулт асуух гишүүд байхгүй байна. Ажлын хэсгээс нэг ирүүлсэн. 30.

Б.Бат-Эрдэнэ: Төслийн Наймдугаар бүлгийн гарчиг-ийн “ИЛ ТОД БАЙДАЛ” гэснийг “ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ” гэж өөрчилж, 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсгийн “Үндэсний” гэсний өмнө “Уур амьсгалын өөрчлөлтийн” гэж нэмж, 27.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“27.2.Үндэсний зохицуулагч байгууллага уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа, төсөл, хөтөлбөрийн үр дүн, хүлэмжийн хийн үндэсний тооллогын мэдээллийг энэ хуулийн 27.1-д заасан үндэсний мэдээллийн системд бүртгэж, түүний ашиглалт, хадгалалт, хамгаалалт, нууцлалын найдвартай байдлыг ханган ажиллана.”

Б.Бейсен: Санал хураалт. Санал 56.3 хувиар дэмжигдлээ. Хуулийн төслийн 28 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Асуулт асуух гишүүд байхгүй байна.

31.Төслийн 28 дугаар зүйлийн гарчиг-ийн “, ил тод байдал” гэснийг хасаж, мөн зүйлийн 28.2 дахь хэсгийн “хуулийн” гэсний өмнө “хуулийн 28.1-д заасан байгууллага” гэж нэмж, 28.3 дахь хэсгийн “мэдээллийг тогтоосон хугацаанд” гэснийг “мэдээллийг энэ хуулийн 8.2.10-т заасан техникийн хороогоор хянуулна.” гэж өөрчлөх. Санал хураалт. Санал 56.3 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 29 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Асуулт асуух гишүүд байхгүй байна. Ажлын хэсгээс санал ирүүлээгүй байна.

Хуулийн төслийн 30 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Асуулт асуух гишүүд байхгүй байна. 32.Төслийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсгийн “зорилтыг хангах зохицуулалттай карбон кредитийг энэ хуулийн 8.2-т заасан” гэснийг “зорилтод тооцогдох карбон кредитийг энэ хуулийн 8.3-т заасан” гэж өөрчлөх. Санал хураалт. Санал 56.3 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 31 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Асуулт асуух гишүүн байхгүй байнга. Ажлын хэсгээс 1 санал ирүүлсэн байна. Төслийн 31 дүгээр зүйлийн 31.3 дахь хэсгийг хасах. Санал хураалт. Санал 56,3 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 32 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Асуулт асуух гишүүд байхгүй байна. Ажлын хэсгээс 3 санал ирүүлсэн байна. 34.Төсөлд доор дурдсан агуулгатай 32 дугаар зүйл нэмэх:

“32 дугаар зүйл. Шилжилтийн үеийн зохицуулалт

32.1.Энэ хуулийн 22.1.7, 22.1.8, 22.1.9, 22.1.10-т заасан журмыг Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 6 сарын сарын дотор баталж мөрдүүлнэ.” Санал хураалт. Санал 56.3 хувиар дэмжигдлээ.

36.“Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулах. Санал хураалт. Санал 56,3 хувиар дэмжигдлээ. Найруулгын санал 1.

Б.Бат-Эрдэнэ: Төслийн 18 дугаар зүйлийн 18.4 дэх хэсгийн “8.3” гэсний дараа “заасан чиг үүрэг” гэж, 24.1 дэх хэсгийн “бүртгэгдсэнээр” гэсний дараа “түүнийг” гэж тус тус нэмж, 4 дүгээр зүйлийн 4.1.6, 4.1.11, 4.1.15 дахь заалтын “зах зээлийн тогтолцоо” гэснийг “зах зээлийг” гэж, 4.1.20 дахь заалтын “мэдрэг байдал өндөр” гэснийг “эрсдэлтэй, мэдрэг байдалтай” гэж, мөн заалтын “өндөр” гэснийг “бүхий” гэж, 4.1.32 дахь заалтын “нүүрсхүчлийн хий” гэснийг “нүүрстөрөгчийн давхар исэл” гэж, 4.1.33 дахь заалтын “экосистемийн,” гэснийг “экосистемийг ашиглах” гэж, 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсгийн “тогтоосон” гэснийг “хуульд заасан” гэж, 31 дүгээр зүйлийн 31.3 дахь хэсгийн “22.7-д” гэснийг “30.2-т” гэж тус тус өөрчилж, төслийн хуулийн нэрийн “ХУУЛЬ” гэснийг, 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалтын “тогтмол” гэснийг, 18 дугаар зүйлийн 18.4 дэх хэсгийн “Салбарын болон бусад” гэснийг тус тус хасах.

Б.Бейсен: Санал хураалт. Санал 62.5 хувиар дэмжигдлээ. Хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэнэ.

Нэг.Агаарын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Байхгүй байна. Санал ирүүлээгүй. Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Ажлын хэсэг санал ирүүлээгүй. Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Байхгүй байна. Ажлын хэсэг санал ирүүлээгүй.

Хоёр.Авто замын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Байхгүй байна. Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Асуулт асуух гишүүд байхгүй байна.

Гурав.Барилгын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу, нэрсээ өгнө үү? Байхгүй байна. Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Байхгүй байна. Ажлын хэсэг санал ирүүлээгүй. Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Асуулт асуух гишүүд байхгүй байна.

Дөрөв.Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу, нэрсээ өгнө үү? Байхгүй байна. Ажлын хэсгээс нэг санал ирүүлсэн байна.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 9 дэх хэсгийн “мэдээллийн нэгдсэн” гэснийг “уур амьсгалын өөрчлөлтийн мэдээллийн” гэж, 2 дугаар зүйлийн “өөрчлөлтийн мэдээллийн нэгдсэн сан” гэснийг “өөрчлөлт” гэж тус тус өөрчлөх. Санал хураалт. Санал 62.5 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Байхгүй байна. Ажлын хэсэг санал ирүүлээгүй байна. Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Асуулт асуух гишүүд байхгүй байна.

Тав.Гамшгаас хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Асуулт асуух гишүүд байхгүй байна. Ажлын хэсгээс нэг санал ирүүлсэн байна. 1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 4.1.4 дэх заалтын "хүнсний баталгаат байдал" гэснийг "Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдал" гэж өөрчлөх. Санал хураалт. Буруу санал хураачихсан, энэ саналыг хүчингүй болгож байна. Энэ холиод шивэлтийн алдаа юм байна.

Зургаа.Тариалангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл Энд саналгүй юм байна. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Байхгүй байна. Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Байхгүй байна.

Долоо.Хот байгуулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Байхгүй байна. Ажлын хэсгээс нэг санал ирүүлсэн байна.

Төслийн 2 дугаар зүйлийн “өөрчлөлтийг даван туулах” гэснийг “өөрчлөлтийн” гэж өөрчлөх. Санал хураалт. Санал 62.5 хувиар дэмжигдлээ. Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Асуулт асуух гишүүн байхгүй байна, санал байхгүй.

Найм.Эрчим хүчний хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Байхгүй байна. Ажлын хэсэг санал ирүүлээгүй. Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Байхгүй байна. Ажлын хэсэг санал ирүүлээгүй байна.

Ес.Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төсөл. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу, нэрсээ өгнө үү? Мөнхбаясгалан гишүүн асуулт асууя.

Л.Мөнхбаясгалан: Энэ Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай, тийм ээ. Энэ дээр би УИХ-ын бүх гишүүд ер нь цаашид хууль хийгээд, бичээд орохдоо энэ хэсгийг анхаармаар юм байна лээ шүү. Жишээ нь дагаж мөрдөх журмын тухай бид батлаад хаячихдаг, ЗГ баталдаггүй. 24 оны хууль гэхэд одоо хүртэл журам нь гараагүй байх жишээний тийм байж байдаг юм байна лээ. Тэгээд энэ хууль дээр хугацаа тавьж өгсөн байгаа байхгүй юу. Тухайн хууль хүчин төгөлдөр болсноос хойш 1 жилийн дотор ЗГ батална, нөгөө журмыг нь. Тэгэхээр энэ аягүй сайн болсон шүү. Энийг цаашаа бүгд анхаарвал.

Б.Бейсен: Ажлын хэсгээс нэг санал ирүүлсэн байна. Төслийг хууль санаачлагчид нь буцаах. Санал хураалт. Санал 62.5 хувиар дэмжигдлээ.

Найруулгын санал. Дээрх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн бүлэг, зүйл, хэсэг, заалтын дугаарыг өөрчилж, төслийн агуулга, зарчмыг алдагдуулахгүйгээр үг хэллэг, найруулгын шинжтэй засвар хийх. Санал хураалт. Санал 62.5 хувиар дэмжигдлээ. Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа. Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаар Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос гаргах санал, дүгнэлтийг УИХ-ын гишүүн Болормаа чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулна.

18.46 цаг

Хоёр.Ойн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ нарын 18 гишүүн 2026.06.04-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Дараагийн хэлэлцэх асуудалд оръё. Ойн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцье. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулаад хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд

Сандаг-Очир, Ш.Батбаяр Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны ТНБД-ын албыг түр орлон гүйцэтгэгч, Б.Оюунсанаа Ойн газрын дарга, Т.Балжинням Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Байгалийн нөөцийн бодлого, зохистой ашиглалтын газрын дарга, Д.Жагдаг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Бодлого, зохистой ашиглалтын газрын Ойн бодлогын хэрэгжилт хариуцсан ахлах шинжээч, Б.Алтанцэцэг НҮБ-ын ХХААБ-ын STREAM төслийн хууль, бодлогын мэргэжилтэн, Я.Хишигт Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн төслийн зөвлөх.

Хууль санаачлагчийн танилцуулгыг УИХ-ын гишүүн Бат-Өлзийн Бат-Эрдэнэ танилцуулна. Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүний микрофоныг өгье.

Б.Бат-Эрдэнэ: Эрхэм гишүүдийнхээ энэ өдрийн амгаланг айлтгая. Ойн тухай хууль шинэчилсэн найруулгаар орж ирж байгаа. Бид Ойн тухай хууль дээр өнөөгийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулийг үндсэн дүн нуруугаа болгож авч үзсэн. Иргэдтэй холбоотой буюу иргэдийн ахуйн хэрэглээтэй холбоотой харилцааг бид хуульчилж өгч байгаа. Аль болох иргэдэд ээлтэй байдлаар оруулж өгч байна.

2 дугаарт эдийн засагжуулах харилцааг оруулж өгч байгаа. Эдийн засагжуулах харилцаа буюу хүмүүсийн ярьдаг, ялангуяа хожуул, унанги, босоо болон хатсан гээд ингээд маш олон моднууд бий. Эдгээрийг бид эдийн засгийн эргэлтэд оруулахтай холбоотой харилцааг зайлшгүй шийдвэрлэх шаардлагатай байгаа. Цаашдаа бид эдийн засгийн эргэлтийг бий болгосноор Ойн тухай хууль буюу энэ хууль хүчин төгөлдөр болж мөрдөгдсөнөөр ойн салбараас бидний хувьд 1 их наядаар тооцогдох хэмжээний эдийн засгийн эргэлтийг бий болгох бүрэн боломжтой гэж үзэж байгаа.

Тогтвортой хөгжлийг нийгэм, эдийн засаг, байгаль орчин гэсэн 3 хүрээнд хангаж, хүрээлэн буй орчин, экосистемийг хамгаалснаар хүн бүр эрхээ бүрэн дүүрэн эдэлж, сайн сайхан амьдрах боломжийг өнөөгийн болон хойч үедээ бүрдүүлнэ. Хүн төрөлхтөнд тулгараад байгаа уур амьсгалын өөрчлөлт, орчны бохирдол, биологийн олон янз байдлын хомсдол нь олон улсын болон үндэсний хууль тогтоомжоор баталгаажсан хүний үндсэн эрхийг хангаж, амьдралын чанарыг сайжруулахад тулгарч байгаа сорилт, бэрхшээлүүдийн нэг болоод байгаа. Тийм учраас бид Ойн тухай хуульд шинэчилсэн найруулга хийж байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн 6 дугаар зүйлийн нэг дэх хэсэгт Монгол Улсад газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэлд, төрийн хамгаалалтад байна гэж, мөн зүйлийн 2 дахь хэсэгт Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан нийтийн өмч мөн гэж тус тус заасан байдаг. Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн хоёрт хүн бүр эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхийг тунхаглаж, байгаль орчныг хамгаалах болон хүний үндсэн эрхийн хамаарлыг хүлээн зөвшөөрсөн байдаг.

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд хүний аюулгүй байдал, хүрээлэн буй орчны аюулгүй байдлыг үндэсний аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсэгт хамааруулж, байгаль орчны тэнцвэрийг хадгалж, уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг дагаврыг зөөлрүүлэх, биологийн олон янз байдлын хомсдолоос сэргийлэх, ойн дагалдах нөөцийн экспорт болон ойн үндсэн ашиглалтын огтлолтыг

бүрэн хориглож, ойн сангийн нөөцийг 2 хувиар нэмэгдүүлэх, харь зүйлийн ургамлыг нутагшуулахдаа биологийн олон янз байдлын удмын санд өөрчлөлт гаргахаас сэргийлэх, хяналт тавих, ойжуулах, тарималжуулах, нөхөн сэргээх ажилд иргэний нийгмийн байгууллага, хувийн хэвшил, нутгийн иргэдийг түлхүү татан оролцуулахаар заасан байдаг.

"Алсын хараа 2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод хөрс дэлхий, унаган байгалиа хайрлан хамгаалж, хөгжих эрхэм зорилгыг тодорхойлж, байгаль орчинд ээлтэй ногоон хөгжлийг эрхэмлэн экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалж, байгаль орчны тогтвортой байдлыг ханган үр өгөөжийг нь өнөө болон ирээдүй хойч үедээ хүртэх нөхцөлийг бүрдүүлэх зорилгын хүрээнд байгалийн үнэ цэн, өгөөжийг үнэлэн хамгаалж, анхдагч экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалах, байгалийн нөөц баялгийг нөхөн сэргээх, хомсдолыг бууруулах, ашиглалтын нөөц бий болгож, байгалийн үр өгөөжийг ирээдүй хойч үедээ өвлүүлэх, хүлэмжийн хийн ялгарал багатай байгаль орчны тэнцвэрт байдлыг хангах, ногоон эдийн засгийг хөгжүүлж, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах олон улсын хүчин чармайлтад хувь нэмэр оруулах зорилтуудыг тусгасан.

Монгол Улсын ЗГ-ын 2024 оны 181 дүгээр тогтоолын хавсралтаар Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлийн 86-д Ойн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулахаар тусгасан. Парисын хэлэлцээрийн Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилтын хэрэгжилтийг хангуулахын тулд ойн хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, ойн нүүрстөрөгчийн хийн шингээлтийг тооцох, түүнийг үнэлэх, тайлагнах эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлагатай байгаа. Ийнхүү дээр дурдсан урт, дунд хугацааны хөгжлийн бодлого, чиглэлд нийцүүлэн Ойн тухай хуулийн шинэчилсэн найруулга хийх зайлшгүй шаардлага бий болж байгаа.

"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний 2.10-т модлог ургамлын үр, суулгац бэлтгэх, импортлох, хадгалах, худалдан борлуулах, тээвэрлэх, ашиглах, үрийн нөөцийн улсын сан бүрдүүлэх эрх зүйн орчныг боловсронгуй болгохоор зааж өгсөн. Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлэх үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилтын хэрэгжилтийг хангуулахын тулд ойн хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, ойн нүүрстөрөгчийн хийн шингээлтийг тооцох, түүнийг үнэлэх тайлагнах эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлагатай байгаа. Практик шаардлагын хувьд Ойн тухай хуулийг 2012 онд шинэчлэн баталснаас хойш 13 удаа нэмэлт, өөрчлөлт орсон. Үүнээс 8 нь бусад хуулийг дагалдан орсон редакцын шинжтэй нэмэлт, өөрчлөлтүүд байгаа. 2022 онд орсон өөрчлөлтөөр улсын хэмжээнд ойн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах чиг үүрэг бүхий ойн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагыг байгуулсан нь дэвшил байсан.

Үүнээс өөрөөр ойн салбарын эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх, ойг экосистемийн хувьд хадгалах, хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, ойн экосистемийн үйлчилгээнд бүрэн чиглэсэн ойн тогтвортой менежментийн бодлогыг урт хугацаанд хэрэгжүүлэхэд чиглэсэн агуулгын өөрчлөлт, шинэчлэлт хийгдээгүй байгаа. Улсын хэмжээнд 2014-2016 онд явуулсан олон зорилтот ойн тооллогын тайланд ойн нөөцийн 76 хувь нь болц гүйцсэн буюу хөгширсөн, унанги, ойн хөнөөлт шавж, өвчинд нэрвэгдсэн, өртсөн талбай ихээр нэмэгдсэн, байгалийн жамаар нөхөн сэргэх чадавх буурсан ба Монгол Улсын ойн үнэт чанар алдагдаж байна гэж дүгнэсэн.

Хуулийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээний хувьд ойг экосистемийн түвшинд тодорхойлж, ойн сан бүхий газарт байгалийн болон таримал заган, татмын ой, мод, сөөг, заг бүхий газар, ойн цоорхой, цагаан энгэр, ой тэлж ургахад шаардлагатай газар болон хамгаалалтын зурвас хамааруулан, ойн сангийн ангиллыг өргөтгөж, хамгаалалтын болон ашиглалтын бүсэд хувааж байсныг 3 болгож, тусгай зориулалтын ойн ангиллыг нэмэх ба тэдгээрийн дэглэм, хориглох үйл ажиллагааг тодорхойлж өгсөн.

2 дугаарт, улс, аймаг, нийслэлийн ойн менежментийн төлөвлөгөөтэй байлгах, төлөвлөгөө нь стратегийн шинжтэй байх бол сумын ойн менежментийн төлөвлөгөө нь тухайн нутаг дэвсгэрийн ойд хэрэгжүүлэх ойн аж ахуйн арга хэмжээг тусгаж хэрэгжүүлэх ба 10 жилийн хугацаатай байх, хугацаанаас өмнө байгалийн аюулт үзэгдлийн улмаас ойн төлөв байдалд их хэмжээний өөрчлөлт орсон нь ойн зохион байгуулалт, ойн тооллогоор тогтоогдсон, эсхүл газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд ойн сан бүхий газрын ангилалд өөрчлөлт орсон үндэслэлээр нэмэлт, өөрчлөлт оруулах тайланг тухайн жилд багтаан цахим системд илгээж байхаар хуульчлах ба хушин ойн менежментийг тусгайлан зааж оруулж өгсөн. Ойн баялгийн модны нөөц болон дагалдах баялгийг эдийн засгийн эргэлтэд оруулах, нэмэгдсэн өртөг шингээх, тогтвортой ашиглах, ойн экосистемийн үйлчилгээний эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх. Ингэхдээ тухайн ойн бүсийн ангилал, дэглэмд нийцсэн ойн менежментийн төлөвлөгөөнд үндэслэсэн, дэвшилтэт ногоон технологи ашигласан, ойн баялгийн нөөцийг хаягдалгүй үр ашигтай, тогтвортой ашиглах, хаягдлыг бууруулах, үлдэгдэл биомассыг био эдийн засгийн эргэлтэд оруулах боломжийг нээж өгч байгаа.

Ойн санг хот айл, нөхөрлөлд гэрээгээр 10 жилийн давтамжтайгаар 60 жил хүртэл хугацаагаар хариуцуулан гэрээ байгуулж хамгаалах, тухайн ойгоосоо ахуйн зориулалтаар түлээний мод болон дагалдах баялаг түүж ашиглах, түүнчлэн ойн сангийн нүүрстөрөгчийн кредитийг ашиглан зах зээлд оролцох нөхцөлийг бид бүрдүүлж өгч байна. Тусгай зөвшөөрөлтэй эрхлэх ойн мэргэжлийн үйл ажиллагааны төрөл, шаардлага, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдэд тавих шаардлага, үүргийг тусгаж өгсөн. Ойн мэдээллийн цахим санг хөгжүүлэх, салбарын үйл ажиллагаанд оролцогчийн мэдээлэл солилцох, ойн сантай холбоотой бүртгэл, зөвшөөрөл, хяналт, мэдээлэл, гарал үүсэл, эрхийн бичгийг цахимжуулах, мод бэлтгэл, боловсруулах үйлдвэрлэлийн үйл явцыг ойн тогтвортой менежментийн стандартыг хангаж байгааг баталгаажуулах харилцааг хуульчилж өгсөн. Ойн салбарын тогтвортой хөгжлийг дэмжих зорилго бүхий Ойжуулалтын сан, мөн нүүрстөрөгчийн шингээлт, ялгарлаар холбоотой төсөл, бүртгэл, баталгаажуулалт, зах зээлийн оролцоог дэмжих зорилго бүхий ойн нүүрстөрөгчийн худалдааны орлогоос бүрдсэн Ойн нүүрстөрөгчийн санг байгуулах, ашиглуулах эрх зүйн орчныг мөн давхар бүрдүүлж өгч байгаа.

Ойн менежменттэй холбоотой харилцаан дээр бид ихээхэн зайлшгүй анхаарах зүйлсийг бид хуульд нарийвчлан зохицуулсан харилцаагаар оруулж өгсөн. 2026 оны 8 сарын 17-ноос 8 сарын 28-ны хооронд СОР буюу Цөлжилтийн конвенцын талуудын бага хурал Монгол Улсад зохион байгуулагдахаар байгаа. 2022 онд байгуулагдсан Европын холбоотой байгуулсан ойн түншлэлийн хүрээнд бид нэг харилцааг хуульчлахаар үүрэг хүлээж авсан. Энэ бол ойг үлдэгдэлгүй байлгах, өөрөөр хэлбэл ойгоос хог хаягдал үүсдэггүй байх, эдийн засагжуулах харилцааг Монгол Улс хуульдаа оруулж, эдийн засагжуулах харилцааг оруулна

гэсний хүрээнд энэхүү хуулийн төсөл дээр бид тодорхой эдийн засагжуулах харилцаануудыг хийж өгсөн.

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын олон улсын гэрээ болон хууль тогтоомжтой нийцүүлэн боловсруулсан. Бид Европын холбоотой байгуулсан Ойн түншлэлийн гэрээний хүрээнд 200 сая евро авах, евро, техникийн туслалцаа болон бусад дэмжлэг авах хэлбэр дээр СОР-ын хүрээнд бид ажиллаж байгаа. Тийм учраас хуулийн төслийг бид өргөн барьж, УИХ-аар хэлэлцүүлэхээр ажиллаж байна. Хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбогдуулан Ойн тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай, Ойн тухай хууль шинэчилсэн найруулгыг дагаж мөрдөх журмын тухай, Тариалангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Ойн тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай УИХ-ын тогтоолын төслийг тус тус боловсруулан хүргүүлээд байна. Баярлалаа.

Б.Бейсен: Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүнд баярлалаа. Хууль санаачлагчийн танилцуулгатай холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Асуулт асуух гишүүд байхгүй байна. 2 уу? Мөнхбаясгалан гишүүнээр тасаллаа. Мөнхбат гишүүн асуулт асууя.

Ц.Мөнхбат: Түрүүний асуусан асуулттай ойролцоо. Ер нь Ойн тухай хууль дээр энэ шинэчилсэн найруулгын хэлбэртэй болж өөрчлөгдөхгүй байснаараа ямар үр дагаврууд гараад байсан бэ гэдгийг асуумаар байгаа юм?

2 дугаарт энэ ойн сав газруудад хорхойтсон барьсан янз бүрийн моднуудыг цэвэрлэдэг, тэрийг нь ААН-үүд гүйцэтгэдэг ийм байсан. Тэрний тоо хэмжээ нэмэгдэж байгаа юм уу, яаж байгаа юм бэ? Бид ер нь тэр юмнуудаа бүрэн дүүрэн гүйцэд цэвэрлэж, янзалж яг амждаг юм уу, амжихгүй байснаасаа болоод ямар тодорхой үр дагаврууд гардаг юм бэ гэдэг нэг ийм зүйл байна. Тэр моднууд нь цэвэрлэсэн моднууд би яг үндсэн хэллэгүүдээр нь хэлж чадахгүй байна шүү, яг тэр цэвэрлэсэн тэр моднууд нь өөрөө манай энэ эдийн засагт, ялангуяа энэ салбартаа хэр хэмжээний эдийн засгийн орлого олох ийм боломж байдаг юм бэ?

3 дугаарт, самар түүдэг улсууд тэр ой модонд самар түүсээр байгаад тэндээс гарч байгаа тэр хор хохирлыг тооцдог, эсхүл тэрэнтэй холбоотой ийм хариуцлагын юмнууд энэ хууль дээр чухам тусгагдаж байгаа юу гэдэг ийм нэг асуудал?

4 дүгээрт, энэ ойн хуулийн хүрээнд, жишээ нь энэ бүс нутгийнхаа л хэмжээний юм ярих гээд байгаа юм. Нөгөө нэг бид энэ Тэрбум модтой холбоотойгоор мод тарих агро парк байгуулах, тэгээд тэр юунууд хэр хэрэгжиж байна вэ? Үгүй ээ тэр хэр тусгагдаж байна вэ? Тэрбум модны хүрээнд чинь нэг баахан олон ААН-үүд хэдэн сая мод л тарина, барина, санхүүжилтийг нь шийдвэрлэнэ гээд л нэг баахан амлалт өгөөд л гарын үсэг зурцгаагаад байсан. Тэр яг бүрэн дүүрэн хэрэгжиж байгаа юм бол их дутуу дулимаг гэж би бол хувьдаа анзаардаг. Тэгэхээрээ тэрэнтэй холбоотой тийм хариуцлагын гэх юм уу, эсхүл тэд нарыг ингээд жоохон шахаж шаардсан ийм зохицуулалт, юмнууд энэ дээр орж байгаа юу?

5-д нь нөгөө нэг алтан харгана энэ тэр гээд нөгөө бут байдаг шүү дээ, говийн бүс нутагт ургадаг. Энэ чинь ойдоо орох уу? Энэнд энэ хуульд тэрийг тарьж ургуулах, тэрний үрийг бэлтгэх, цацах ийм юмнууд энэ ой модны энэ хуульд хамаарах уу, тэр моднуудыг хамаардаг юм уу гэдэг ийм нэг хэдэн асуулт байна?

Б.Бейсен: Бат-Эрдэнэ гишүүн хариулъя.

Б.Бат-Эрдэнэ: Одоогийн хуулийг өөрчлөх болсон зайлшгүй хэд хэдэн суурь шалтгаан байна. 1 дүгээрт, бид ойгоосоо эдийн засгийн харилцааг огт хийж чадахгүй байна. Өөрөөр хэлбэл жишээлбэл Хөвсгөл аймгийн Жаргалант сумын хогийн цэг дээр хаягдаж байгаа нийт хогийн гэж тодорхойлж байгаа, хогийн цэгийн бүрдүүлбэрийнх нь 60 хувь модны үртэс байгаа. Бид модны үртсийг огт ашиглаж чадахгүй байна. Тэгэхээр модтой газрууд бол огт модны үртсээ ашиглаж чадахгүй байна гэсэн үг. Ойд ороход бид хожуулаас авхуулаад хүн болгонд харамсалтай дүр төрхүүд байдаг. Тэгвэл бид энийг авч, эдийн засгийн эргэлтэд оруулах харилцаа буюу био эдийн засгаар дамжуулж эдийн засгийн эргэлтэд оруулах зайлшгүй харилцааг бид бий болгох шаардлагатай байгаа.

3 дугаарт, бид таримал ойтой холбоотой асуудал байна. Бид хүлэмжийн хийн зах зээл дээрээс буюу олон улсын зах зээл дээрээс мөнгө олох боломж бидэнд бүрэн дүүрэн байдаг. Үүнийгээ бид эргээд мод тарьж байгаа иргэн, ААН-үүд, төрийн байгууллага, төрийн өмчлөлийн хэлбэрийн ой дээр авах бүрэн дүүрэн боломжийг бид бүрдүүлж өгөх зайлшгүй шаардлагатай болчихоод байгаа юм. Иргэдийн харилцаа байна. Иргэд, ялангуяа орон нутагт ойтой газар амьдарч байгаа иргэд гэмт хэрэгт холбогдох асуудлууд их өндөр байгаа. Тухайлбал яагаад бид Ойн тухай хуулийн шинэчилсэн найруулга дээр цахимжуулалтын системийг хийж өгч байгаа вэ гэхээр өвөлжөөн дээрээ модоо авчхаад гоожин гэдэг гэж яригддаг. Өвөлжөөн дээрээ модоо авчхаад магадгүй хаваржаа руугаа тээвэрлэж явж байгаад гэмт хэрэгт холбогдчих магадлал маш өндөр, нөгөө гоожингоо хайгаад олохгүй ийм тийм. Тийм учраас бид цахим мэдээллийн нэгдсэн мэдээллийн сантай болж байгаа, бүгдийг нь цахимжуулж байгаа гэсэн үг. Дээрээс нь гоожин гэж яригдаад байдаг зүйлийг заавал сумын төв орж авдаг системийг халж, цахимжүүлж байх жишээтэй байгаа гэдэг ч юм уу.

Нөгөө талдаа олон улсын хүлэмжийн хийн зах зээл дээрээс орж ирж байгаа мөнгөтэй нь уяад тодорхой хэмжээнд эдийн засагжуулах харилцааг сайн болгож өгснөөрөө эргээд иргэдийн хувьд орлогожих бүрэн дүүрэн боломжийг бид бүрдүүлж өгч байгаа гэсэн үг.

Хөнөөлт шавж болон ой хээрийн түймэр, унанги эдийн засагжуулахад хэр хэмжээний ашиг орох вэ гэдэгтэй холбоотой харилцаа. Яг өнөөдөр унанги болон ой хээрийн түймэрт өртсөн, хөнөөлт организмд өртсөн модны хэмжээг нийтэд нь гаргаад тооцвол Монгол Улсад 32 жилийн ашиглах нөөц байгаа. Энэ нөөцийг бид ашиглая гэж байгаа юм. Тийм учраас шинэчилсэн найруулга дээр бол эдийн засагжуулах харилцааг зайлшгүй оруулж өгч байна. Самартай холбоотой хариуцлагууд тооцогдож байгаа. Бид самартай холбоотой харилцааг хуулийн 36 дугаар зүйл дээр хушин ойн менежмент буюу самрын модтой нь холбож бид бүгдийг нь оруулж холбож өгч байгаа. Хариуцлагажуулах хэлбэрүүд мэдээж тухайн хэлбэрээсээ шалтгаалаад Эрүүгийн болон Зөрчлийн хуулиар шийдвэрлэгдэх харилцаанууд бүрэн дүүрэн явж байгаа. Ялангуяа тухайн самрыг авахдаа байгальд ээлтэй дэвшилтэт технологи ашиглах, самрын нөөц ашиглах хэмжээ, хугацаа, тоо хэмжээг тогтоохоос авхуулаад тодорхой хуульчлах ёстой зүйл, заалтуудыг бол бид албан ёсоор хуучилж өгч байгаа гэсэн үг.

Үр, үржүүлэгтэй холбоотой асуудал дээр хуульчилж бид өгч байгаа. Ялангуяа энэ нөөцтэй холбоотой, сантай холбоотой асуудлыг бид хуульчилж өгч, цаашдаа энэ гарал үүслийн тодорхойлолтыг бид хийж өгөхгүй бол энд тэндээс орж ирсэн моднуудыг байгальд аваачиж шууд тарих гэдэг ч юм уу, эсхүл тухайн зарагдаж байгаа, худалдаалагдаж байгаа мод нь өөрөө гарал үүслийн гэрчилгээгүйгээсээ улбаатай хаана таригдах нь мэдэгдэхгүй, таны саяын хэлдэг жишээлбэл Сэлэнгэд мод үржүүлэг дээр байсан модыг аваачаад Замын-Үүдэд аваачиж тарихаар ямар ч ургах боломжгүй, хөрсөнд таарахгүй гэх мэт ийм нөхцөл байдлууд үүсэж байгаа. Тэгэхээр бид энэ мэдээллийн системээрээ дамжуулаад иргэдэд мэдээлэл авах бүрэн эрхийг нь нээж өгөөд, дээрээс нь заавал гарал үүслийн тодорхойлолттой байх хариуцлагын асуудлыг бид заавал оруулж өгч байгаа.

Тэрбум мод хариуцлагажуулахтай холбоотой асуудлууд мөн адилхан орж байгаа. Ялангуяа эдийн засгийн харилцааг бид оруулснаараа "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнд өнөөдөр оролцоод явж байгаа ААН-үүдийн хувьд тодорхой хэмжээний эргээд ашгийг нь хүртэх боломжийг бид бүрдүүлж өгч байгаа. Тухайлбал өнөөдөр эдийн засгийн харилцаа дээр тарьсан модоо улсад хүлээлгэж өгөөд л дуусаж байгаа, эсхүл тухайн аймагтаа ч юм уу. Тэгвэл тухайн компани өөрсдөө эргээд хүлэмжийн хийн зах зээл дээрээс мөнгө авах бүрэн дүүрэн боломжийг нь бид энэ Ойн тухай хуулийн шинэчилсэн найруулга дээр оруулаад өгчхөж байгаа учраас эргээд хариуцлагатай болно.

Б.Бейсен: Мөнхбаясгалан гишүүн асуулт асууя.

Л.Мөнхбаясгалан: Шинэчилсэн найруулга бол сайн болсон. Энэ нөгөө ойгоо хамгаалдаг тийм үзэл баримтлалаас ийм төвтэй үзэл баримтлалаас эдийн засгийн эргэлтэд оруулах, тэгээд уур амьсгалын өөрчлөлтийн бодлогодоо давхар тулгуурлаад уялдуулаад явчхаж байгаа юм л даа. Тэгэхээрээ их сайн гэдгийг нь хэлэх ёстой.

Энэ хуулийн би нэг юм тодруулчихъя гэж бодоод байгаа юм. Хуулийн төслийн 35 дугаар зүйл байна. Ойн дагалдах баялгийг үйлдвэрлэлийн зориулалтаар түүж бэлтгэх гэдгийг зохицуулсан байгаа юм л даа. Тэгээд энд ойн дагалдах баялгийг үйлдвэрлэлийн зориулалтаар бэлтгэх гэдэг нь угтаа ойн мэргэжлийн үйл ажиллагаа биш, харин ойн дагалдах баялгийг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах тийм нэг төрлийн үйлдвэрлэл гэж ойлгож байна. Тэгэхээр энэ нь экологийн тэнцвэрт байдлаа аль болохоор алдагдуулахгүйгээр хөрс болон уст давхаргыг гэмтээхгүйгээр байх зохицуулалт нь байгаа юу?

Б.Бейсен: Бат-Эрдэнэ гишүүн хариулъя.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Мөнхбаясгалан гишүүн маань өргөн барьсан гишүүдийн нэг. Ялангуяа устай холбоотой харилцаан дээр нэлээн олон саналуудыг хэлдэг, ярьдаг. Бид ойн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага болон байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гэх мэтчилэн тодорхой хэмжээний эрх, үүргийн хуваарилалтуудыг бид хийж өгч байгаа. Тухайлбал 35.2-т "Ойн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага ойн дагалдах баялгийг түүж бэлтгэхэд хязгаарлалт тогтоож болно" гэдэг заалт байгаа. Энэ заалт өөрөө юу гэсэн үг вэ гэхээр, тухайн устай холбоотой харилцаан дээр мөн орж ирж байгаа. Ямар тохиолдолд бид ойн дагалдах баялгийг хязгаарлаж болох вэ? Энэ өөрөө байгалийн нөөц гэдэг дотор ус орж байгаа учраас тодорхой хэмжээнд

усны нөөцийн ашиглалтын бүх хэлбэрийг хуульд тодорхой хэмжээнд ойн дагалдах баялгийг ашиглахтай холбоотой тусгай зөвшөөрлийн харилцаан дотор нь оруулж өгсөн учраас энэ дээр бид тодорхой хэмжээнд хязгаарлалтуудыг 1 дүгээрт хийж өгөх, 2 дугаарт зарчмыг нь зааж өгч байгаа.

Тэр 35.5-д боловсруулаагүй ойн дагалдах баялгийг экспортлохыг шууд хориглож өгч байгаа, энэ тодорхой хэмжээний хязгаарлалтад орно. 35.6-д дагалдах баялгийн дунд ургацын жилд зөвхөн ахуйн зориулалтаар, их ургацын жилд аль ч зориулалтаар ашиглахыг зөвшөөрнө гэдэг ч юм уу ингээд тодорхой хэмжээний харилцааны асуудлуудыг бид оруулж өгсөн гэдгийг хэлье.

Б.Бейсен: Ганбаатар гишүүн, дараа нь үг байгаа юм байна, үг дээр хэлэх юм байна. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Хууль санаачлагчийн танилцуулгатай холбогдуулан санал, үг хэлэх хүн байна уу, нэрсээ өгнө үү гишүүд? Ганбаатар гишүүнээр тасаллаа. Ганбаатар гишүүн.

Г.Ганбаатар: Энэ хуулийн төслийн 22.6 дээр "харь болон устсан унаган зүйлийн мод, мод сөөгийн тарьц, суулгацыг судалгааны зориулалтаар импортлох хуулийн этгээдэд тавигдах шаардлага" гээд байгаа байхгүй юу. Ер нь яах вэ бид гадагшаа яваад туршлага судалж явсан. Энэ харь ургамал гэдэг юм уу, харийн мод чинь тухайн орон нутгийн газрыг их дарангуйлдаг тийм айхтар хүчтэй моднууд байдаг юм байна. Би мэргэжлийн хүн биш учраас, тэгээд энэ чинь нэг улс бүр тэр чигээрээ нөгөө нарсан ойн дарангуйлалд орж байсан гээд тэгж ярьж байсан байхгүй юу. Тэгээд энэ чиглэлийн юмнууд дээр 1 дүгээрт их сайн анхаарах ёстой юм шиг байна лээ. Тэгээд яах вэ, энэ 3, 4-хөн зүйл байна л даа.

Дээрээс нь сая энэ амралын өдрөөр бид говийн бүс рүү, хилийн өмнөд сумдаар 2 хоног хагас, бүтэн сайнаар тэнд ингээд бүр говийн унаган модыг бүр 1800-аад оны үед нутгийн нэг сайхан сэтгэлтэй улсууд нутагтаа сайхан зүйл хийе гээд нэг ийм тооройн ой мод байгуулсан байна лээ. Тэр Дэрсэн усны тооройн төгөл гэдэг юм, Монгол Улсын хамгийн том төгөл л юм билээ. Гэтэл тэнд тухайн үедээ тариалчихсан болохоос биш бид хангайн ой мод хамгаалах тухай л яриад байгаа болохоос яг дотор нь ороод үзэж байхад тэнд тэр говийн ойг ч гэсэн хамгаалах асуудал гарчихсан байгаа байхгүй юу. Тухайн үедээ 300-аад жилийн өмнө нутгийн улсууд л нутагтаа буян үйлдье гээд нэг тийм тарьсан ой мод байгаа юм. Тэгээд энэ чиглэлийн юмнуудыг нь нэмж энэ хэлэлцүүлгийн явцад оруулж өгвөл их зүгээр юм шиг санагдсан шүү. Баярлалаа.

Б.Бейсен: Гишүүд санал, үг хэлж дууслаа. Санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтад бэлдээрэй. Ойн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал 62.5 хувиар дэмжигдлээ. Мөнхбаясгалан гишүүн дэмжсэнээр авъя.

Хамт өргөн мэдүүлсэн Ойн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал 68.8 хувиар дэмжигдлээ.

Тариалангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал 68.8 хувиар дэмжигдлээ.

Ойн тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал 68.8 хувиар дэмжигдлээ.

Ойн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай УИХ-ын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал 62.5 хувиар дэмжигдлээ. Энэ асуудлыг хэлэлцэж дууслаа. Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулах гишүүнийг Мөнхбаясгалан гишүүн танилцуулъя. Гомбын Ганбаатар гишүүн танилцуулъя.

19:11 цаг

Гурав. “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2026.03.17-ны өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Дараагийн хэлэлцэх асуудалд оръё. Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай УИХ-ын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулъя. Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай УИХ-ын тогтоолын төслийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдааны хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий Ажлын хэсэг Байнгын хорооны тогтоолоор байгуулагдан ажилласан. Төслийн анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх танилцуулгыг Ажлын хэсгийн ахлагч, УИХ-ын гишүүн Б.Уянга танилцуулна. Уянга гишүүний микрофоныг өгье.

Б.Уянга: Монгол Улсын ЗГ-аас 2026 оны 3 дугаар сарын 17-ны өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай УИХ-ын тогтоолын төслийн хэлэлцэх эсэхийг БОХХАА-н байнгын хорооны 2026 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн, УИХ-ын чуулганы 2026 оны 4 дүгээр сарын 16-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр тус байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Байнгын хороо Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай УИХ-ын тогтоолын төслийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах үүрэг бүхий Ажлын хэсгийг Байнгын хорооны 2026 оны 01 тоот тогтоолоор байгуулсан бөгөөд Ажлын хэсгийн ахлагчаар УИХ-ын гишүүн Б.Уянга, бүрэлдэхүүнд УИХ-ын гишүүн Н.Алтаншагай, Б.Бейсен, М.Ганхүлэг, Ж.Чинбүрэн, А.Ундраа ажиллалаа.

Энэ хугацаанд Хэлний бодлогын үндэсний зөвлөлөөс Баян-Өлгий, Сүхбаатар аймгийн нутаг дэвсгэрт хамаарах өөр хэл дээр батлагдсан газар зүйн нэрийн жагсаалтыг шинээр батлах, өөрчлөхтэй холбогдуулан газар зүйн нэрийн Монгол кирилл үсгийн латин хөрвүүлгийн стандарт, зарим газар зүйн нэрийн Монгол хэлний дүрмийн алдаатай эсэх талаарх лавлагаа, мэдээллийг авч ажиллалаа. Мөн Ажлын хэсгийн ахлагчаас Баян-Өлгий аймагт хамаарах зарим газар зүйн нэрийн талаар Монголын Тувачуудын нийгэмлэгээс ирүүлсэн саналтай холбогдуулан тус

нийгэмлэгийн төлөөлөлтэй уулзаж, санал солилцон, холбогдох тайлбар, мэдээллийг өгсөн болно.

Ажлын хэсэг нийт 3 удаа хуралдаж, тогтоолын төсөлтэй холбогдуулан дараах саналыг гаргасныг Байнгын хороонд танилцуулах нь зүйтэй гэж үзлээ. Үүнд, тогтоолын төслийн 1, 2 дахь заалтын зарим дэвсгэр нэрд хамаарах газар зүйн нэрийг нийцүүлж, холбогдох засварыг хийх. Мөн тогтоолоор дараах асуудлыг ЗГ-т даалгах нь зүйтэй гэж үзлээ. Үүнд энэ тогтоолоор баталсан газар зүйн нэрийг геодези, зураг зүйн мэдээллийн улсын нэгдсэн санд бүртгэх, МУИХ-аас баталсан газар зүйн нэрийг батлагдсан стандартад нийцүүлэн латин үсгээр галиглан хэрэглэх, газар зүйн нэрийг судлах, сурталчлах, хамгаалах, мөрдүүлэх, цахим системээр дамжуулан хэрэглээнд нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах, Баян-Өлгий аймгийн нутаг дэвсгэрт хамаарах газар зүйн нэрийн тодотголыг хийж, сумдын хилийн цэсийг албан ёсны газар зүйн нэрийн дагуу шинэчлэн холбогдох шийдвэрийн төслийг боловсруулж, 2027 оны намрын ээлжит чуулганы хугацаанд багтаан УИХ-д өргөн мэдүүлэх, төслийн нэр, томъёог жигдлэх, Хууль тогтоомжийн тухай хуульд нийцүүлэн тогтоолын заалтын дугаарыг нийцүүлж өөрчлөн, бүтэц, найруулга, латин хөрвүүлэгт холбогдох хууль зүйн техникийн засварыг хийлээ.

Эдгээр өөрчлөлтүүдтэй холбогдуулан тогтоолын төслийн талаар гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг бэлтгэн та бүхэнд хүргүүлсэн болно. Ажлын хэсгийн бэлтгэсэн танилцуулга, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү. Анхаарал хандуулсанд баярлалаа.

Б.Бейсен: Уянга гишүүнд баярлалаа. Ажлын хэсгийг танилцуулъя. А.Энхманлай Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын дарга, Д.Мөнхцэцэг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын Геодези, зураг зүйн хэлтсийн дарга, Ц.Орлого Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын Геодези, зураг зүйн хэлтсийн мэргэжилтэн, Ц.Цэрэндорж Шинжлэх ухааны академи /ШУА/-ийн Нийгмийн шинжлэх ухаан хариуцсан дэд ерөнхийлөгч, шинжлэх ухааны доктор, академич, Н.Нарангэрэл Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн Ажлын албаны дарга, доктор, Ц.Наранцацрал ШУА-ийн Газар зүй, геоэкологийн хүрээлэнгийн Газар зүйн мэдээллийн систем, зураг зүйн салбарын дарга, Э.Равдан эмирит профессор, Монгол Улсын гавьяат багш, П.Энхжаргал МУИС-ийн Ази судлалын тэнхимийн профессор, О.Самбуудорж ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн Хэл шинжлэлийн салбарын эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, доктор, Д.Оюунчимэг Монгол Улсын гавьяат барилгачин, зөвлөх инженер, О.Сарангэрэл "Сондуултын зам" компанийн ерөнхий менежер.

МУИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-д Байнгын хороо хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэнэ гэж заасны дагуу хэлэлцье. Гишүүд та бүхэн тухайн зүйлтэй холбогдуулан асуулт асууж болно. Асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Тогтоолын төслийн 1 дүгээр заалттай холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Байхгүй байна. Саналын томъёоллыг нь өгөөрэй манайхан. Тараачихсан. Ажлын хэсгээс 2 санал ирүүлсэн байгаа, гишүүд санал хураалтад бэлдээрэй. Тогтоолын төслийн 1 дэх заалтын, гишүүд санал хураалтад бэлдээрэй. Бэлдсэн байна уу, хэдэн хүн бэлдсэн байна вэ? Хүрэх байх.

1.Тогтоолын төслийн 1 дэх заалтын ““Гатлага”,” гэсний дараах ““Говь”,” гэснийг, ““Толгой”,” гэсний дараах ““Тохой”,” гэснийг, ““Хад”,” гэсний дараах ““Харгайт”,” гэснийг, ““Цав”,” гэсний дараах “Чулуу” гэсэн дэвсгэр нэрийг хасаж,

эдгээрт хамаарах газар зүйн нэрийг “Салаа”, “Бөөрөг”, “Хаалга”, “Хөтөл”, “Уул”, “Товог”, “Бэлчир”, “Даваа”, “Тал” хэсэгт тус тус харгалзуулж нэмэх. Санал хураалт. Санал 62.5 хувиар дэмжигдлээ.

2.Тогтоолын төслийн 1 дэх заалтын “Уул” хэсгийн “Арал Толгой уул, Aral Tolgoi uul, Баян-Өлгий, Сагсай” гэснийг “Арал Толгой уул, Aral Tolgoi uul, Баян-Өлгий, Алтай” гэж өөрчлөх. Энэ дээр нэг ийм юм байгаа. Энэ яг Алтай сум дээр яг Арал толгой уул яг юун дээр нь карт дээр нь байна уу. Энийг Сагсайтай андуураад яасан чинь Алтайд бас байдаг юм байна. Би бас сая асуух гээд яагаагүй. Санал хураалт. Санал 62.5 хувиар дэмжигдлээ.

Тогтоолын төслийн 2 дугаар заалттай холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Асуулт асуух гишүүн байхгүй байна. Ажлын хэсгээс нэг санал ирүүлсэн байгаа.

3.Тогтоолын төслийн 2 дахь заалтын “Ам” гэсний дараа ““Ар”,” гэж, “Шанд” гэсний дараа ““Ширээ”,” гэж тус тус нэмэх. Санал хураалт. Санал 68.8 хувиар дэмжигдлээ.

Тогтоолын төслийн 3 дугаар заалттай холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Ганбаатар гишүүн, Ганхүлэг гишүүнээр тасаллаа. Гомбын Ганбаатар гишүүн, Ганхүлэг ирцээрээ орсон байна. Ганхүлэг гишүүн асуулт асууя.

М.Ганхүлэг: Протоколд тэмдэглүүлээд би ажлын хэсэгт нь ажилласан юм. Асуулт гэхээсээ илүүтэй, энэ ажлын хэсэг дээр гол яригдсан, нэг гишүүний зүгээс оруулсан 2 санал байгаа юм. Хамгийн эхнийх нь болохоор энэ латин үсэг, энэ галиглахтай холбогдолтой энэ хэрэглээг нэгдсэн байдлаар бид нэг тийм зохион байгуулалтад оруулаад хуульчлаад өгчихмөөр юм билээ. Тэгэхгүй ингээд галигууд нь өөр, өөр байдлаар орж ирдэг ийм нийтлэг асуудал манай ажлын хэсэг дээр яригдсан. Тэгэхээр цаашдаа тогтоолын төслийн хэрэгжилт дээр энийг нэгдсэн байдлаар шийдэх чиглэлийн агуулгыг оруулж өгсөн байгаа. Тэгээд энэ дээрээ гол анхаарлаа хандуулж та бүхэн маань ажиллаарай. Энэ чиглэлээр нэмэлт тайлбар хэлэх шаардлагатай бол нэмээд тайлбар хэлээрэй гэдгийг хэлье.

2-т бид тодорхой нэр усаа ингээд баталчихдаг. Гэхдээ энэ нь яг өөрөө хэрэглээн дээрээ нэвтрэхгүй байгаад байгаа юм. Ялангуяа энэ Google Maps байдаг юм уу, үндсэндээ хүмүүсийн өдөр тутамдаа хэрэглэж байгаа энэ цахим хэрэгслүүд дээр ерөөсөө яг бидний баталсан нэршлээрээ хөрвөж орох энэ процесс нь өөрөө аягүй удаан, хүмүүс хэрэглэх тэр байдал нь нэлээн тийм төвөгтэй ийм байдалтай байгаа. Тэгэхээр ажлын хэсэгт танилцуулж байгаа байдлаас харахад бол өөрсдөө энэ төрлийн цахим систем хөгжүүлэх тухай агуулгууд ярьж байсан. Одоо байгаа болон энэ чиглэлийн энэ хэрэглээг сайжруулах чиглэл дээр та бүхэн маань цаашдаа илүү анхаарлаа хандуулаарай. Нэмэлт гишүүдэд болон олон нийтэд танилцуулах санал байвал та бүхэн маань асуулт гэж ойлгоод хариулаарай гэдгийг протоколд тэмдэглүүлээд энэ 2 саналыг дурдъя.

Б.Бейсен: Санал хэлсэн үү? Энхманлай дарга тодруулж, индрийн микрофон өгье.

А.Энхманлай: Ганхүлэг гишүүний асуултад хариулъя. Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын дарга Энхманлай. Ганхүлэг

гишүүнээс ажлын хэсэг дээр санал гаргасан байгаа. Энэ санал нь 1 дүгээрт, энэ газар зүйн нэр батлагдаад, тэгээд дараа нь стандарт буюу Монгол хэлнээс латин хэл рүү хөрвүүлэх ийм галигийн стандарт өөрчлөгдсөн тохиолдол бүрд УИХ дээр орж ирж батлах ийм зайлшгүй шаардлагууд гарч ирэх болж байна. Тийм учраас энийг стандарт өөрчлөгдсөн тухай бүрд нь латин зөв тэр стандартынх нь дагуу галиглаад, хэрэглээд явдаг ийм тогтолцоо руу оруулъя гэдэг ийм санал гаргасан. Энэ саналын дагуу бид бүхэн энэ УИХ-ын тогтоолын төсөл дээр өөрчлөлт оруулж, ийм латин үсгийн галиг өөрчлөгдсөн тохиолдолд, стандарт өөрчлөгдсөн тухай бүр энэ шинэ стандартынх нь дагуу галиглан хэрэглэж байя гэсэн ийм тогтоолын төсөлд өөрчлөлт оруулах ийм саналыг хүлээж авсан байгаа.

2-т энэ газар зүйн нэрийг хэрэглээнд нэвтрүүлэхтэй холбоотой Google программ, иргэдийн байнгын хэрэглэдэг энэ программууд дээр газар зүйн нэртэй холбоотой мэдээллийг хэрэглээнд гаргах үүднээс бид бүхэн энэ газар зүйн нэрийн мэдээллийн системийг шинээр хөгжүүлж байгаа. Тэгээд энэ систем дээр бүх шинээр батлагдсан газар зүйн нэрснүүд маань бүгд бүртгэгдэж орно. Ингээд координаттай байна. Мөн иргэдийн түгээмэл хэрэглэдэг Google программ дээр энэ газар зүйн нэрийг дэвсэж хэрэглэхээр, ийм давхцуулж хэрэглэж болохоор ийм системийг хөгжүүлж ингэж ашиглалтад гаргаж байгаа юм. Тийм учраас энэ хэрэглээний хувьд илүү давуу талтай болж байгаа гэсэн үг. Баярлалаа.

Б.Бейсен: Гомбын Ганбаатар гишүүн асуулт асууя.

Г.Ганбаатар: Би энэ тогтоолын төслийг чинь ер нь бол хуучин Баян-Өлгий аймгийн нутаг дэвсгэрт хамаарч байсан газар зүйн нэр томъёоллыг л тодотгож байгаа л гэж ойлгож байна шүү дээ. Тэгээд тийм их хугацаа орох эд үү? Ингээд энэ хилийн цэсийг албажуулаад, энэ шийдвэрийнхээ төслийг 2027 оны намрын ээлжит чуулганаар гээд, энэ хаврын ээлжит чуулганд орж амжихгүй билүү? Энийг бол нэг тийм их хугацаа орно гэж ерөөсөө бодохгүй байгаа шүү дээ. Хэн хариулах вэ?

Б.Бейсен: Уянга гишүүн хариулъя.

Б.Уянга: Ганбаатар гишүүний асуултад хариулъя. Газар зүйн нэрийг тогтоох процесс нь Геодези, зураг зүйн тухай хуулиар явдаг юм байна. Тэгээд батлах субъект нь УИХ байдаг. Тэгээд ингээд тогтоол нь хамгийн анх 2003 онд батлагдсан дээр гадаад хэлээр нэрлэгдсэн байсан нэрийг Монгол хэл рүү хөрвүүлээд, тэгээд нэмж нэрлэж байгаа хэдэн нэрснүүдээ оруулаад ингээд тогтоолын хавсралтад өөрчлөлт орох байдлаар өнөөдөр бүгдээрээ хэлэлцэж байна. Тэгээд ерөнхий процесс нь Геодези, зураг зүйн тухай хуульд сууснаараа бол ажлын хэсэг гараад, тухайн нутаг дэвсгэртээ очоод ажилладаг юм байна. Тэгээд хээрийн ажлаар нэрийг нь баталгаажуулаад, нутгийн иргэдтэй уулзаад ингэж явсаар байгаад тухайн сумаас нь аймаг руугаа ИТХ-даа нэрснүүдээ явуулаад, дараа нь ИТХ нь бүх аймгийнхаа хэмжээний нэрснүүдээ авч үзээд, тэгээд тэр нь өөрсдөө тогтоолоороо баталгаажуулаад, тэгээд Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газарт ирүүлснийх нь дараа Засгаар ороод, дараа нь Засгаас Их Хурал руу өргөн баригдсан байгаа процесс. Тэгэхээр 2022, 2023 онд хийгдсэн ажлууд нь өнөөдөр ингээд баригдаад 3 сард, сая энэ оны 3 сард өргөн баригдаад бид тогтоолын хавсралтад нь одоо өөрчлөлт оруулж байгаа ийм л процесс юм байна.

Тэгээд 2027 ондоо багтаагаад ер нь зарим аймгуудад, бүхэлдээ энэ удаад Баян-Өлгий аймгийн бүх сумд хамрагдаж чадаагүй. Тэгээд Баян-Өлгий аймаг бүх

сумдынхаа холбогдох газар зүйн нэрийг нь ажлын хэсэг гаргаж ажиллаад, тэгээд дахиад ингээд процесс нь газар зохион байгуулалт, Газар зүй, геодези, зураг зүйн тухай хуулиар явахаар хугацаа орохоор л юм билээ. Тэгээд анх ажлын хэсгийг ахалж ажиллахад энэ процессыг нь сайн мэдэхгүй байсны хүрээнд нэлээн тодруулж, лавлаж асуусан. Тэгээд энэ газар зүйн нэрийг оноож Монгол хэл рүү хөрвүүлэх явцад Монгол Тувачуудын нийгэмлэгээс ажлын хэсэгт хандаж уулзалтыг зохион байгуулсан байгаа. Тэгээд яг энэ орчуулж хэрэглэх дээр яг тухайн нийгэмлэгүүдтэй нь хамтарч ажиллах ажлууд их гардаг юм байна. Тэгээд энэ ажлууд нь гүйцээгдээд хийгдэхэд 2027 ондоо багтаагаад л орж ирэх юм байна гэдэг үүднээс тогтоолын төсөлд найруулга орсон байгаа юм.

Б.Бейсен: Ганбаатар гишүүн энэ юутай холбоотой Сүхбаатар аймаг, Баян-Өлгий аймаг, тэгээд нөгөө Цэнгэл сумын Тувачууд нийтдээ 13 санал ирүүлсэн. Тэгээд тэр нийгэмлэгийн төлөөлөлтэй манай ажлын хэсгийнхэн бүгд, дарга энэ тэр уулзсан. Тэгээд тэндээсээ дахин саналын зарим нь ижил саналтай байна, зарим нь орчуулга нь ижил гэх мэт утга ойролцоо тийм үг байдаг юм байна л даа. Тэрийг бүгдийг нь тохироод ойлгуулсан, бас 4 санал байна, тэрийг дараа ярьж гэсэн байна, тэрний дагуу ийм яаж байгаа байх гэж бодож байна. Гишүүд асуулт асууж дууслаа. Тогтоолын төслийн 3 дугаар заалттай холбогдуулан асуулт асууж дуусаад, одоо ажлын хэсгээс нэг санал ирүүлсэн байгаа.

3.Тогтоолын төслийн 3 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3.Монгол Улсын Засгийн газар /Н.Учрал/-т даалгах нь:

1/Энэ тогтоолоор баталсан газар зүйн нэрийг геодези, зураг зүйн мэдээллийн улсын нэгдсэн санд бүртгэх;

2/Монгол Улсын Их Хурлаас баталсан газар зүйн нэрийг батлагдсан стандартад нийцүүлэн латин үсэгт галиглан хэрэглэх, газар зүйн нэрийг судлах, сурталчлах, хамгаалах, мөрдүүлэх, газар зүйн нэрийн цахим системээр дамжуулан хэрэглээнд нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах;

3/Баян-Өлгий аймгийн нутаг дэвсгэрт хамаарах газар зүйн нэрийн тодотголыг хийж, сумдын хилийн цэсийг албан ёсны газар зүйн нэрийн дагуу шинэчлэн холбогдох шийдвэрийн төслийг боловсруулж, 2027 оны Намрын ээлжит чуулганы хугацаанд багтаан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх. Санал хураалт. Санал 68.8 хувиар дэмжигдлээ.

Тогтоолын төслийн 4 дүгээр заалттай холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Асуулт асуух гишүүд байхгүй байна. Ажлын хэсгээс 3 санал ирүүлсэн байгаа.

5.Тогтоолын төсөлд доор дурдсан 4 дэх заалт нэмэх:

“4.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо /Б.Бейсен/-д даалгасугай.” Санал хураалт. Санал 68.8 хувиар дэмжигдлээ.

6.Хууль тогтоомжийн тухай хуульд нийцүүлэн тогтоолын төслийн 1 дэх заалтыг 2 дахь заалт болгон өөрчлөх. Санал хураалт. Санал 68.8 хувиар дэмжигдлээ.

7.Төслийн нэр томъёог жигдлэх, заалтын дугаарыг нийцүүлж өөрчлөх, бүтэц найруулга, латин хөрвүүлэгт холбогдох хууль зүйн техникийн засварыг хийх. Санал хураалт. Санал 68.8 хувиар дэмжигдлээ. Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай УИХ-ын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа. Тогтоолын төслийн анхны хэлэлцүүлэг явагдсан талаар БОХХАА-н байнгын хорооноос гаргах санал, дүгнэлтийг УИХ-ын гишүүн Б.Уянга чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулна. Ажлын хэсэгт баярлалаа.

19.31 цаг

Дөрөв.Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай нарын 10 гишүүн 2025.06.19 -ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Дараагийн хэлэлцэх асуудалд оръё. Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна. Эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх танилцуулгыг Ажлын хэсгийн ахлагч, УИХ-ын гишүүн Тогтмолын Мөнхсайхан танилцуулна. Мөнхсайхан гишүүний микрофоныг өгье.

Т.Мөнхсайхан: Байнгын хорооны гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе. УИХ-ын гишүүн М.Мандхай нарын гишүүдээс 2025 оны 6 дугаар сарын 19-ний өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг 2026 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр БОХХАА-н байнгын хороонд шилжүүлсэн.

Төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий Ажлын хэсэг 2026 оны 6 дугаар сарын 15-ны өдөр хуралдаж, МУИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42.2.3-т заасныг баримтлан хуулийн төслийн заалтаар дахин нэг санал хураах шаардлагатай гэж үзсэн болно. Нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналуудыг төсөлд нэмж тусган, төслийн агуулга, бодлого, зарчмыг алдагдуулахгүйгээр үг хэллэг, дэс дараалал, бүтцийн шинжтэй засварыг хийж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл болон эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх танилцуулга, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал хандуулсан явдалд баярлалаа.

Б.Бейсен: Мөнхсайхан гишүүнд баярлалаа. Ажлын хэсгийг танилцуулъя. Д.Довчинсүрэн ХХААХҮЯ-ны Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, Ч.Раднаабазар ХХААХҮЯ-ны Хуулийн хэлтсийн дарга, О.Онон ХХААХҮЯ-ны Бодлого, төлөвлөлтийн газрын салбарын нэгдсэн төлөвлөлт хариуцсан ахлах шинжээч, Х.Цэрэнханд ХХААХҮЯ-ны Бодлого, төлөвлөлтийн газрын салбарын нэгдсэн төлөвлөлт хариуцсан ахлах мэргэжилтэн, Я.Хишигт Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн төслийн зөвлөх.

Ажлын хэсгийн танилцуулгатай холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Асуулт асуух гишүүд байхгүй байна. Санал хураалт явуулна. Санал хураалтад бэлдээрэй. МУИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-т заасны дагуу нэг санал хураана. Саналыг уншиж танилцуулъя.

Төслийн 4 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4 дүгээр зүйл. Хүнсний тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийн “эрхлэхтэй” гэснийг “эрхлэх, түүнд хяналт тавихтай” гэж, 3 дугаар зүйлийн 3.1.8 дахь заалтын “үйлдвэрлэсэн” гэснийг “үйлдвэрлэсэн хүнс” гэж, “хийгдсэнийг” гэснийг “хийгдсэн хүнсийг” гэж, 4 дүгээр зүйлийн гарчгийн “зарчим” гэснийг “зарчим, бодлогын чиглэл” гэж, Хоёрдугаар бүлгийн гарчгийн “ХАНГАМЖ” гэснийг “ХАНГАМЖ, ХҮРТЭЭМЖ” гэж, 10 дугаар зүйлийн 10.1.5 дахь заалтын “боловсруулах болон нийтийн хоолны үйлдвэрлэл” гэснийг “хүнсний боловсруулах болон хоол үйлдвэрлэл, үйлчилгээ” гэж, 13 дугаар зүйлийн 13.1.1 дэх заалтын “шим тэжээллэг байдалд” гэснийг “шим тэжээллэг байдал, хуурамч хүнсний бүтээгдэхүүнд” гэж, 13.1.4 дэх заалтын “энэ хуулийн 6.8-д заасан” гэснийг “энэ хуулийн 5¹ дүгээр зүйлд заасан” гэж тус тус өөрчлөн найруулсугай.” Санал хураалт. Санал 62.5 хувиар дэмжигдлээ. Мөнхбат гишүүн зарчмын зөрүүтэй санал гаргах гэж байна, горимын санал.

Ц.Мөнхбат: Саяын санал хураалтыг хүчингүй болгож өгнө үү. Миний техникийн саатал гарах шиг боллоо.

Б.Бейсен: Мөнхбат гишүүний гаргасан горимын саналын дагуу саяын санал хураалтыг хүчингүй болгох санал хураалт явуулъя. Санал хураалт. 68.8 хувиар дэмжигдлээ. Саяын санал хүчингүй болсон учраас дахин санал хураалт явуулъя. Санал хураалт. 68.8 санал хувиар дэмжигдлээ. Түрүүн уншсан саналыг дэмжье гэдгээр санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал 68.8 хувиар дэмжигдлээ. Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулж дууслаа. Төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулсан талаарх БОХХАА-н байнгын хорооноос гаргах танилцуулгыг УИХ-ын гишүүн Т.Мөнхсайхан чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулна. Ажлын хэсэгт баярлалаа.

19.38 цаг

Тав.Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Хөдөө аж ахуйн тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/

Дараагийн хэлэлцэх асуудалд оръё. Одоо удахгүй, ганцхан асуудал байгаа. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна. Хөдөө аж ахуйн тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан байгаа. Төслийн анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх танилцуулгыг Ажлын хэсгийн ахлагч, УИХ-ын гишүүн Наранбаатар танилцуулна.

Н.Наранбаатар: УИХ-ын гишүүн Мандхай нарын 10 гишүүнээс 2025 оны 6 дугаар сарын 19-ний өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн Хөдөө аж ахуйн тухай хуулийн төсөлд ХАА-г тогтвортой хөгжүүлэх зорилгоор улсын хэмжээнд дунд хугацааны

хөгжлийн зорилтот хөтөлбөртэй байх асуудал туссан боловч холбогдох хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хууль санаачлагч өргөн мэдүүлээгүй болно.

ХАА-н тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг 2026 оны 6 дугаар сарын 5-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар явуулах үед БОХХАА-н байнгын хорооноос гаргасан Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах саналыг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно. Иймээс МУИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.5 дахь хэсэгт "анхдагч болон хуулийн шинэчилсэн найруулгын төслийн анхны хэлэлцүүлгээр санал хурааж шийдвэрлэсэн зарчмын зөрүүтэй саналтай холбогдуулан Байнгын хороо төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэхдээ хууль тогтоомжийн хоорондын уялдааг хангах зорилгоор холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулан хамтад нь хэлэлцүүлж болно." гэж заасныг үндэслэн Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5 дахь хэсэгт "6.5.9.Хөдөө аж ахуйн хөгжлийн зорилтот хөтөлбөр" гэсэн заалт нэмэх хуулийн төслийг боловсрууллаа.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ, ХАА-н тухай хуулийн төсөлтэй холбогдуулан Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү. УИХ-ын гишүүн, Ажлын хэсгийн ахлагч Бат-Эрдэнэ.

Б.Бейсен: Нанзадын Наранбаатар гишүүнд баярлалаа. Ажлын хэсгийг танилцуулъя. ХХААХҮЯ-наас Ч.Раднаабазар ХХААХҮЯ-ны Хуулийн хэлтсийн дарга, Ц.Мөнхнасан ХХААХҮЯ-ны Бодлого, төлөвлөлтийн газрын шинжээч. МУИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-д Байнгын хороо хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэнэ гэж заасны дагуу хэлэлцье. Гишүүд та бүхэн тухайн зүйлтэй холбогдуулан асуулт асууж болно. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Асуулт асуух гишүүд байхгүй байна. Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Асуулт асуух гишүүн байхгүй байна. Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа. Наранбаатар гишүүн горимын санал гаргах юм байна. Наранбаатар гишүүний микрофоныг өгье.

Н.Наранбаатар: Хуулийн төслийн талаар зарчмын зөрүүтэй саналын томъёолол гараагүй тул хуулийн төслийг анхны хэлэлцүүлгээс эцэслэн батлах үе шат руу шилжүүлэх горимын саналыг нэгдсэн хуралдаанд гаргаж байна.

Б.Бейсен: Наранбаатар гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулъя. Санал хураалтад бэлдээрэй гишүүд. Горимын саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Горимын санал 68.8 хувиар дэмжигдлээ. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооноос гаргах санал, дүгнэлтийг Ж.Бат-Эрдэнэ гишүүн танилцуулна.

19.44 цаг

Дараагийн асуудал Хянан шалгах түр хорооны асуудлыг хойшлуулсан байгаа. Тийм учраас хэлэлцэх асуудал байхгүй. Байнгын хорооны өнөөдрийн

хуралдаанд оролцсон гишүүд, ажлын хэсгийнхэнд баярлалаа. Өнөөдрийн хуралдаан дууслаа.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА